



НҮБХХ нь мэдлэг, туршлага, нөөцийг холбож, улс орнуудын
өөрчлөлтийг олон нийтэд хүргэх замаар илүү сайн сайхан амьдралыг
цогцлон байгуулахад хүмүүст туслах зорилго бүхий НҮБ-ын дэлхий
нийтийн хөгжлийн сүлжээ юм.

АГУУЛГА

Ерөнхий редакторын зурvas2

Содовсүрэнгийн Нарангэрэл
Эрх зүйн толь бичиг шуврал бүтээл:
Шинжлэх ухааны үнэ цэнэ3

Цэрэнжавын Алтанцэцэг
Хүүхэд хамгаалал-Гадаадын иргэн Монгол Улсын харьяат
хүүхдийг үрчлэн авах асуудлын эрх зүйн зохицуулалт13

Тэрбишийн Амгалан
Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтуудыг
жендэрийн өншгөөс харах нь26

Баастын Болд-Эрдэнэ
Мэдээлэл түгээх эрх, хариуцлагын асуудал45

Жүрмэдийн Занаа
Тэгш эрх ба жендэрийн тэгш байдлын тухай асуудлууд50

Доржийн Мөнхөө
Хүнд ээлтэй бодлогыг тунхаглахаас эмэгтэйчүүдийн
оролцоог дэмжиж баталгаажуулах нь60

Пүрэвийн Оюунчимэг
Эмэгтэйчүүд, охидыг хил дамнуулан худалдаалах
гэмт хэргийн талаархи ойлголтууд ба түүнд нөлөөлөх
хүчин зүйлсийн талаар63

Нямдолгорын Сампилноров
Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэл урам хайлрдай67

Дашаагийн Цэдэнбал
Хүний хөгжил ба жендэрийн ойлголт, жендэрийн чиг хандлагыг
хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах тухай72

ЕРӨНХИЙ РЕДАКТОРЫН ЗУРВАС

Эрхэм уншигчил аа!

“Хүний эрх” сэтгүүлийн 2008 оны эхний дугаарыг хүлээн авна уу.


Манай хуулийн салбарт 2 баходам үйл явдал боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 54 дүгээр зарлигаар манай улсад хуулийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, иргэний хууль тогтоомжийг боловсронгуй болгон иргэний шүүн таслах ажиллагааг шинэ шатанд гаргах, зах зээлийн эдийн засгийн харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлэх, Үндсэн хуулийг хамгаалах болон оюуны өмчийн тогтолцоог боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж Оюуны өмчийн газрын дарга, МУИС-ийн багш Н.Чинбатад Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээлээ.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, академич С.Нарангэрэл 2008 оны 2 дугаар сарын 29-ний өдөр Хууль зүйн үндэсний төвөөс уламжлал болгон зохион байгуулдаг Хүндэтгэлийн цуврал лекцийн үйл ажиллагаанд “Эрх зүйн толь бичиг цуврал бүтээл: шинжлэх ухааны үнэ цэнэ” сэдэвт лекц үншсэн Та бүгдэд толилуулж байна.

Гавьяат хуульч Н.Чинбат, Академич С.Нарангэрэл нарт энэхүү тэмдэглэлт үйл явдлыг тохиолдуулан баяр хүргэхийн ялдамд шавийнх нь хувьд хоёр багшдаа аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг чин сэтгэлээсээ хүсэн ерөө!

Хүндэтгэсэн,
Д.Солонго



Монгол Улсын Хүний эрхийн
үндэсний комиссын дарга

Сэтгүүлийн ерөнхий редактор



СОДОВСҮРЭНГИЙН НАРАНГЭРЭЛ

Монгол Улсын Шинжлэх ухааны академийн гишүүн, академич, доктор, профессор, Япон Улсын Эзэн хааны Нагояагийн их сургуулийн хүндэт доктор.

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны зэрэг хамгаалуулах эрдмийн зөвлөлийн дарга, Түүхийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, МУИС-ийн удирдах зөвлөлийн гишүүн.

Академич С.Нарангэрэл

ЭРХ ЗҮЙН ТОЛЬ БИЧИГ ЦУВРАЛ БҮТЭЭЛ: шинжлэх ухааны үнэ цэнэ

2008-02-29

ТОВЧЛОЛ

- Эл илтгэл нь академич С.Нарангэрэлийн сүүлийн **20 шахам жилд эрх зүйн толь бичиг зохиох талаар хийсэн эрдэм судлалын цуврал бүтээлийн үр дүнг нэгтгэн гаргахад чиглэгдэв.**



АГУУЛГА

- I. Зорилго
- II. Ач холбогдол
- III. Зориулалт
- IV. Дэлхий нийтийн жишиг
- V. Хамарсан хүрээ
- VI. Агуулгын багтаамж
- VII. Ашигласан эх сурвалж
- VIII. Үр дүн
- IX. Шинжлэх ухааны үнэ цэнэ

НЭГ. ЗОРИЛГО

- Эрх зүйн ухагдахуун ба нэр томъёоны агуулгыг нарийн зөв тодорхойлох;
- Эрх зүйн нэр томъёоны сан бүрдүүлэх;
- Монгол Улсад эрх зүйн тулгуур, суурь, тайлбар толь бичиг буй болгох.

ХОЁР. АЧ ХОЛБОГДОЛ

- Монгол Улсад эрх зүйн ухагдахуун ба нэр томъёоны агуулгыг нэг мөр, зөв ойлгох ба тайлбарлах, хэрэглэх, хэвшүүлэх.

ГУРАВ. ЗОРИУЛАЛТ

- Цуврал бүтээлийн зориулалтыг чухам хэнд зориулснаар нь дараах байдлаар тоймолж болно:
 - хууль тогтоогчид;
 - хууль сахиулагчид (шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, улсын байцаагч зэрэг);
 - хууль биелүүлэгчид (бүх нийтэд);
 - хууль зүй судлалыг хөгжүүлэгчид (эрдэмтэд, судлаачид, багш зэрэг);
 - хууль зүйд суралцагчид (оюутан, магистрант, докторант зэрэг).

ДӨРӨВ. ДЭЛХИЙ НИЙТИЙН ЖИШИГ

- Хууль зүй судлал өндөр хөгжсөн дэлхийн улсууд эрх зүйн ухагдахуун ба нэр томъёогоо жишээлбэл, дараах толь бичиг зохион нийтийн хүртээл болгох замаар хэвшүүлэн тогтоож чаджээ:

ТОЛЬ БИЧИГ . . .

- АНУ анх 1891 онд **Black's Law Dictionary** (ес дэх нэмэлт засвараар 25 мянга гаруй нэр томъёо, хэллэг бүхий);
- ХБНГУ анх 1914 онд **Rechts-Worter-Buch** (арван долоо дахь нэмэлт засвараар 9200 гаруй нэр томъёо, хэллэг бүхий);
- ОХУ анх 1999 онд **Большой юридический словарь** (гурав дахь нэмэлт засвараар 7000 гаруй нэр томъёо, хэллэг бүхий) зэрэг.

ТАВ. ХАМАРСАН ХҮРЭЭ

- Цуврал бүтээлд оруулсан **эрх зүйн ухагдахуун ба нэр томъёоны хүрээг** дараах байдлаар тоймолж болно:
 - **эрх зүйн ерөнхий онол** (төр, эрх зүйн онол, монголын ба гадаад улсын төр, эрх зүйн түүх, эрх зүйн философи, эрх зүйн социологи зэрэг);
 - **материаллаг салбар эрх зүй** (үндсэн хуулийн, захиргааны, иргэний, эрүүгийн, хөдөлмөрийн, гэр бүлийн, санхүүгийн зэрэг);
 - **салбар хоорондын материаллаг эрх зүй** (экологийн, гаалийн зэрэг);

- **олон улсын эрх зүй** (олон улсын нийтийн ба хувийн эрх зүй);
- **процессын эрх зүй** (үндсэн хуулийн, захиргааны, иргэний, эрүүгийн, арбитрын);
- **хууль зүйн хавсарга судлагдахуун** (криминологи, криминалистик, шүүх эмнэлэг, шүүхийн сэтгэц гэм судлал зэрэг);
- **харьцуулсан эрх зүй судлал** (англо-америкийн эрх зүйн бүл, ром-германы эрх зүйн бүл, мусульманы эрх зүйн бүл, социалист эрх зүйн бүл, скандинавын эрх зүйн бүл зэрэг);

ЗУРГАА. АГУУЛГЫН БАГТААМЖ

Цуврал бүтээлд авч үзсэн **эрх зүйн нэр томъёоны агуулгын** багтаамжийг дараах байдлаар тоймолж болно:

- **түгээмэл ач холбогдолтой** (өдөр тутам хэрэглэгддэг, нийтэд ойлгомжтой) эрх зүйн нэр томъёо;

- эрх зүйн онцгой утга агуулга бүхий **хууль зүйн тусгай нэр томъёо** (жишээ нь татвар өршөөл, концессын гэрээ зэрэг);
- техник, эдийн засаг, анагаах ухаан, мал эмнэлэг, хөдөө аж ахуй зэрэг **шинжлэх ухааныг тусган илэрхийлдэг тусгай нэр томъёо** (жишээ нь хүн, малын гоц халдварт өвчин, дархлал олдмол хомсдолын өвчин, нянтай программ зэрэг);

ДОЛОО. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


Цуврал бүтээлд хууль зүйн шинжлэх ухаанд их үнэ цэнэтэй дараах эх сурвалжийг ашигласан:

- хууль тогтоомж;
- олон улсын гэрээ, конвенц;
- толь бичиг;
- нэвтэрхий толь;
- ном зохиол;
- түүхэн материал зэрэг 1000 гаруй эх сурвалж.

НАЙМ. ҮР ДҮН


- Зохиогч 1988 оноос эхлэн 20 шахам жилийн туршид дараах цуврал бүтээлийг боловсруулан хэвлүүлж нийтийн хүртээл болгосон:

1) Англи-монгол-орос хууль зүйн толь.




- 1994 онд хэвлүүлсэн;
- 9000 гаруй нэр томъёо, хэллэгтэй;
- 40 гаруй хэвлэлийн хуудастай;
- монгол, орос индекстэй.

2) Хууль зүй судлалын Англи-монгол тайлбар.



- 2005 онд хэвлүүлсэн;
- 20 мянга гаруй нэр томъёо, хэллэгтэй;
- 80 гаруй хэвлэлийн хуудастай;
- Галигтай;
- зарим англи хууль зүйн нэр томъёоны тайлбар үйлдсэн;
- англи товчлолын тайлал үйлдсэн.

3) Эрх зүйн эх толь бичиг.



- 2007 онд хэвлүүлсэн;
- 5000 гаруй тайлбартай;
- 70 шахам хэвлэлийн хуудастай;
- латин, англи, орос оноолт үйлдсэн.

ЕС. ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНЭ ЦЭНЭ

- Монголын хууль зүйн шинжлэх ухааны **суурь бүтээлийн нэг болсон**;
- Монгол Улсад **эрх зүйн нэр томъёоны тулгуур толь бичиг буй болгох нэгэн томоохон алхам хийгдсэн**;
- Хууль тогтоогчид, хууль сахиулагчид, хууль биелүүлэгчдээс **эрх зүйн нэр томъёо ба хэллэгийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх** шинжлэх ухааны үндсийг бүрдүүлсэн;
- Дэлхий нийтийн эрх зүйн нэр томъёоны жишиг ухагдахууныг **МОНГОЛЫН ХУУЛЬ ЗҮЙ СУДЛАЛЫН ЭРГЭЛТЭД ОРУУЛСАН**;
- Монголын эрх зүйн нэр томъёог латин, англи, орос хэлнийхтэй, англи, орос эрх зүйн нэр томъёог монгол хэлнийхтэй дүйцүүлэхэд чухал оролдлого болсон;

ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНЭ ЦЭНЭ

- Өмнө дурдсан эрх зүйн толь бичгийн цуврал бүтээлийг зохиох явцад **“Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал”** хэмээх мэн цуврал бүтээлүүд турvigдсан:
 - Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ., 2001; x 448;
 - Монголын эрх зүйн тогтолцооны удиртгал. УБ., 2003, x 59;
 - Правовая система Монголии., Улан-батор-Москва., Московский Государственный Институт Международных Отношений (Университет) МИД России, 2003, стр.146;
 - Legal system of Mongolia. Ulaanbaatar-Nagoya, Japan., 2004, p.248
 - Einführung in das mongolische Recht., BWV.Berliner Wissenschafts.Verlag., 2005, p.114 (Герман, Хятад хэл дээр)
- эрх зүйн боловсролын **сургалтын нэн чухал хэрэглэгдэхүүн** болсон.



ЦЭРЭНЖАВЫН АЛТАНЦЭЦЭГ

Дэд профессор. Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны гишүүн, хяналтын зөвлөлийн дарга.

Эрдэм шинжилгээний ажил, судалгааны бүтээлүүд

“Гэр бүлийн эрх зүй”	(1995)
“Эрх зүйн гарын авлага” хамтын бүтээл	(2000)
“Иргэн, бизнесийн эрх зүйн гарын авлага” хамтын бүтээл	(2006)
“Гэр бүлийн эрх зүй” /бодлого, дасгалын гарын авлага/	(2007)
“Хуульчийн ур чадвар” хичээлийн хөтөлбөр, зөвлөх	(2007)
“Хуульчийн ур чадвар” хичээлийн гарын авлага, зөвлөх	(2007)
“Гэр бүлийн эрх зүй” хичээлийн хөтөлбөр, гарын авлага	(2007)

ХҮҮХЭД ХАМГААЛАЛ-ГАДААДЫН ИРГЭН МОНГОЛ УЛСЫН ХАРЬЯАТ ХҮҮХДИЙГ ҮРЧЛЭН АВАХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүүхэд хамгаалал, түүний хүрээнд авч үзэх үрчлэлтийн тухай асуудал бол хүний эрхийг хөндөж байгаагийн хувьд нэн тэргүүнд хүүхдийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэх тулгамдсан асуудлын нэг болно.

Хүний эрх, эрх чөлөө бол нийгмийн хөгжил, дэвшлийн гол хөдөлгөгч хүчиний нэг бөгөөд нийгэм дэх хүн төрөлхтний хамгийн үнэ цэнэтэй зүйл билээ.

“Хүний эрх, эрх чөлөө” хэмээх ойлголт нь:

“хүлээн зөвшөөрөх”-“баталгаажуулах”-“хамгаалах” гэсэн үндсэн агуулгаар томъёологох ба эдгээр ойлголтууд өөр хоорондоо салшгүй холбоотой, нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлэх шинжээрээ харилсан хамаарлыг бий болгодог. Энэхүү эрх, эрх чөлөө нь хуулийн хүч, дэмжлэгээр тогтоогдон хамгаалагдаж байж сая эрх, эрх чөлөө өөрөө хүн бүрт тодорхой болж бас үнэ цэнэтэй, ач холбогдолтой болох тул ямар нэгэн хамгаалалтгүйгээр орших бололцоогүйн дээр үүнийг гагшхүү эрх зүйн хувьд баталгаажсан төр л хангаж хэрэгжүүлэх боломжтой. Энэ утгаараа хүний үнэлэмжийг дээшлүүлэх, түүний хөгжлийг хангах нь нэн чухал тул Үндсэн хуульд:

“Хүний эрх, эрх чөлөөг хангахуйш эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эллүүлэх үргийг төр иргэнийхээ өмнө хариуцна” гэж заажээ.

Хамгаалал - хамгаалах үйлийн нэр²

Иймээс хүүхэд хамгаалал нь түүний хуулиар хүлээн зөвшөөрөгдөж, баталгаажсан хүний эрхийг хангах эрх зүйн механизмаар хэрэгжинэ.

Хүний эрхийг хангах механизм гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бүхий л нөхцөл боломжийг хангахын тулд төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, хууль зүйн арга хэрэгслүүдийн тогтолцоо юм. Хүүхдийг хамгаалах зорилгоор хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар тусгайлан баталсан олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг хангах, хамгаалах системийн хүрээнд багтах цогц асуудлыг илэрхийлнэ.

Хүн төрөлхтний хөгжил, хувь заяаг тодорхойлох нэн чухал асуудал бол хүүхэд, тэдний хөгжил, хамгаалал юм. Иймээс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тусгай чуулган хүүхдийн асуудлыг онцлон хэлэлцэж **“Хүүхдийн эсэн мэнд амьдрах нөхцлийг хангаж**

1 Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. Арван есдүгээр зүйл

2 Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. 1966 он. 635-р тал

хамгаалах, хэрэгжүүлэх” тухай дэлхий дахинь тунхаглалыг 1990 онд гаргасан.

Монгол Улс нь НҮБ-ын гишүүн улсын хувьд тунхаглалын үзэл санааг хэрэгжүүлэх арга хэмжээг авсан нь чухал байлаа. Үүний нэг тод илрэл бол 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг баталснаар энэ салбар дахь эрх зүйн орчны шинэчлэлтийн үйл явц эхэлсэн юм. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтооолоор “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг баталснаар хүүхдийн эрхийг хамгаалах төрийн эрх зүйн бодлогын шинэчлэлтийн 2 дахь шатны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд хүүхэд хамгааллын салбарт үндэсний хэмжээнд баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, түүний хүрээнд нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан болно.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод сууринсан Үндэсний хөгжлийн цогц боллогод тусгагдсан “Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого”-ын хүрээнд “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил хөтөлбөр”-ийг /2007 он/ боловсруулж хэрэгжүүлэхээр тусгагдаж байгаа нь чухал ач холбогдолтой юм.

Ингэснээр хүүхдийн талаархи төрийн бодлого нь хүн ам зүйн буюу гэр бүлийн хүрээн дэх бодлогын дагавар салбар гэхээсээ илүү бие даасан шинжтэй бодлого болохыг харуулж байна.

Бие даасан салбарын хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбогдсон түүний хөгжил, хамгааллын асуудлыг цогц шийдвэрлэх үүднээс төрийн эрх зүйн бодлого нь дараах 5 түвшинд тодорхойлогдох ба тус бүрт үйлчлэх эрх зүйн үр нөлөө бүхий тодорхой механизмуудаар дамжин хэрэгжүүлэх болно. Үүнд:

1. Хууль тогтоох түвшинд
2. Хөтөлбөрийн түвшинд
3. Үдирдлагын түвшинд
4. Гүйцэтгэх түвшинд
5. Боловсролын зэрэг түвшингийн хүрээнд хүүхэд хамгааллын асуудлыг авч үзэхийн сацуу түүний үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, хүүхдийн хөгжил, эрхийг хангах, хамгаалах хүрээнд дэвшигүүлсэн зорилтод хүрэх эрх зүйн үйлчлэл, нөлөөллийн түвшинг дээшлүүлэхэд оршино.

Эрх зүйн зохицуулалт хангалтгүй байх нь нийгмийн хөгжилд төдийгүй хувь хүний хөгжилд саад тогтор учруулах, хүний эрх, эрх чөлөөг нийтээр хүлээн зөвшөөрсөн жишгээс дордуулах, эрх зүйн хийдэл гаргах, хуулийн заалтууд зөрчилдөх, нийтийн сайн сайхан байдлыг алдагдуулах, хүн амын тодорхой хэсгийн, тухайлбал: хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хохироох, хууль бус үйлдэл хүргэх зэрэг хэлбэрээр сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх талтай. Ийм нөхцөлд эрх зүйн механизмын үр нөлөөг дээшлүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй арга хэмжээг цогц байдааар хэрэгжүүлэх шаардлагатай. Олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр нөлөө бүхий эрх зүйн хамгаалалтаар хангах хэрэгтэй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /1966 он/-ын 2 дугаар зүйлийн 2.3-т зааснаар:

- a) хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах,
- b) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг хөгжүүлэх

с) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдалыг хангах үргийг оролцогч улс бүр хүлээнэ.

Үр ашигтай арга хэрэгсэл – энэ нэр томъёог хүний эрхийн талаарх ихэнх олон улсын гэрээ конвенцид тусгасан ба түүнийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэрэгслийг бий болгох тухай заалттай холбоотой хэрэглэдэг. Эдгээр арга хэрэгсэл нь үр ашигтай байх шаардлагатай бөгөөд энэ нь хүн бүхэнд хүртээмжтэй болон хэм хэмжээг хэрэгжүүлэхэд тус дөхөмтэй байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, дотоодын арга хэрэгсэл нь бодитойгоор хэрэгждэг байвал зохино³.

Нэг. Гадаадын иргэн Монгол Улсын харьят хүүхдийг үрчлэн авах асуудлын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Монгол Улсын гэр бүлийн эрх зүйн эх сурвалж нь үндэсний хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэж орсон олон улсын гэрээ, конвенциудаас бүрдэнэ. Гэр бүлийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах үрчлэлттэй холбогдсон харилцааны эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл дараах олон улсын болон үндэсний хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

a) Олон улсын гэрээ, конвенц:

- ❖ **Хүүхдийн эрхийн тухай конвенц** (1989 онд батлагдаж, Монгол Улс 1990 онд соёрхон баталсан)
- ❖ **Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц** (1993 онд батлагдаж, Монгол Улс 1998 онд нэгдэн орсон)

b) Үндэсний хууль тогтоомж:

- ❖ **Монгол Улсын Үндсэн хууль** (1992 он)
- ❖ **Гэр бүлийн тухай хууль** (1999 он)
- ❖ **Гадаадын иргэнд Монгол Улсын харьят хүүхдийг үрчлүүлэх журам** (Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 тоот хамтарсан тушаал)

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц:

Хүүхдийн эрхийн тухай үндсэн баримт бичиг нь 1989 онд батлагдсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц юм.

Энэхүү Конвенцид оролцогч улсууд “Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм”-д тунхагласан зарчмуудын дагуу нийгмийн бүх гишүүдийн угаас заяасан нэр төр, тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь дэлхий дахинд эрх чөлөө, шударга ёс, энх тайвныг хангах үндэс болно гэж үзэж энэ хүрээнд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах асуудалд оншгой анхаарал хандуулах шаардлагатайг тодорхойлжээ.

“Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйшэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа оншгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай” гэсэн Хүүхдийн эрхийн тунхаглалд заасан дээрх заалт нь “Хүүхэд”-эрх зүйн харилцааны оншгой субъект болохыг илэрхийлж байна.

Иймээс конвенц нь дэлхий нийтээр хүүхдийн эрхийг дэмжиж хамгаалах эрх зүйн механизмыг тогтоосон чухал баримт бичиг юм.

Конвенцид хүүхдийн эрхийг хангахад баримтлах, зайлшгүй мөрдлөг болговол зохих үндсэн зарчмуудыг тогтоосон. Үүнд:

1. Үл ялгаварлан гадуурхах зарчим;
2. Хүүхдийн амьдрах, амьд явах, хөгжих эрхийн зарчим;
3. Хүүхдийн үзэл боллыг хүндэтгэх зарчим;
4. Хүүхдийн эрхэм эрх ашгийг хангах зарчим;

Эдгээр зарчмуудыг хүүхдийн эрх ашигтай холбогдсон аливаа бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах түвшинд удирдлага болгох хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд хүүхдийн

³ Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага. 2002 он

талаар төрөөс баримтлах эрх зүйн бодлогод бүрэн тусгагдахын зэрэгцээ түүний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, шүүх болон засаг захиргааны байгууллагаас гаргах шийдвэр, хүүхэдтэй холбогдсон аливаа үйлчилгээ, үйл ажиллагаанд ч зайлшгүй дагаж мөрдөх хэлбэрээр хэрэгжих ёстой байдаг. Тодруулбал: энэ бүхнийг хүүхдийн эрхэм эрх ашгаас үүдэлтэй, түүнд нийшүүлэх ёстой болохыг харуулж байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн З дугаар зүйлийн 3.1-д:

“Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна” гэж заасныг харгалзан үзэх ёстой. Энэ утгаараа хүүхдийн дээд ашиг сонирхол гэдэг нь тэдний эрхийг хангахад анхаарч, хalamжлан хамгаалахад оршино.

2. Хүүхдийг хамгаалах ба улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенц:

Конвенцид улс бүр хүүхдийг өөрийн төрөлх гэр бүлийн асрамжинд байх боломжийг бүрдүүлэх талаар зохих арга хэмжээг тэргүүн зэрэгт тавьж ажиллах шаардлагатайг онцлон тодорхойлж, харин **өөрийн төрөлх улс оронд тохиромжтой гэр бүл оддохгүй байгаа** нөхцөлд хүүхдийг байнгын гэр бүлийн давуутай талыг олгох боломжийн үүднээс улс хооронд үрчлэх үрчлэлтийн систем байж болохыг хүлээн зөвшөөрсөн юм.

Улс хооронд үрчлэх үрчлэлтийн системийн зорилго нь:

а) Үрчлэлтийг хүүхдийн дээдашиг сонирхлын дагуу олон улсын хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн түүний үндсэн эрхийг хүндэтгэх үндсэн дээр хэрэгжүүлэх баталгааг бий болгох;

б) Хүүхэд хүлгайлах, худалдах, хил дамнан худалдаалагдахаас сэргийлэх хууль зүйн баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох;

в) Хүүхэд үрчлэл нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагдах боловч хүүхдийн эрхэм эрх ашгийг онцгой харгалзан үзэж, үүнд санхүүгийн ашиг хонжоо олох зорилго агуулж үл болох, түүнийг хориглосон байх;

Дээрх зохицуулалт нь хүүхдийн эрхийг хангах, тэдний эрх, ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хамгаалах үүднээс үрчлэлтийг бүхий л үйл явц хуулиар зайлшгүй зохицуулагдах ёстой болохыг хүлээн зөвшөөрсөн юм.

Иймээс үрчлэлтийн процессыг бүхэлд нь хамарсан эрх зүйн зохицуулалт байх шаардлагатай бөгөөд үүнд:

1. Үрчлэх, үрчлүүлэх нөхцөл байдлыг урьдчилан тогтоох процесс;
2. Үрчлэх, үрчлүүлэх процесс;
3. Үрчлэгдсэн хүүхдийг үрчлэн авсан эшэг, эх болон тухайн улс оронд шилжүүлэх процесс;
4. Үрчлэлтийн дараах процесс хамрагдана.

Эдгээр процессуудад үйлчлэх, тухайн процесс бүр нь хууль зүйн тодорхой шаардлагуудын хүрээнд зохицуулагдах ёстой болохыг тусгасан. Ялангуяа улс хоорондын үрчлэлтийн систем нь уг конвенцийн 2 дугаар зүйлд зааснаар хэлэлцэн тохирогч нэг улсад (төрөлх улс) оршин суугаа, хүлээн авах улсын оршин суугч этгээд буюу төрөлх улсад байгаа гэрлэгчид үрчлэн авсны дараа бусад хүлээн авагч улсал буюу төрөлх улсын дотор ийнхүү үрчлүүлэх зорилгоор хэлэлцэн тохирогч өөр нэг улсал (хүлээн авагч улс) хүүхэд **шилжин очсон, очих гэж байгаа буюу очиход** эрх зүйн хэм хэмжээ үйлчлэх ёстой юм.

Тухайлбал, хүүхдийн дээд эрх, ашиг сонирхлыг хангаж, түүнд нийшүүлэх шаардлагаас урган гарч байгаа тул үрчлэлтийн бүхий л процесст хууль зүйн тодорхой шаардлагууд

тавигдаж, энэхүү шаардлагуудыг улс бүр хүлээн зөвшөөрч, түүнийг баталгаажуулсан, хууль зүйн зохих шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд хүлээн зөвшөөрөлцөх нөхцөл бүрдэнэ гэдгийг тодорхойлж байна.

Хүүхэд үрчлэх асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэх, гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх нөхцөлд тухайн үрчлүүлж буй хүүхдийн харьялсан улсын хуулиар олгож буй адил эрх, баталгааг олгох, гадаад улсад хүүхэд үрчлүүлэх нь тухайн үрчилж байгаа этгээдэд аливаа санхүүгийн ашиг олох үндэслэл болохгүй байх талаас нь нэн тэргүүнд анхаарах ёстой болохыг заажээ.

Үндэсний хууль тогтоомжийн хүрээнд авч үзвэл:

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)

Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим, түүнийг хангах баталгааг хуульчлан заасан. Тухайлбал:

- Хүний үндсэн эрх, түүний агуулга
- Хүний эрх, эрх чөлөөг хангах
- Хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдалтай тэмцэх
- Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх
- Хүний эрх, эрх чөлөөг бүрэн хангах талаар төрөөс иргэнийхээ өмнө хүлээх үүрэг хариулагыг тусгасан байдаг.

Үрчлэлт нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн асуудал болохынхоо хувьд хүүхдийн эрх, түүний хамгааллын хүрээнд зохицуулагдах асуудлуудыг багтаасан өргөн ойлголт бөгөөд тодруулбал, хүүхдийн гэр бүл, эцэг, эхийг орлох хэлбэрийн оншгий зохицуулалт болох тул үрчлэлтийн бүхий л процесс хүүхдийн эрхийг хангах хүрээнд маш тодорхой зохицуулагдвал зохих хүний эрхийн асуудал юм.

Гэр бүлийн тухай хууль (1999 он)

Үг хуулийн Долдугаар бүлэг буюу 54-62 дугаар зүйлүүдийн хүрээнд хүүхэд үрчлэлттэй холбогдсон харилцааг зохицуулж үрчлэлтийн системийг тогтоосон.

Үрчлэлтийн систем нь:

1. Дотоодын үрчлэлт (Монгол Улсын иргэн хүүхэд үрчлэн авах)
2. Улс хоорондын үрчлэлт (Гадаадын иргэн Монгол Улсын харьят хүүхэд үрчлэн авах) гэсэн хоёр хэлбэрээр зохицуулагдаж байна.

Үрчлэлтийн дээрх хоёр хэлбэрийн хүрээнд хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий болон тусгай нөхцөл журмыг тусгаж түүний хүрээнд дараах асуудлыг хамруулан зохицуулж байна.

1. Хүүхдийг тэдний ашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ гэсэн үрчлэлтийн үндсэн зарчмыг тодорхойлсон;
2. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нөхцлийн хүрээнд хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл болон хүүхэд үрчлэн авах тухай хүсэлт гаргах журам, үрчлэлтийн процесст зөвшөөрөл авбал зохих этгээдүүдийг тодорхойлсон;
3. Үрчлэгч этгээдэд тавигдах шаардлага;
4. Үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллага (Сум, дүүргийн Засаг дарга, Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн алба болон Монгол Улсын дипломат болон консулын байгууллага)-ыг тогтоосон;
5. Гадаадын иргэн Монгол Улсын харьят хүүхэд үрчлэн авах тусгай журам;
6. Үрчлэгдсэн хүүхэд, үрчлэн авсан эцэг, эхийн эрх, үүрэг;
7. Үрчлэлтийг хүчингүйд тоошох үндэслэл журам, үр дагавар;

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам (2001 оны 100/32 дугаар тушаал)

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д Гадаадын иргэнд хүүхэд үрчлүүлэх журмыг Хууль зүйн болон Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүд хамтран тогтоохоор заасан. Одоо мөрдөж буй энэхүү журам нь Хууль зүйн дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан. Харин Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон гадаадын иргэн дагавар хүүхдээ үрчлэн авахад энэ журам үйлчлэхгүй байхаар заасныг анхаарах хэрэгтэй.

Дээрх журмаар гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх ерөнхий шаардлага, үрчлэхийг хүсэгч гадаадын иргэний бүрдүүлэх баримт бичиг болон үрчлэгдэх хүүхдийн талаарх баримт бичиг, түүнийг гаргах журам, үрчлэлтийг шийдвэрлэх байгууллага, үрчлэн авагч гадаадын иргэний хүлээх үүрэг, хүүхэд үрчилснийг бүртгэх журам болон үрчлэлтийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэх байгууллага, түүнээс гарах үр дагаврын тухай асуудлыг хамруулан зохицуулж байна.

Хоёр. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт

Эдгээр хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж харьяалах улсынхаа төрийн захиргааны байгууллагаас улс хооронд хүүхэд үрчлэх зөвшөөрөл олгосон бүртгэлтэй байгууллагаар дамжуулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд ирүүлэх ба тус яам нь материалыг шалгаж, үрчлэгч эцэг, эхэд зуучлагч байгууллагаар дамжуулан үрчлэгдэх боломжтой хүүхдийн судалгааг хүргүүлж, зөвшөөрсөн тохиолдолд хүүхдийн талаархи материалыг хавсаргаж, яамны зөвлөлийн хурлаар оруулж, санал дүгнэлтээ гарган улмаар Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанда холбогдох материалыг явуулж ГИХАЭА нь дээрх материалыг шалгаж шаардлага хангасан гэж үзвэл албаны зөвлөлийн хурлаар оруулан, даргын тушаал гаргаж, эшэслэн шийдвэрлэж байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах зөвшөөрөл авсан эцэг, эх, зуучлагч байгууллагатай тус алба үрчлэлтийн гурван талт гэрээ байгуулж энэхүү гэрээнд заасан нөхцлөөр үрчлэгч нь үрчлэн авсан хүүхдийн тайланг тодорхой хугацаанд ирүүлэхээр тусгагдсан.

НХХЯ болон ГИХАЭА нь Монгол Улс Гаагийн конвенцийн оролцогч улсын хувьд олон улсын хэмжээнд харьяалах улсынхаа төр захиргааны байгууллагаас улс хооронд хүүхэд үрчлэлтийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй байгууллагаар дамжуулан үрчлэгчийн материалыг хүлээн авч шийдвэрлэдэг.

Түүнчлэн, Гаагийн конвенциид нэгдэн ороогүй улс тухайлбал, АНУ-ын хувьд Лутераны нийгмийн үйлчилгээ /LSS/, Холт олон улсын байгууллага /Holt International/, Смоул Воулд /Small world/ гэсэн 3 төрийн бус байгууллагаар зуучлуулан ирүүлсэн үрчлэгчийн материалыг хүлээн авч шийдвэрлэдэг.

Өнөөгийн үед дэлхийн хүн амын хил дамнасан шилжилт хөдөлгөөн улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна. 2006 оны байдлаар Үндэсний статистикийн газрын гаргасан судалгаагаар Монгол Улсын нийт хүн ам 2.594.8 мянга гэсэн тоон үзүүлэлт гарч, үрчлэгдсэн хүүхдийн тоон үзүүлэлтийг авч үзвэл харьцангуй өсөх хандлага ажиглагдаа. Үрчлэгдэж байгаа хүүхдийн 80 хувийг олдмол буюу хаягдсан хүүхдүүд, цөөн хувийг хагас өнчин хүүхдүүд эзэлж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

1999-2007 оны хугацаанд гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдийг авч үзвэл:

Нийт гадаадын иргэн, **158** гэр бүлд **168** Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэгдсэн ба дээрх журам гарснаас хойшхи хугацаанд:

1999 онд эмэгтэй **4**, эрэгтэй **5**, нийт **9**

2000 онд эмэгтэй **4**, эрэгтэй **2**, нийт **6**

2001 онд эмэгтэй **4**, эрэгтэй **4**, нийт **8**

2002 онд эмэгтэй **16**, эрэгтэй **12**, нийт **28**

2003 онд эмэгтэй **17**, эрэгтэй **18**, нийт **35**

2004 онд эмэгтэй **14**, эрэгтэй **16**, нийт **30**

2005 онд эмэгтэй **11**, эрэгтэй **10**, нийт **21**

2006 онд эмэгтэй **14**, эрэгтэй **12**, нийт **26**

2007 он гарснаас хойш эмэгтэй **3**, эрэгтэй **2**, нийт **5** хүүхэд үрчлэгдсэн байна.

Хүснэгтээр үзүүлбэл:

№		Үрчлэлт																		
		1999		2000		2001		2002		2003		2004		2005		2006		2007.03.28		
		эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	
		5	4	2	4	4	4	12	16	18	17	16	14	10	11	12	14	2	3	
																		81	87	
1	Хүүхэд үрчлэн авсан эцэг, эх	9		6		8		28		35		30		21		26		5		168
2	Хүчингүй болгосон үрчлэлт	0		0		0		0		0		0		1		0		0		1

1999 оноос өнөөг хүртэлх хугацаанд үрчлэгдсэн хүүхдийн тоог улс орноор нь авч үзвэл:

АНУ-д	122	Бельги	3
ХБНГУ	13	Канад	3
Франц	6	Австрали	3
БНСҮ	5	Англи	3
Нидерланд	1	Голланд	2
Дани	1	Итали	2
Япон	1		
Испани	1		

Үрчлэгчийн улсаар гаргасан судалгаа сүүлийн 7 жилээр

№	Үрчлэгч эцэг, эхийн харьяат улс	2001	2002	2003	2004	2005	2006	2007	Нийт
1	АНУ	3	24	25	28	13	14	4	111
2	ХБНГУ		3	3	1	1	3		11
3	Франц				1	1	4	1	7
4	Австрали	1		1			1		3
5	БНСҮ		1	2					3
6	Дани			1			2		3
7	Англи			1		2			3
8	Бельги			1		2			3
9	Итали	1					1		2
10	Канад	1		1					2
11	Голланд					2			2
12	Нидерланд	1							1
13	Япон	1							1
14	Испани						1		1
15	Нийт	8	28	35	30	21	26		153

2001 оны 5 дугаар сарын 1-нд ГИХАЭА байгуулагдсанаас хойш нийт **142** гадаадын гэр бүлд **149** хүүхэд үрчлэгдсэнээс:

- 2001 онд эмэгтэй **2**, эрэгтэй **2**, нийт **4**
- 2002 онд эмэгтэй **16**, эрэгтэй **12**, нийт **28**
- 2003 онд эмэгтэй **17**, эрэгтэй **18**, нийт **35**
- 2004 онд эмэгтэй **14**, эрэгтэй **16**, нийт **30**
- 2005 онд эмэгтэй **11**, эрэгтэй **10**, нийт **21**
- 2006 онд эмэгтэй **14**, эрэгтэй **12**, нийт **26**

2007 он гарснаас хойш эмэгтэй **3**, эрэгтэй **2**, нийт **5** хүүхэд үрчлэгджээ.

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжуудаар зохицуулж, түүнтэй холбоотой эрх зүйн орчин бүрдэж, хүүхэд хамгааллын талаархи бие даасан хууль үйлчилж, төрөөс баримтлах эрх зүйн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлж байгаа хэдий ч “Хүүхдийн эрх-үрчлэлийн процесс”-ыг олон улсын хууль тогтоомжид нийцүүлэх хэрэгшээ шаардлага бий болж, шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудал болж, Тухайлбал:

- Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн заалтууд хоорондоо зөрчилтэй;
- Дагаж мөрдөж буй хуулийн зохижуулалт нь амьдрал практикт үүсээд байгаа тулгамдсан, шийдвэрлэвэл зохих асуудлыг зохицуулах боломжгүй;
- Нэр томьёо, түүний хууль зүйн агуулга тодорхой бус;
- Гэр бүлийн жам ёсны мөн чанар, хэрэгшээ шаардлага, гэр бүлийн орчинд хүний эрхийг хангахуйц төрийн болдого, эрх зүйн зохицуулалтын механизм учир дутагдалтай байгаагаас нийгмийн амьдрал, ялангуяа гэр бүл, эцэг, эх, хүүхдийн хоорондын харилцаанд үүссэн “**гажуудал**”-аас нийгмийн үнэт зүйл “**хүний**” эрхэм зэргийн эрх болсон гэр бүл, эцэг, эхийн хайр халамж алдагдаж, улмаар хуулиар хамгаалагдсан хүний эрх, ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл бий болсон;
- Хүүхэд хамгаалал, хариуцлага, хяналтын болон мэдээллийн оновчтой тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын механизмын үр нөлөө хангалтгүй;
- Тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын эрх, үүрэг тодорхой бус, зөрчилдсөн;
- Олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтийг хангах, түүнтэй нийцүүлэх шаардлагатай байна.

Иймээс энэхүү асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс юуны өмнө:

1. Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх талаархи хуулийн зохицуулалт, бодлогын чанартай баримт бичгийн хэрэгжилт, үр нөлөөнд дүн шинжилгээ хийх;
2. Олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтийг хангах, холбогдох заалт, зарчим, санал зөвлөмжийн хүрээнд үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх үүднээс Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үрчлэлийн асуудлыг хүүхэд хамгааллын хүрээнд цогц авч үзэж, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох;
3. **Хүүхдийн эрхийн тухай конвенцид** “Хүүхэд бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай” гэсэн заалт нь хүүхэд-эрх зүйн харилцааны онцгой субъект гэдгийг илэрхийлж байгаа тул энэхүү онцлогт тохирсон эрх зүйн механизмыг бүрдүүлэх;
4. **Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т** заасан “Гэр бүл,

эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалт

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй, эрх тэгш байлагах”, “Төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага аливаа үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэх” гэсэн зарчим

Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5-д заасан “Хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөж хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалахыг эрхэмлэнэ” гэсэн хуулийн заалт, зарчмуудын агуулгад нийцүүлж үрчлэлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохын зэрэгцээ дээрх зарчмын агуулгыг тодорхойлох;

5. “Хүүхэд нь халамж, хамгаалал бүхий өөрийн төрсөн гэр бүлийн орчинд амьдрах” эрхтэй. Энэ утгаар хүүхдэд үзүүлэх халамж, хамгаалал нь юуны түрүүнд тэднийг гэр бүлдээ эсхүгл ойрын төрөл, садантайгаа амьдрахыг дэмжих нь чухал юм. Энэ нь хамгийн **шилдэг арга** буюу “**эхний хувилбар**”, харин халамжийн төвд байршуулах, үрчлэх нь “**эцсийн хувилбар**” болохыг олон улсын гэрээ, конвенцид хүлээн зөвшөөрсний дагуу хүүхэд хамгааллын талаар улс орнуудын баримтлах төрийн бодлогын гол цөм болдог. Иймээс үрчлэлт нь “**гэр бүлийг орлох**” онцгой хэлбэрийн зохицуулалт тул хүүхдийн эрхийг хүндэтгэж, хангах, хамгаалах хүрээнд хуулиар журамлагдан зохицуулагдах харилцаа бөгөөд энэ утгаараа үрчлэлтийн бүхий л процессыг хамарсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
6. 2005 онд НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 39 дүгээр чуулганаас хүүхдийн эрхийн асуудлаар Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмжид: “Дотоодын хууль тогтоомждоо эерэг алхам хийсэн ч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хангалтгүй, хууль нь амьдралаас хол, хуулийн зарим заалт хүүхдийн эрхийг хангалттай хамгаалж чадахгүй, хоорондоо зөрчилтэй”, “Хүүхэд үрчлүүлэх талаархи хууль тогтоомж нь конвенцийн зарчимтай бүрэн нийцээгүй байгаа” гэж заасныг харгалzan үзэж дотоодын болон улс хоорондын үрчлэлтийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг “Хүүхэд хамгаалаал”-ын хүрээнд боловсронгуй болгож хамгаалалт, хариуцлагын болон хяналт, мэдээллийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх хэрэгшээ, шаарллага бий болжээ.

Хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалсан, түүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж чадсан, эрх зүйн үр ашигтай механизм бүрдсэн, энэ нь амьдралд нийцсэн, хэрэгжих боломжтой тийм л хуулийг сайн хууль гэж хэлэх бөгөөд тухайн хууль бодит утгаараа бүрэн хангагдаж, хэрэгжих юм.

Хавсралт

**УЛС ХООРОНДЫН ҮРЧЛЭЛИЙН ХАРИЛЦАА БУЮУ ГАДААД ИРГЭН МОНГОЛ УЛСЫН
ХАРЬЯАТ ХҮҮХДИЙГ ҮРЧЛЭН АВАХ АСУУДЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

A. Үрчлэлийн харилцааны эрх зүйн зохицуулалт

Д/д	Үндэсний хууль тогтоомж	Олон улсын гэрээ, конвенц	Тайлбар
1	<p>Монгол улсын гэр бүлийн тухай хууль(1999 он)</p> <p>7 дугаар булэг : Хүүхэд үрчлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх журам /54§/ - Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх ерөнхий нэхцэл /55§/ - Хүнд нэхцэлд байгаа үрчлүүлсэн хүүхдийн бүртгэл, хяналт /56§/ - Үрчлэгч /57§/ - Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах журам /58§/ - Үрчлэгдсэн хүүхэд, үрчлэн авсан эцэг, эхийн эрх, үүрэг /59§/ - Үрчлэлтийн нууц /60§/ - Үрчлэлтийг хүчингүйд тооцох /61§/ - Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар /62§/ 	<p><u>Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенци</u></p> <p>(1993 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1995 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол улс 1998 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр нэгдэн орсон)</p> <ul style="list-style-type: none"> - Улс хооронд үрчлэх харилцааны зарчим, харилцан хүлээн зөвшөөрөх нэхцэл байдал. - Конвенцийн зорилго /1,2,3§/ - Улс хооронд хүүхэд үрчлэхэд тавигдах шаардлага /4,5§/ - Эрх бүхий төв байгууллага болон итгэмжлэгдсэн байгууллага /6-13§/ - Улс хооронд үрчлэх явцад тавигдах шаардлага /14-22§/ - Үрчлэн авахыг хүлээн зөвшөөрөх, түүний үр дагавар /23-27§/ - Ерөнхий заалт : Үрчлэлтийн журам /28-42§/ 	<p>Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 58 дугаар зүйлээр : Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах асуудлыг зохицуулж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Хүсэлт гаргах журам; - Зөвшөөрөлбүрдүүлэх баримт бичиг; - Шийдвэрлэх эрх бүхий байгууллага зэрэг асуудлыг хамруулсан. <p>Үрчлэлтийн процесс:</p> <ol style="list-style-type: none"> 1. үрчлэн авагч эцэг, эхэд шилжин очих 2. хүлээн авагч улсад шилжүүлэх 3. шилжүүлсний дараах зохицуулалтыг тодорхой тусгах
	<p>Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2001 оны 100/32 тоот тушаал:</p> <ul style="list-style-type: none"> - Нийтлэг үндэслэл /даган мөрдөх хууль тогтоомж, шийдвэрлэх байгууллага, журам/; - Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх ерөнхий нэхцэл; - Хүүхэд үрчилснийг бүртгэх; - Бусад /үрчлэлтийг хүчингүйд тооцох, үр дагавар, мэдээлэл, тавих хяналт/ гэсэн бүтэцтэй. 	<p>“Гэр бүлийг орлох” хэлбэрийн онцгой зохицуулалт болох үүднээс авч үзвэл энэхүү асуудал нь журмаар зохицуулагдах нь учир дутагдалтай.</p>	<p>2001 оны 100/32 тоот тушаалаар батлагдсан журмаар гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэхэд баримтлах журам, үрчлүүлэх ерөнхий нэхцэл буюу бүрдүүлэх баримт, бичиг, шийдвэрлэх эрхбүхийбайгууллага, үрчлэнавагчийн үүрэг, үрчлэлтийг бүртгэх журам, үрчлэлтийг хүчингүйд тооцох түүнээс гарах зардал болон хүүхдийн талаархи мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх, үрчлэлтийн асуудалд олон нийтээс тавих хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын асуудлыг тусгасан. Энэ нь олон улсын гэрээ конвенцтой зөрчилдсэн, үрчлэлтийн процессыг бүрэн хамруулж зохицуулаагүй байна. “Үрчлэлт нь хүүхдийн гэр бүлийг орлох эцсийн хувилбар, хүүхдийг асарч хүмүүжүүлэх онцгой хэлбэрийн зохицуулалт болох тул энэ нь хуулиар зохицуулагдах ёстой харилцаа юм.</p>

Б. Холбогдох хууль тогтоомжийн харьцуулалт

Д/д	Олон улсын гэрээ, конвенц	Үндэсний хууль тогтоомж	Тайлбар
1	<p>Улс хооронд үрчлэх харилцааны зарчим, харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөл</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийгөвтэгшхөгжүүлэхүүднээстэднийгт гэр бүлийн болон баяр баясгалан, хайр, ойлголцлын орчинд өсгөн хүмүүжүүлэх; - Төрөлх улсад үрчлэн авах тохиromжтой гэр бүл олдохгүй тохиолдолд хүүхдийг улс хооронд үрчлэх нь байнгын гэр бүлийг харгалzan үзсэнээр үрчлүүлж буй хүүхдэд тааламжтай байдал олгох; - Хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн, үндсэн эрхийг нь хүндэтгэж, хүүхэд худалдах, хулгайлах, хил дамнан худалдахаас сэргийлэх; 	Хүүхдийгтэднийашиг сонирхлын үүднээс үрчлүүлнэ гэсэн ерөнхий зарчмаар тодорхойлсон.	<ul style="list-style-type: none"> - Зарчим, харилцан хүлээн зөвшөөрсөн нөхцлийг хуульд тусгах; - Төрөлх улсад үрчлэн авах тохиromжтой гэр бүл олдохгүй тохиолдол гэдгийг тодорхойлох; - Хүүхдийн дээд ашиг сонирхол гэдгийг тодорхой тусгах;
2	<p>Үрчлэлтийн зорилго :</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн дээд ашиг сонирхол, түүний үндсэн эрх олон улсын эрх зүйд нийцэж байгаа талаар баталгааг бүрдүүлэх; - Хүүхэд хулгайлах, худалдах, хил дамнан худалдахаас сэргийлж тэдгээр баталгааг хүндэтгэх үүднээс хэлэлцэн тохирогч улсуудын хамтын ажиллагааны тогтолцоог бий болгох; - Хүүхэд шилжиж очсон, очих гэж байгаа буюу очиход энэхүү конвенц үйлчилнэ; - Зөвхөн эцэг, эх, хүүхдийн байнгын харилцааг бий болгох үрчлэлтэд энэхүү конвенц хамаарна; - Хүүхдийг 18 нас хүрэхээс өмнө 17§/с/ дэд хэсэгт заасан хэлэлцээ хийгээгүй бол конвенц үйлчлэхгүй; 	Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсынхарьяят хүүхэд үрчлэн авах хүсэлтэй гадаадын иргэний бүртгэл хөтөлж, хүүхдийг үрчлэх, үрчлэгдсэн хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн холбогдох байгууллага, олон улсынбайгууллагатай хамтран ажиллана.	<ul style="list-style-type: none"> - Үрчлэлтийн явцад хүүхдийн эрхийг хамгаалах механизмыг тодорхой тусгах; - Үрчлэлтийн харилцааны зохицуулалт нь хүүхэд шилжин очсон, очих гэж байгаа буюу очиход үйлчлэх зохицуулалтыг хамруулан тусгах; - Эрх бүхий байгууллага, зуучлагч байгууллага, зөвлөлийн бүрэлдэхүүн зэргийг тодорхой тусгаж тэдгээрийн ажлыг уялдуулах.
3	<p>Улс хооронд хүүхэд үрчлэхэд тавигдах шаардлага</p> <p>1. Төрөлх улсын эрх бүхий байгууллагын зайлшгүй тогтоох нөхцөл шаардлага</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийг үрчлүүлж болохыг тогтоосон байх; - Хүүхдийгасрамжхамгаалалтадшилжүүлэх боломжийг төрөлх улсад судалсны үндсэн дээр улс хооронд үрчлэх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхийг тогтоосон байх; <p>2. Тавигдах шаардлага :</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох этгээдийн зөвшөөрлийн үр дагаврын тухай, түүнчлэн хүүхэд болон түүний төрсөн гэр бүлийн хоорондын эрх зүйн харилцаа дуусгавар болох эсэх талаар мэдээлэл авах; - Эрх бүхий этгээд зөвшөөрлөө сайн дураар, хуульд заасан хэлбэрээр бичгээр гэрчлэх буюу илэрхийлэх; - Зөвшөөрлийг аливаа төрлийн төлбөр, нөхөн төлбөрт үндэслэж олгоогүй байх; 	<ul style="list-style-type: none"> - Сум, дүүргийн засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хэмжээн дэх хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн судалгаа гаргаж бүртгэл хөтөлнө; - Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн нэгдсэн бүртгэл хөтөлж хяналт тавина; 	<ul style="list-style-type: none"> - Төрөлх улсын эрх бүхий байгууллагын зайлшгүй тогтоох нөхцөл шаардлагыг хуульчлах, - Мэдээлэл авах, зөвлөгөө өгөх журмыг тусгах; - Зөвшөөрлийг аливаа төрлийн төлбөр, нөхөн төлбөрийн үндсэн дээр олгохыг хориглох; - Үрчлэн авах тухай хүсэлтийг нотариатаар гэрчлүүлэх талаархи зохицуулалт нь Гэр бүлийн тухай хуулийн 58.3.1 заалт, журмын 10.а дахь заалт хоорондоо зөрчилтэй байна.

	<p>Хүүхдийн нас, төлөөвшилийн байдлыг харгалzan тавигдах шаардлага :</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдэд зөвлөгөө өгсөн болон үрчлэх талаар түүнд зохих мэдээлэл өгсөн, шаардлагатай бол үрчлэн авах тухай түүнээс зөвшөөрөл авах; - Хүүхдийн, хүсэл бодлыг анхаарч үзсэн байх; - Хүүхдийн зөвшөөрөл нь сайн дураар, хуульд заасан хэлбэр болох бичгээр гэрчлүүлэх буюу илэрхийлэх; - Ийм зөвшөөрлийг галиваа төрлийн төлбөр, нөхөн төлбөрийн үндсэн дээр олгохгүй байх; <p>2.Хүүхдийг үрчлүүлэхэд хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагад тавигдах шаардлага :</p> <ul style="list-style-type: none"> - Үрчлэн авах гэж буй эцэг, эх нь үрчлэх эрхтэй буюу боломжтой гэж тооцогдсон; - Үрчлэн авах гэж буй эцэг, эхэд шаардлагатай зөвлөгөө өгсөн байх; <p>Хүүхдэд тэрхүү улсад байнга оршин суух эсхүл нэвтрэх зөвшөөрөлтэй гэдэг нь тогтоогдсон байх;</p>	<ul style="list-style-type: none"> - Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага хүүхдэд үрчлэн авах тухай материалыг хүлээн авч баримт бичиг хангалттай бурдсэн гэж үзвэл 30 хоногийндоторүрчлэгдэх хүүхдийг судлан сонгоно (журмаар зохицуулсан); - Зөвшөөрөл авах эрх бүхий этгээд бүрдүүлэх баримт бичиг; Үрчлэхийг хүсэгч гадаадын иргэний бүрдүүлэх баримт бичгийн хүрээнд тодорхойлж тусгасан; 	<ul style="list-style-type: none"> - “Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн зөвшөөрөл нь бичгээр гаргаж нотариатаар гэрчлүүлсэн байх” гэсэн хуулийн заалтыг журамд “хагас өнчин хүүхд үрчлэх бол уг зөвшөөрлийг бичгээр гаргах” гэж тусгасан нь мөн журмын 12.в-д заасан заалт нь хуулийн 55.1-дэх заалт, мөн хуулийн 55.3, журмын 12 дэх заалт уг хуулийн 55.1 дэх заалттай зөрчилдэж байна. <p>Үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий байгууллагад тавигдах шаардлагыг хуульчлах;</p>
4	<p>Эрх бүхий төв байгууллага болон итгэмжлэгдсэн байгууллага</p> <p>1.Хэлэлцэн тохирогч улс бүр конвенцоор, хүлээсэн үүргийг гүйцэтгэх эрх бүхий төв байгууллагыг томилон ажиллуулна.</p> <p>Мэдээллээр хангах</p> <ul style="list-style-type: none"> -Өөрийн улсад үрчлэлтийн холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх болон үрчилж авсны дараах үйлчилгээг өргөжүүлэх -Тайлан харилцан солилцох; -Хүүхдийн байдалтай холбогдох мэдээлэл цуглуулах, хадгалах, солилцох <p>2. Итгэмжлэгдсэн байгууллага</p> <ul style="list-style-type: none"> -Итгэмжлэгдсэн үүрэг, даалгаврыг зохистой гүйцэтгэх чадвар бүхий байгууллагад итгэмжлэл олгон ажиллана -Итгэмжлэл олгосон улсын эрх бүхий байгууллагаастогтоосон нөхцлийнхүрээнд ашгийн бус үйл ажиллагаа явуулна; -Улс хооронд хүүхдэд үрчлүүлэх ажлын туршлагатай, ёс суртахуун болон сургалтын шалгуурыг хангасан хүмүүсээр удирдуулан ажиллуулах; -Тухайн улсын эрх бүхий байгууллага өөрийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа болон санхүүгийн байдлыг хянах; -2 улсын эрх бүхий байгууллага зөвшөөрсөн бол хэлэлцэн тохирогч нэг улсад итгэмжлэгдсэн байгууллага хэлэлцэн тохирогч нэгээ улсад үйл ажиллагаа явуулж болно; -Хэлэлцэн тохирогч улс эрх бүхий төв байгууллагуудыг томилсон тухай, явуулах үйл ажиллагаа, итгэмжлэгдсэн байгууллагын нэр, хаягийг Гаагийн бага хурлын байнгын төвчөонд мэдэгдэнэ; 	<ul style="list-style-type: none"> -Хуулийн 58.1-д Монгол Улсын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргах; -Үрчлэн авсныг ГИЭЗ байдлын тухай хуульд заасан байгууллага бүртгэнэ; -Гадаадад оршин суугаа Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах хүсэлтийг Монгол Улсын дипломат болон консулын байгууллагаар уламжилна; -Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага нь хүүхдэд үрчлэн авах хүсэлтийн иргэний бүртгэл хөтөлж, хүүхдийг үрчлэх, үрчлэгдсэн хүүхдийн эрх ашгийг хамгаалах асуудлаар бусад улс, тэдгээрийн холбогдох байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллана; -Журмаар зохицуулсан үрчлэлтийн асуудалд олон нийтээс тавих хяналтыг хүн амын асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын итгэмжлэгдсэн этгээд хэрэгжүүлж болно; 	<ul style="list-style-type: none"> -Иргэний бүртгэлийн тухай, Гэр булийн тухай зэрэг холбогдох хуулийн заалтыг уялдуулах, -Хуулийн заалт, журамд заасан ба үгүүлэх талаарх зохицуулалт х о о р о н д о о зөрчилдсэн. Хуулийн 58.4, 58.6 дугаар зүйлд заасан заалт мөн журмын 13, 14 дэх заалтуудыг уялдуулах эрх бүхий байгууллагын эрх, үүрэг, шийдвэрлэх журмыг нэг мөр тодорхой тусгах; -Итгэмжлэгдсэн ба үгүүлэх талаарх асуудлыг хуульд тодорхой тусгах; -Тухайн улсад хуулиар зөвшөөрөлдээсээний эрх бүхий төв ба үгүүлэх талаарх асуудлыг хуульд тодорхой тусгах; -Тухайн улсад хуулиар зөвшөөрөлдээсээний эрх бүхий төв ба үгүүлэх талаарх хяналтан дор ажиллах байгууллага, итгэмжлэгдсэн этгээд тавих шаардлагыг гонвентцийн 22 дугаар зүйлд засантай нийцүүлэн тусгах;

<p>Улс хооронд үрчлэх явцад тавигдах шаардлага</p> <p>1.Хүсэлт гаргасан этгээд хүүхэд үрчлэн авах боломжтой гэж үзвэл тэдний хувийн шинж, үрчлүүлэхэд тохиромжтой эсэх болон боловсрол, гэр бүлийн болон эрүүл мэнд, өвчиний түүх, нийгмийн байдал, үрчлэн авах чадвар болон тэдний асрамжинд очих хүүхдийн байдал зэрэг мэдээлэл агуулсан тайланг хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага бэлтгэнэ.</p> <p>2.Хэрэе хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагау гүүхдийг үрчлэх бүрэн боломжтой гэж үзвэл хүүхдийн хувийн шинж, үрчлүүлэх боломж, намтар, нийгмийн байдал, гэр бүлийн түүх, өөрийн буюу гэр бүлийн эрүүл мэндийн өвчиний түүх болон хүүхдийн онцгой хэрэгцээний талаархи мэдээллийг агуулсан тайлан бэлтгэнэ</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн хүмүүжил, гаралт ургасаа, шашин шүтлэг, соёлын болон орчны байдалд зохих ёсны анхаарал хандуулна; - Зөвшөөрлийг 4 дүгээр зүйлийн дагуу олгосон эсэхийг тодруулна; - Хүүхэд үрчлэн авах эцэг, эхийн тайланг үндэслэн төлөвлөж буй үрчлэлт хүүхдийн ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг тодорхойлно; <p>3.Хүүхдийг үрчлэн авах эцэг, эхэд нь даалган хүлээлгэн өгөх шийдвэрийг хүүхдийн төрөлх улсад зөвхөн доорх тохиолдолд гаргана. Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн улсын эрх бүхий төв байгууллага үрчлэн авах гэж буй эцэг эхийн зөвшөөрлийг баталгаажуулсан; - Хүлээн авагч, төрөлх улсын эрх бүхий төв байгууллага тийм шийдвэрийг зөвшөөрсөн; - 2 улсын байгууллага үрчлэлтийн явцыг үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн; - 5 дугаар зүйлийн дагуу үрчлэн авах эцэг, эх нь үрчлэн авах боломжтой, нэвтрэх зөвшөөрөлтэй гэдэг нь тогтоогдсон; - Эрх бүхий төв байгууллага нь хүүхдийг төрөлх улсаас гарч явах, хүлээн авагч улсад нэвтрэх, байнга оршин суугаа зөвшөөрлийг авахад шаардлагатай бүх арга хэмжээг авна; <p>Хүүхдийг хүлээн авагч улсад шилжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Хүлээн авагч улсад хүүхдийг шилжүүлсний дараа түүнийг үрчлэн авах эцэг, эхийн хамт цаашид байлгахад хүүхдийн ашиг сонирхолд нийцэхгүй гэдгийг эрх бүхий төв байгууллагад мэдэгдэвэл тухайн байгууллага хүүхдийг хамгаалах арга хэмжээ авна; - Хүүхдийг буцаан авч, түр асрамжид өгөх; - Хүүхдийн төрөлх улсын эрх бүхий төв байгууллагатай зөвшилцэн, хүүхдийг үрчлүүлэх үүднээс цаг алдалгүй шинээр шилжүүлэн суурьшуулах бөгөөд хэрэв энэ арга хэмжээ тохиромжгүй бол урт хугацааны асрамжид өгнө; - Хүүхдийн төрсөн улсын эрх бүхий төв байгууллага урчлэн авах шинэ эцэг, эхийн талаар бүрэн мэдээлэл авах хүртэл хүүхдийг үрчлүүлэхгүй; <p>4.Урчлэн авахыг хүлээн зөвшөөрөх, түүний үр дагавар</p> <ul style="list-style-type: none"> - Эрх бүхий байгууллагын гэрчилсэн үрчлэлтийг тухайн улсын хуулиар хүлээн зөвшөөрнө; - Үрчлэлт төрийн бодлогод илт харшилбал хүүхдийн эрх ашигийг хамгаалах үүднээс үрчлэлтийг зөвшөөрөхгүй байж болно; - Үрчлэлтийг хүлээн зөвшөөрөх, түүнээс гарах үр дагавар /26§/; 	<p>Үрчлэн авахыг хүсэгч этгээд хуулийн 55.1, 55.3-д заасан зөвшөөрөл, 58.3-т заасан бичиг баримтыг бурдүүлж эрх бүхий байгууллага, албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна. Хуулийн 57 дугаар зүйлд үрчлэгч этгээдэд тавигдах шаардлагын талаарх ерөнхий заалтыг баримтлахаар тусгасан. Үүнд :</p> <ul style="list-style-type: none"> - Насанд хүрсэн; - Иргэний эрх зүйн чадамжтай; - Хүүхдийг тэжээн тэтгэх, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой; - 57.2-т заасан этгээдүүдэд хүүхэд үр члүлэх эхийг хориглох; <p>Хуулиар зохицуулаагүй. Журамд заасан (12 дугаар заалт) хүүхдийн талаарх материалыг бүрдүүлнэ</p> <p>Үрчлэн авах эцэг, эхэд даалган хүлээлгэн өгөх асуудал зохицуулагдаагүй</p> <p>Хуулиар зохицуулаагүй</p> <p>Хуулийн 59 дүгээр зүйлд заасан үрчлэгдсэн хүүхэд, үрчлэн авсан эцэг, эхийн эрх, үүрэг гэдгээр зохицуулсан. Энэ асуудал үрчлэлтийн ерөнхий журмаар зохицуулгадж байна.</p> <p>Холбогдох мэдээлэл агуулсан тайланг бэлтгэх, ирүүлэх асуудлыг тусгах;</p> <ul style="list-style-type: none"> - Гадаадын иргэний хувьд үрчлэн авах боломжтой гэдгийг тодорхойлж хуульд тодорхой тусгах; - Хүүхдийг үрчлэх боломжтой гэдгийг тодорхойлох; - Хүүхдийн талаархи мэдээллийн тайланг тусгах; - Үрчлэн авах эцэг, эхэд хүүхдийг шилжүүлэх асуудлыг зохицуулах; - Үрчлэн авах эцэг, эхэд хүүхдийг шилжүүлэх журмыг хуулиар зохицуулах; - Хүүхдийг хүлээн авагч улсад шилжүүлэх журамд заасан (12 дугаар заалт) хүүхдийн талаарх материалыг бүрдүүлнэ - Хүүхдийг хүлээн авагч улсад шилжүүлсний дараа хамгаалах болон үйлчилгээний зохицуултыг тусгах; - Хүүхдийг хүлээн авагч улсад шилжүүлсний дараа хамгаалах болон үйлчилгээний зохицуултыг тусгах; - Үрчлэгдсэн хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг тусгах; - Гадаадын иргэнд үрчлүүлж байгаа тул үрчлэлтийг хүлээн зөвшөөрөх нөхцөл байдал, үр дагаврыг хуульд тусгай заалт оруулж тусгах; - Үрчлэлтийн дараах процесст тавих хяналт болон хамгаалалт, хамгаалах болон мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;
--	---

ТЭРБИШИЙН АМГАЛАН



Зохистой хөгжлийн жендэр төвийн гүйцэтгэх захиral.

Эрдэм шинжилгээний ажил, судалгааны бүтээлүүд

Шилжилтийн үе дэх Монголын эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдал судалгаа (1998)

Биеэ үнэлэгч охидын байдал хандлага судалгаа (1998)

БЗХӨ/ХДХВ/ДОХ өвчинд өртөх магадлал өндөртэй биеэ үнэлэгч/янхан, гомосексуудийн

БЗХӨ/ХДХВ/ДОХ өвчний талаархи мэдлэг, хандлага, дадал хэвшил судалгаа (1998)

Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын Эмзэг бүлгийн орлого бий болгох төслийн үнэлгээ/судалгаа (1998)

Жижиг зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо судалгаа (1999)

Гадаадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэрт ажиллагчдын хөдөлмөрлөх эрх, хөдөлмөр хамгаалалын төлөв байдал (1999)

Монголын эмэгтэйчүүдийн нөхцөл байдал (2000)

Төрийн бус байгууллагуудын нийгмийн салбарт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр (2000)

Эмэгтэйчүүдийн төрийн бус байгуулмагын хөгжил ба байгуулмагын чадавхийн үнэлгээ (2001)

Гэр бүл дэх хүчирхийллийн талаархи олон нийтийн ойлголт мэдлэг, хандлага (2002)

Гэр бүл дэх хүчирхийллийн эсрэг хуулийн талаархи УИХ-ын гишүүдийн санаа бодол (2003)

Монгол Улсын жендерийн байдлын үнэлгээ (2003)

Жендерийн асуудлыг салбарын бодлого, төлөвлөлтөнд тусгах стратеги (2003)

“Жендерийн тэгш байдлын үзэл баримтлал” мэдээллийн багц (2004)

“Төсвийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангах нь” судалгаа (2005)

Жендерийн сургалтын модуль (2006)

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ядуурлын байдал ба шинэ хөдөлгөөний үүсэл, хөгжил” судалгаа (2007)

МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫГ ЖЕНДЕРИЙН ӨНЦГӨӨС ХАРАХ НЬ

Дэлхий дахинаа жендерийн тэгш байдлыг хангах⁴ нь тогтвортой хөгжилд хүрэх гол арга зам хэмээн үзэж, жендерийн чиг хандалгыг хөгжлийн бүхий л бодлого, төлөвлөлтөнд нийцүүлэн тусгах явдал чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрч байна.

Жендерийн үзэл баримтлалыг үйл хэрэг болгох (gender mainstreaming) нь бүх шатны зохион байгуулалт, санхүүгийн болон бусад нөөц бололцоог хэр үр ашигтай дайчилж, байгууллага, төрийн албан хаагч эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн дотоод хандлага, соёлыг хэр үр өгөөжтэй өөрчилж чадсанаас ихээхэн хамаарах билээ.

Жендер гэдэг нэр томъёо нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эдийн засаг, нийгэм, улс төр ба соёлын амьдралын онцлог шинж чанар, боломж бололцоог тодорхойлдог. Ихэнх нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эрхэлж буй үйл ажиллагаа, нийгмийн нөөцөөс хүртэх боломж, нөөцийг хянах ба шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцоо харилцан адилгүй байдаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаа цаг хугацаа өнгөрөхөд

4 Хүйс, жендер гэсэн ойлголтуудыг хэрэглэх үед төрөгдөл гарах үе цөөнгүй тохиолддог. Тэр байтугай англи хэлээр ярьдаггүй улс орнуудын хүмүүст “Gender” гэдэг үгийг эх хэл рүүгээ хөрүүлэн хэрэглэхэд тэдний өмнө нилээд саад гардаг. Жендер гэдэг үгийн утга нь хүйс гэдэг үгнээс өөр утгатай боловч зарчмын хувьд холбоотой юм. 1995 онд Бээжин хотноо чуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр бага хурлаас хойш энэ ойлголтыг жендер ба хөгжлийн судалгаа, сургалтын үндэс болгон олон улсын түвшинд хүлээн зөвшөөрч эхэлсэн. 1996 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т “Gender” гэдэг үгийг англи хэллэгийн дуудлагаар нь шууд авч хүйс гэсэн тайлбартаigaар хэрэглэснээр энэхүү нэр томъёо төрийн бодлого баримт бичигт анх тусгагдсан. 2002 оны 12 дугаар сард Засгийн газраас “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталснаар Монгол Улс “Жендер” гэдэг үгийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл явцдаа хэрэглэж эхэлж байна.

өөрчлөгддөг бөгөөд эдгээр нь нийгэм бүрт харилсан адилгүй олон янзын хувилбартай байдаг. Жендер нь харилсааны онол бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцааг тодруулбал, энэ нь зөвхөн эмэгтэйчүүдийн асуудал биш бөгөөд төр, эдийн засаг, зэрэг нийгмийн макро ба микро үйл явц, институутдтай уялсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бүтцийн харилцааг мөн илэрхийлдэг.

Монгол Улсад жендерийн тэгш байдлыг хангах чармайлтууд олон улсын байгууллагууд, ТББ-уудын идэвхи санаачлагаар эхлэн хийгдсээр 10 гаруй жил өнгөрсөн ба Засгийн газрын бүтцийн дотор ЖТБҮХороо байгуулагдаж, ЖТБҮХөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлсэн нь нийгэм эдийн засгийн бүх салбарт gender mainstreaming хийх албан тогтолцоог үүсгэсэн. Гэвч жендерийн тэгш байдлыг хангах зорилгын хэрэгжилт удаашралтай, бодитой үр дүн харагдахгүй байгаа бөгөөд үүний шалтгааныг үндэсний хэмжээнд ажиллах чадваргүй сүл тогтолцоо, жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг үйл хэрэг болгох үндэсний буурай чадавхи, хөгжлийн бус чиг баримжаатай төсөвтэй холbon тайлбарлаж байна.⁵ Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ялгаатай хэрэгшээ, сонирхол, үүрэг, нөөцтэйн адилаар тэдгээрийн бодлого болон төсөлд нэвтрэх боломж нь мөн ялгаатай байдаг ба үүний дагуу бодлого төсөл нь тэдгээрт өөр өөрөөр нөлөөлдөг байна. Тийм ч учраас МХЗ-уудыг хангах явдал нь жендерийн асуудалтай шууд холбоотой юм.

Нэг. Мянганы хөгжлийн зорилт ба жендерийн тэгш байдал

2000 онд болсон НҮБ-ын дээд хэмжээний чуулга уулзалтаар дэлхийн 189 орны төр засгийн тэргүүн цуглаж, “хамгийн эмзэг бүлгийнхний эрхийг хүндэтгэн, хүний хөгжлийг хангах орчныг бүрдүүль” уриатай Мянганы тунхаг хэмээх баримт бичгийг баталж, 2015 он хүртэл хугацаанд шийдвэрлэвэл зохих асуудлуудыг баглан тодорхойлж, Мянганы тунхаглалыг Монгол Улсын Ерөнхийлөгч оролцон талархан дэмжсэн билээ. Энэ ч утгаараа тунхаглалыг дэмжин хүлээн авсан улс орнуудын нэгэн адил Монгол Улс өөрийн орны онцлогт нийцүүлэн тулгамдсан асуудлуудыг тодорхойлон⁶. Монгол Улс үндэсний 9 зорилго дэвшүүлэв.

Улс орон бүр 2015 онд багтаан Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд хөрөнгө оруулалт хийх салбараа оновчтой тодорхойлж, хязгаарлагдмал нөөцөө үр ашигтай зарцуулахыг зорих нь ойлгомжтой. Үүнийг амжилттай болгохын тулд жендерийн тэгш байдлыг хангахуйц хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал гэдгийг хүлээн зөвшөөрөх асуудал юм. Жендерийн тэгш байдлыг бий болгохын тулд тэгш бус байдлыг тогтвортой хадгалахад нөлөөлж буй байгууллагуудын дадлага, нийгмийн харилцааг өөрчлөх шаардлагатай болдог.

Хэрэв бид үйлажиллагаа, эсвэл үйлдлийг өөрчлөхөөр зорьсон бол асуудлын мөн чанарыг ойлгох нь чухал. Жендерийн үзэл баримтлалыг үйл хэрэг болгох нь урт хугацааны, зөвхөн системтэйгээр хийсэн тохиолдолд л үр дүнд хүрэх хөгжлийн ажил гэдгийг олон улс орны туршлага дэлхий дахинаа харуулж байна. Үүнээс хамгийн гол нь бүх шатны байгууллагууд тэгш эрх, боломжийн талаархи зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллах нь чухал бөгөөд жендерийн мэдрэмжтэй улс төрийн шийдэл бүхэн хүн амын өсөлттэй шууд холбоотой байдгийг жендерийн тэгш байдлыг хангасан улс орнуудын түүх батлан харуулж байна.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт бол өөрийн орны өмнө тулгараад байгаа нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудыг шийдэх нээлттэй, үр дүнтэй байж болохуйц алхам юм. Нийгэм эдийн засгийн хүндрэлтэй асуудлуудын цаана тэгш бус байдал бий болж байdag. Өнөөгийн ялгаатай, тэгш бус нөхцөлд эрэгтэй, эмэгтэй хүмүүст тэгш хандах гэж оролдох нь жендерийн тэгш байдлыг хангах арга стратегийн

5 "Монгол улсын жендерийн бодлого" үндэсний форум 2008 оны 2 ёёааад сар.

6 Монгол Улсын их хурлын 2005 оны 25 дугаар тогтоол, "Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг батлах тухай"

хувьд хангалтгүй. Тэгш бус нөхцөл тэгш хандах гэж оролдох нь ялгавартай байдал улам нэмэгдэх үндэс болдог гэдгийг анхаарах хэрэгтэй.

Мянганы хөгжлийн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд жендэрийн тэгш байдлыг хангах асуудлыг давхар харгалзан үзэж нийгмийн бүлэг, давхаргууд, эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээ, нөөцийг ашиглах боломж нь өөр өөр байдгийг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын хүн амын 48.8 хувь нь эрэгтэй, 51.2 хувь нь эмэгтэй байна. Төрөх үеийн хүйсийн харьцаа 100 охид, 104 хөвгүүн ноогдож байгаа нь хүн амын бүтцийн хувьд хэвийн харьцаа юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүгд л өөрсдийн амьдралаа зохицуулах чадвартай болох үүднээс өөрсдийгээ чадавхжуулдаг. Өөрөөр хэлбэл, хүмүүс өөрийн саал бэрхшээлийг давж чадах, бие даах чадвараа хөгжүүлэх зэрэгт шаардлагатай мэдлэг чадвар олж авахыг хүсдэг нь олон нийтийн, улс төрийн бус харин хувь хүний хөгжлийн үйл явц юм. Эдгээр хүрээнд билтэгш байдлын асуудлыг хөндөн тавьдаг. Жендерийн асуудлууд нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн амьдралын бүхий л хүрээнд, хөрөнгө нөөцөөс хүртэх тэдгээрийн боломж, хэрэгцээ зэргийг хамаарсан өргөн ойлголт билээ.

Жендерийн тэгш байдал нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижилхэн байхын нэр бус, харин тэдний эдлэх боломж, бололцоо, амьдралд хүртэх боломж нь тэгш байхыг хэлдэг. Жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн чадварыг бэхжүүлэх асуудалд анхаарснаар нийгэм бүржендерийн тэгш байдлын аль нэг загварыг дагаж мөрдөх ёстай гэсэн үг бус, харин эрэгтэй, эмэгтэй хүмүүс жендерийн тэгш байдал гэж юу болох талаар сонголт хийж, тавьсан зорилгодоо хүрэхээр хамтран ажиллах тэгш боломжтой гэсэн санааг илэрхийлнэ.

Салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд жендерийн хандлагыг тусгах, Мянганы хөгжлийн зорилт, Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (ЖТБҮХ)-ийн хүрээний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Жендерийн тэгш байдлын Үндэсний хороог 2005 оны 25 дугаар тогтооолоор байгуулж, түүний ажлын албыг бэхжүүлсэн нь жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, зөвлөлдөх, хяналт тавьж ажиллах үндэсний тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болов.

Хоёр. Мянганы хөгжлийн зорилтуудын жендерийн тэгш байдлыг хангах асуудал

Жендерийн тэгш байдлыг хангах нь Монголын эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдийн амьдралд чанарын өөрчлөлт гаргаж, тэднийг бие даан өөрсдийн бүрэн эрхийн дагуу аж амьдралаа дээшлүүлэхийг дэмжих явдал юм. Иймээс Монгол Улсын Засгийн газар нь улс орныхоо хөгжил дэвшилд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах, тэднийг нийгмийн баялгийн үр шимээс адил тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, улмаар нийгэм соёлын харилцаан дахь жендерийн тэгш байдалд гарч буй гажуудлыг засан залруулах, сөрөг үр дагаврыг арилгах бодлогыг баримтлах хүсэл эрмэлзлээ илэрхийлж байгаагийн тод илрэл нь МХЗ-уудыг батлан гаргасан явдал юм.

Монгол Улсын жендерийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлэх МХЗ нь боловсрол, хөдөлмөр эрхлэлт, шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн харьцааг тэгш хангахад чиглэгдэж байна..

2.1. Ядуурал дахь жендерийн асуудал

МХЗ-д 2015 он гэхэд ядуурлын хувийг 18 хувь хүртэл бууруулах зорилт тавьсан. Түүнчлэн, ядуурлыг бууруулахын хамтаар хоол тэжээлийн дутагдал, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хүн амын шилжих хөдөлгөөний талаархи асуудлуудыг шийдвэрлэхээр зорьсон.

Нийт хүн амын 32.2 хувь нь ядуу амьдарч байна. Сүүлийн жилүүдэд эдийн засаг өссөн хэдий ч тэгш бус байдал газар авч, эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулахад нөлөөлж чадсангүй. Иймээс эдийн засгийн өсөлтийн үр шимийг Монголын эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд хүртэх боломжийг бүрдүүлэхийн тулд жендерийн тэгш байдлыг хангах хөгжлийн загварыг анхаарах нь чухал байна.

Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн эрх ашгийг хөндсөн эмзэг асуудлуудыг зохицуулах шинэ арга хэрэгсэл дутагдаж, тэгш эрхийн тухай өрөөсгөл, туйлширсан, нэг хэв загварын ойлголт, мэдрэмж үргэлжилж байгаагаас эмэгтэйчүүд, хүүхдүүд нийгмийн сөрөг үзэгдлүүдэд давуутай өртөж, “Эмзэг бүлэг” гэгдэх хэсэгт тэд дийлэнх болж байна.

Шилжилтийн үеийн орлогын ядуурлын даамжрал болон амьдралын хүнд хэцүү бүхэн хүүхэд, эмэгтэйчүүдэд илүүтэйгээр туссан нь эмэгтэйчүүд, хүүхдийг ядууруулахад нөлөөллөө. Хүн амын амьжиргааны түвшингийн 1998 оны түүвэр судалгаагаар нэн ядуу өрхийн 24,6 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байгаа нь ядуу бус өрхүүдээс 2 дахин их, 2002-2003 оны судалгаагаар нийт ядуу өрхийн 43.9 хувь нь эмэгтэй тэргүүнтэй өрх байж, мөн л эмэгтэйчүүд тэргүүлсэн өрхүүд ядуу гэсэн дүгнэлт гарчээ. Өрх тэргүүлэн үр хүүхдээ ганцаар өсгөж, гэр ахуйгаа хөтөлж яваа эмэгтэйчүүдийн тоо⁷ 2006 оны байдлаар 78,765 мянгад хүрч, 1990 оноос 5 дахин нэмэгджээ. Энэ нь бодит амьдрал дээр хөдөлмөр эрхэлж орлого олдоггүй нөхөртэй, өрх гэрээ тэжээн тэтгэдэг эмэгтэйчүүдийг⁸ тооцоогүй үзүүлэлт юм.

Нийгмийн хalamжийн тухай хуульд “нэн ядуу амьдралтай, өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 насанд хүрсэн эх (50 насанд хүрсэн эцэг) тэтгэвэр авах эрхтэй” гэжээ. Зааснаас олон хүүхэдтэй өрх тэргүүлсэн 45-аас доош насын эмэгтэй тэтгэвэр авах эрхгүй болж, нийгмийн хalamжийн тэтгэвэр, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна. Ядуурлаас гадна сүүлийн жилүүдэд хоол тэжээлийн дутагдал, өлсгөлөн ядууучуудыг нөмөрч эхэллээ. Иймээс хоол тэжээлийн дутагдал, тэр дундаа хүүхдийн хоол тэжээлийн дутагдалтай байдлын цаана ядуу, жирэмсэн болон төрсөн эмэгтэйчүүдийн хоол тэжээлийн дутагдын асуудлыг анхаарах шаардлагатай юм.

2.2. Боловсрол дахь жендерийн асуудал

МХЗ-ын гол асуудал нь бага боловсролын сургалт, 1-ээс 5 дугаар ангидаа суралцагсын хамрагдалтын байдал, 15-24 насын залуучуудын бичиг, үсэг тайлагдалт, бага, дунд, дээл боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн харьцааны асуудал юм. Энд охид хөвгүүдийн боловсрол, сургалтаас гадна боловсролын чанар, хүртээмжийн асуудал боловсрол дахь жендерийн асуудлын хүрээнд хөндөгдөнө.

Боловсролын салбар дахь жендерийн тэгш байдлын үзүүлэлтийг суралцагсын хүйсийн харьцааны тоон мэдээллийн хүрээнд ойлгох нь туйлын хангалтгүй бөгөөд энэ байдал нь жендерийн тэгш бус байдлыг үүсгэж буй хүчин зүйлсийг бодитойгоор үнэлэх, шийдвэрлэх арга замыг сонгоход сөрөг нөлөө үзүүлсдэг.


Монгол Улсын Засгийн газраас “Жендерийн тэгш бус байдлыг 2005 онд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд арилгах”-аар тусгасан Мянганы хөгжлийн зорилт өнөөдөр боловсрол дахь жендерийн тэгш байдлыг хэмжих албан ёсны гол үзүүлэлт хэдий ч мэдээ, мэдээллийн дутмаг байдал нь боллого боловсруулагчдыг ч уг зорилгын агуулга, түүнд хүрэх арга замын талаар тодорхой ойлголт төсөөлөлгүй байдалд хүргэж байна.

⁷ Гэрлэж байгаагүй, тусдаа амьдардаг, салсан, бэлэвсэн эмэгтэйчүүдийг оруулсан ба эдгээр эмэгтэйчүүд албан ёсоор бүртгэлтэй өрх тэргүүлсэн эмэгтэйчүүд юм.

⁸ Эрэгтэйчүүд нь албан ёсоор өрхийн тэргүүний бүртгэлтэй боловч амьдрал дээр өрх гэрээ хөтөлж тэжээж яваа эмэгтэйчүүдийг хэлсэн болно.

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод тусгасан энэхүү зорилтын 2005-2006 оны хэрэгжилтийн үндэсний хоёрдугаар илтгэл дурдсанаар бага, боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн тооны харьцаа 2006 оны байдлаар 0.98, ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа 1.03 хувьтай байна.

Зураг 1. Бага, дунд, дээд боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн харьцаа



Мэдээллийн эх сурвалж: УСГ, 2006 он

Энэхүү зорилтыг хангахын тулд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, БСШУЯНЫ үйл ажиллагааны хөтөлбөрт “Ерөнхий боловсролын сургуулийн IX анги төгсөгчдийн 80-аас доошгүй хувийг Х анgid элсүүлж, ахлах ангийн сурагчдын хүйсийн харьцааг тэнцвэржүүлэх арга хэмжээ авна” хэмээн тусгаж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор “Элсэлтийг нэмэгдүүлэх тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 486 дугаар тушаал батлагдан гарсан. Үг тушаалд “... ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгсөгчдийн 80-аас доошгүй хувийг 10 дугаар анgid элсүүлж, түүнээ эрэгтэй сурагчдын эзлэх хувийг улсын хэмжээнд 48 хувьд хүргэх...” гэж заажээ. Энэхүү тушаалыг хэрэгжүүлэхийн тулд 10 дугаар анgid элсэн орох болзол хангасан охидын эрхийг ялангуяа хөдөө орон нутагт зөрчсөн гажуудал гарсан нь тушаалын агуулгыг буруу ойлгосноос болсон гэсэн тайлбартай байна.

Хүснэгт 1. Насанд хүрэгчдийн боловсролын түвшин

1979, 1989, 2000 оны хүн амын тооллогын мэдээгээр

	Бичиг үсэггүй	Бичиг үсэгтэй	Бага	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Диплом	Боловсролын зэрэгтэй
1979 он							
Бүгд	7.3	11.4	29.0	28.4	9.8	7.9	6.2
Эрэгтэй	3.9	11.6	28.8	32.5	9.2	6.6	7.4
Эмэгтэй	10.6	11.3	29.1	24.3	10.4	9.3	5.0
1989 он							
Бүгд	3.5	6.0	20.5	33.9	18.1	9.6	8.5
Эрэгтэй	1.8	5.0	19.7	38.8	17.6	7.4	9.8
Эмэгтэй	5.1	7.0	21.4	29.0	18.6	11.7	7.2

	2000 он						
Бүгд	2.2	3.2	16.4	30.1	29.7	9.2	9.2
Эрэгтэй	2.0	3.1	17	34.0	27.8	6.9	9.2
Эмэгтэй	2.5	3.4	15.8	26.2	31.6	11.3	9.2

Эх сурвалж: УСГ.2000. Хүн ам, орон сууин тоомого, Боловсролын байдал, бичиг үсгийн мэдлэг

Боловсрол дахь жендерийн асуудлын хүрээнд сурх бичгийн агуулгын жендерийн мэдрэмжтэй байдал их чухал юм. Ерөнхий боловсролын сургуулиудын сурх бичгийн агуулгын жендерийн мэдрэмжтэй байдлыг 2003-2005 оны байдлаар судлахад хангатгүй, сүл байна⁹.

2006 оны байдлаар нийт суралцагсын 51 хувь нь эмэгтэйчүүд, түүнчлэн, сургууль суралцагсын хүйсийн харьцаа бага, дунд ангид тэнцвэртэй, ахлах ангиас өөрчлөгдөх хандлагатай байна. Эмэгтэйчүүдэд дээд боловсрол эзэмших хувь давуу байгаа ч албан тушаал ахих, шинэ боломжуудаа ашиглах тал дээр дутагдалтай байна¹⁰. Энэ нь эмэгтэйчүүдийн мэргэжлийн боловсролын бүтэц, эдийн засгийн салбарын үйл ажиллагааны эрэлт нийлүүлэлтэд тэр бүр тохирохгүй байгааг харуулж байна.

Боловсролын шат ахих тусам нэмэгдэж буй хүйсийн нэг тийшээ хэлтийсэн байдалд нийгмийн сөрөг үзэгдэл гэж хандахаас илүү түүний шалтгаан, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг судалгааны үндэслэлтэйгээр тодорхойлох шаардлагатай. Ингэснээр боловсролын салбарт төдийгүй нийгмийн оюуны амьдралын салбарт мэдрэгдэж буй болон гарч болох олон төлөв байдлыг танин мэдэх боломжтой билээ.

2.3 Эрүүл мэнд дэх жендерийн асуудал

МХЗ-д нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн болон эхийн эндэгдлийн түвшинг бууруулах зорилт тавьсан. 2006 оны байдлаар 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл 19.8 хувь, нялхсын нас баралт 62.4 хувьтай, үүнээс нярай, эхийн 84.3 хувь нь төрсний дараах 7 хоногт эндэж байна. Энэ нь ураг, нярайн тусламж үйлчилгээнд оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх дэвшилтэт технологи нэвтрүүлж, эхийн эрүүл мэндийг сайжруулах, төрөх үеийн хүндрэлээс сэргийлэх ажиллагаа хангатгүй байгаатай холбоотой. Нялхсын /5 хүртэлх насны хүүхдийн/ эндэгдлийн түвшинг эхийн боловсролын түвшингээр авч үзэхэд боловсролгүй болон бага боловсролтой эхчүүдийн хүүхдийн хувьд хамгийн өндөр 1000 амьд төрөлтөнд 66 /90/ байхад, дээд боловсролтой эхчүүдийн хүүхдийн хувьд 18 /22/ байна.

Хүснэгт 2. Нялхсын эндэгдэл

(Нэг нас хүрэлгүй эндсэн хүүхдийн тоо 1000 амьд төрөлтөд)

1989	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2004	2006
64,1	59,8	57,8	46,7	44,4	40,4	40,2	35,4	37,3	32,8	22,3	19,1

Эх сурвалж: УСГ эмхтгэл

Хүүхэд төрүүлж буй эмэгтэйчүүдийн 99 хувь нь эмнэлгийн мэргэжлийн ажилтны хяналтанд хамрагдаж, хүүхдээ төрүүлж байгаа хэдий ч, 2006 оны байдлаар эхний эндэгдлийн түвшин 100.000 амьд төрөлтөд 69.7 хувь байна. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 46 хувь нь суурь өвчтэй, жирэмсэн эмэгтэйчүүдийн 47 хувь нь төмөр, 37 хувь нь “Δ” амин дэмийн дутагдалд байна. 2000 онд төрөхийн улмаас 81 эх эндсэнээс Улаанбаатар хотод 25, хөдөө орон нутагт 56 эх эндсэн байна. Мөн 2001 онд 82 эх, 2006 онд 33 эх энджээ.

⁹ БСШУЯ-аас ЭЯГБХУТК-ийн хэрэгжилтийн Засгийн газрын 5 ёёддээр тайланд тусгасан мэдээллээс

¹⁰ НҮБХХ, Монголын хүний хөгжлийн илтгэл 2003 хуудас 14-д өдөр.

Хүснэгт 3. Эхийн эндэгдэл, (100 мянган амьд төрөлтөнд)

1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2004	2005	2006
120	200	244	212	185	176	145	158	175	158	169	98.6	93.0	69.7

Эх сурвалж: ЭМЯ

Улсын хэмжээнд 2006 онд эхчүүдийн амрах байр 335 ажиллаж байгаагаас 312 нь сумын төвд, 21 нь аймгийн төвд, Улаанбаатар хотод 2 эмнэлэг ажиллаж байна. Эдгээрийн 98 нь зориулалтын, 237 нь эмнэлэг дотор байрладаг. Төрөх тусгай байргүй байгаа нь эмнэлгийн практикт жирэмсэн, хүүхэд тээж буй эмэгтэйг өвчтөн гэж үздэг хандлагатай холбоотой. Түүнчлэн, эхийн эндэгдэлд уламжлалт жендерийн стереотип нөлөөлж байна.

Болит баримт

Эх 38 настай, 6 дахь жирэмслэлт, 4 дэх төрөлт. Ядуу амьдралтай. Жирэмсний хяналтын эмч аймагт төрөхийг зөвлөсөн боловч боломжгүй, гэр орны ажил их, нөхөр хүүхдүүд гэрт үлдсэн гээд зөвшөөрөөгүйгээс гэр лүүгээ харьсан. Жирэмсний 6 сар хагастай байхдаа төрөлт өөрөө эхэлж, улмаар төрж, умай урагдан цус их хэмжээгээр алдан нас барсан. Сумын эх баригч аймгаас тусlamж дуудсан боловч ирэхээс нь өмнө нас баржээ.

ЭНЭШТ, Эхийн эндэгдлийн итгэмжит лавлагааны судалгаанаас, 2006 он

Болит баримт

Эх 28 настай, анхны төрөлт. Сумын эмчийн заавраар эх жирэмсний хяналтанд байсан, эрүүл мэндийн байдлаас төрөхийн өмнөх тасагт хэвтэж байсан. Гэтэл нөхөр нь эмнэлэгт олон хоног зүгээр хэвтлээ гээд орой нь ирээд жирэмсэн эхнэрээ мотоциклд суулган гэр лүүгээ авч явснаас эхнэр нь тэр оройдоо бие муудан, эхэс ховхорч, эмнэлгийн тусlamж авч чадалгүй нас барсан.

Орон нутагт ажилласан шинжээчийн тайлангаас, 2006 он

Эхийн эрүүл мэндийг хангах асуудлын хүрээнд үр хөндөлтийн асуудлыг анхааран үзэх шаардлагатай байна. 1993 оноос улсын болон ЭМЯ-ны зөвшөөрөлтэй гурваас доош сартай жирэмсэн эмэгтэйчүүдэд үр хөндөлт хийхийг зөвшөөрчээ.

2006 онд 130,0 эмэгтэй үр хөндүүлсэн тухай бүртгэлээс үзэхэд өдөрт 361 эмэгтэй үр хөндүүлж байна. Гэтэл бүртгэлгүйгээр хувийн эмнэлэгт үр хөндүүлж буй эмэгтэйчүүдийн тоог мэдэхгүй байна. Эмэгтэйчүүдийн хувийн эмнэлгүүд орлогынхоо 80-90 хувийг үр хөндөх үйлчилгээнээс олдог гэсэн мэдээлэл хүртэл байна.


Хүсээгүй үедээ жирэмсэлж, үр хөндүүлэх тоо өсч байгаа нь нөхөн үржихүйн эрхийн хүрээнд эмэгтэйчүүд эрх мэдэл багатайг харуулж байна. Үр хөндөлтийг чөлөөтэй болгож, гэр бүл төлөвлөлтийн аргуудыг нэвтрүүлснээр хууль бус, амь насанд аюултай үр хөндөлт, эхийн эндэгдлийн түвшин буурахад нөлөөлсөн хэдий ч дөрвөн амьд төрөлт тутамд нэг үр хөндөлт ногдоор¹¹ байна. 2000 онд төрөх насны 1000 эмэгтэйд 18,4 үр хөндөлт, 1000 амьд төрөлтөд 231 үр хөндөлт ногдох байлаа. Жирэмсэлсэн эмэгтэйчүүдийн 96 хувь нь хүүхэд төрүүлэхийг хүсээгүйн улмаас үр хөндүүлсэн байна¹². Түүнчлэн, өсвөр насны болон гэр бүлгүй эмэгтэйчүүдийн дунд үр хөндөлт нэмэгдэж, давтан үр хөндөлт өндөр байгаа нь сэтгэл эмзэглүүлж байна. Үр хөндүүлснээр эмэгтэйчүүд эрүүл мэнд, сэтгэл санааны маш хүнд байдалд хүрдэг. Гэвч олон эмэгтэйчүүд үр хөндүүлсээр байна.

11 Монгол дахь хүсээгүй жирэмсэлт ба үр хөндөлт судалгаа, ЭМХҮТ, НҮБ-ын Хүн амын сан.
12 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаа, УСГ, НҮБХАС, 1998 үйл.

2.4 Хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн асуудал

Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь 2006 оны байдлаар 2000 оны түвшингээс нэмэгдэж 53.9 хувьд хүрсэн байна. Энэ хандлага хэвээр үргэлжилбэл 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтыг хангах боломжтой юм. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийн үзүүлэлт нь үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь хөдөлмөрийн зах зээл эмэгтэйчүүдэд хэр нээлттэй байгаа нь харагддаг.

Зураг 2. Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь



Мэдээллийн эх сурвалж: УСГ, 2006 он

Монгол Улсын нийт хүн амын 50.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эдийн засгийн идэвхитэй хүн ам, ажиллагчдын дотор эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байгаа боловч бүртгэлтэй ажилгүйчүүдийн дунда эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс харьшангуй өндөр гарсан нь эрэгтэйчүүд хөдөлмөр эрхлэлтийн албандаа бага бүртгүүлж байгаатай холбоотой.

Жендерийн тэгш бус байдал хамгийн тод хэмжигдэхүйц байдлаар илэрч буй талбар бол хөдөлмөр эрхлэлт юм. Монголд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн тэгш бус байдлыг ажиллах хүчиний оролцооны жендерийн ялгаа, ажил мэргэжлийн жендерийн тусгаарлалт, хөдөлмөрийн хөлслний жендерийн ялгаа, хөдөлмөрийн нөхцөл, агуулгын хувьд илрэх жендерийн ялгаа гэсэн үзүүлэлтүүдээр авч үзжээ¹³.

Ажиллах хүчиний оролцооны жендерийн ялгаа

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээлд оролцох оролцоо, ажил эрхлэх боломж ялгаатай байна. Судалгаагаар эрэгтэй, эрэгтэй хүний эдийн засгийн идэвхитэй байдал, ажилгүйдэлд өртөхөөс хамгаалагдсан байдал нь мөн л ялгаатай байна. 2006 оны байдлаар эрэгтэйчүүдийн ажиллах хүчиний оролцооны түвшин 66 хувь, эмэгтэйчүүдийнх 61 хувь байна. Энэ тоо 2004 онд эрэгтэйчүүд 52.0 хувь, эмэгтэйчүүд 48 хувь байв.

Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэхэд эрэгтэйчүүд долоо хоногт дунджаар 17.5 цаг, эмэгтэйчүүд 31.8 цаг зарцуулж байна¹⁴. Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл дээр гарч цалинтай ажил эрхлэхийн зэрэгцээ гэр бүлийнхээ сайн сайхны төлөө үр хүүхдээ харах, өвчтэй хүн, хөгшдлийг асрах, хоол хүнсээ бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд дийлэнх цагаа зарцуулж байна¹⁵. Үнэлгээгүй хөдөлмөрийн хамгийн гол ачаалал нь хүүхэд, өндөр настан, өвчтэй хүн асрах явдал юм. Эмэгтэйчүүдийг хөдөлмөр эрхлэхэд хамгийн их саад буй асуудал нь хүүхэд асаргааны байгууллагуудын дутагдалтай байгаатай

13 С.Түмэндэлгэр, Хөдөлмөрийн зах зээл дэх жендерийн сегрегаци, судалгааны тайлан, 2005 й.

14 УСГ. 2004 он, Ажиллах хүчиний судалгааны тайлан.

15 ЗХЖТ, "Хөлсгүй хөдөлмөр" судалгаа, 2005 он.

холбоотой. Түүнчлэн, тэтгэвэр авагчдын дунд эмэгтэйчүүд зонхицж байгааг нь 1990-ээд оны эхэн үед авч хэрэгжүүлсэн эмэгтэйчүүдийг тэтгэвэрт гаргасан тэтгэврийн бодлогын үр дүн байна.

Хөдөлмөрийн гэрээнд ил тусгагдаагүй ч жирэмслэх болон хүүхэд төрүүлэх, бага насны хүүхдээ асрах зэрэгт ажлаас чөлөөлөгдөхгүй байх, эсвэл чөлөөлөгдхийг ажил олгогчдын зүгээс шаардах нь эмэгтэйчүүдийг нөхөн үргихүйн үргээр нь ялагварласан “хүүхэдгүй” эрэгтэй ажилтны нэгэн адил байхыг шаардаж буй асуудал болж байна. Энэ нь “бага насны хүүхэдтэй” эрэгтэй ажилчдад ч адил байна. Хэдийгээр төр засгаас хүн амыг өсгөх бодлого баримталж байгаа ч энэ нь ажил хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх өнөөгийн байдлыг дэмжих бодлоготой уялдахгүй байна.

Хүснэгт 3. Шилжилтийн үеийн ажиллах хүчиний үзүүлэлтүүд, хүйсээр

Он	Хөдөлмөрийн насны хүн ам (мян.хүн)		Ажиллах хүч (мян.хүн)		Ажиллагч хүн ам (мян.хүн)		Ажилгүйдлийн түвшин (хувиар)	
	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй
1992	565.3	569.3	446.0	414.0	421.1	384.9	6,3	7,0
1994	584.9	580.8	430.3	404.4	395.6	364.2	9,0	9,9
1995	596.3	590.4	429.0	383.7	407.5	360.1	5,5	6,2
1997	617.4	612.2	428.1	400.7	397.0	368.1	7,7	8,1
1998	631.0	625.8	438.0	404.4	414.2	378.4	5,9	6,4
2000	670.9	676.5	434.8	412.8	416.9	392.1	4,6	5,0
2006	784.4	835.2	506.0	536.8	491.9	518.1	3.2	3.5

Эх сурвалж: УСГ. Статистикийн эмхэтгэл, 2007 он

Ажил эрхлэх боломж эрэгтэйчүүдэд илүү байгаагаас ажилгүйдлийн түвшингээр эмэгтэйчүүд үргэлж эрэгтэйчүүдээс өндөр байдаг. Өндөр боловсролтой, 30-аас дээш насны эмэгтэйчүүд ажилд орох, ажлаа солих боломж хөдөлмөрийн зах зээл дээр хязгаарлагдмал байна.¹⁶


Шилжилтийн жилүүдэд жендерийн үүрэг, хариуцлагыг зохистой хуваарилахад дутмаг анхаарснаас эмэгтэй хүний нийгмийн болоод гэр бүлийн давхар үүрэг ачаалал нэмэгдсэж улмаар өрх гэрийн дотор эмэгтэйчүүдийн ачаалал илүү нэмэгдэх болсон нь өрхийн эдийн засгийн дотоод зохион байгуулалттай холбоотой юм. Энэ нь нэг талаас мал сүрэг, орон сууц зэрэг төрөөс шилжүүлэн өгсөн эд хөрөнгийг эзэмших, нөгөө талаас гэр бүлийн хүрээнд орлого нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулж, гэр бүлийн үүргээ ажил эрхлэхтэй хослуулан албан бус салбарт хувиараа хөдөлмөр эрхлэж байгаатай хамааралтай.

Энэ байдлаас тэд илүү уян хатан, нээлттэй албан бус хөдөлмөр эрхлэлтийн салбарыг сонгож байна. Албан бус салбарт ажиллагчдын 54 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг хэдий ч албан бус хэлбэрт хөдөлмөр эрхлэх нь хөдөлмөрийн зохистой төрөл биш юм.

Хөдөлмөрийн хөлсний жендерийн ялгаа

Ижил байр суурь бүхий хүмүүс ижил цалин хөлс авахыг хуульчлан тогтоосон үед цалин хөлсний жендерийн ялгаа нь ажил мэргэжлүүд жендерийн бүлгүүдэд тусгаарлагдаж буй байдалтай холбоотой байдаг.

Зураг 3. Сарын дундаж цалин, жил бүрийн 2 дугаар улирлын байдаар, хүйсээр Мян.төг



Эх сурвалж: УСГ. Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, 2007 он

Хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн тусгаарлалтыг эдийн засгийн салбаруудаар харахад тээвэр, холбоо, уул уурхай, барилга, төрийн удирдлага, батлан хамгаалахад эрэгтэйчүүд, эрүүл мэнд, боловсрол, зочид буудал, хоолны газарт эмэгтэйчүүд зонхицж байна. Эдгээр салбаруудын цалингийн зөрүү нь цалин хөлсний жендерийн ялгаатай байдалд хүргэж байна. Тухайлбал, эмэгтэйчүүд зонхилсон салбарт эрэгтэйчүүд өндөр цалин авч, албан тушаалын эрэмбээр тухайн салбарт эрэгтэйчүүд удирдах, эмэгтэйчүүд гүйцэтгэх түвшинд ажиллаж байгаатай холбоотой байна.

Өндөр цалин хөлс олгодог зарим салбарт ажлын байр нэмэгдэж байгаа боловч бага цалинтай салбаруудад эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь өндөр хэвээр байгаа нь цалингийн зөрүүг бий болгож байгаа нь 2003-2006 онд шинээр бий болгосон ажлын байрны 27 хувь нь барилга, 13 хувь нь уул уурхайн салбарт ажиглагдаж байна. Цалин хөлсний тухайд нийт ажиллах хүчиний 15 хувийг эзэлдэг боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны байгууллагуудын цалин нэмэгдсэн ч, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчдийн цалин нэмэгдээгүй юм.

Түүнчлэн, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ажиллаж буй салбар, эрхэлж буй ажлаас хамаарч цалингийн ялгаа нь боловсролын түвшингээс хамаарахгүй, харин эмэгтэйчүүдийн цалингийн голч эрэгтэйчүүдийнхээс 25 дахин доогуур, эмэгтэйчүүдийн ажлын бүтээмж эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү боловч цалин, хөлс нь бага байгааг харуулж байна. Хэрэв цалин хөлс тэнцүү байсан бол, зөвхөн боловсролын түвшинтэй нь харьцуулахад эмэгтэйчүүд 11,7 хувь дахин илүү цалин хөлстэй, хөдөлмөр эрхлэлтийн цалин, хөдөлмөрийн ихээхэн зөрүү байгаагүй бол эмэгтэйчүүд 22 дахин хувь илүү цалин авах ёстой¹⁷ юм.

Хөдөө аж ахуйгаас бусад салбарт ажиллаж буй эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харуулахад эмэгтэйчүүд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарт, харин эрэгтэйчүүд төрийн удирдлага, батлан хамгаалах, тээвэр, олборлох үйлдвэрлэл зэрэг орлого ихтэй салбарт түлхүүг ажиллаж байна.

Гадаадад цагаачлагч ажиллах хүчиний жендерийн асуудал

Гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа нь хөдөлмөр эрхлэлт дэх жендерийн ялгаа гадаадад ажиллагсдын дунд мөн илэрч байна. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс 3-2 дахин бага цалин, хөлс авдаг нь эмэгтэйчүүд засгийн газрын

17 УСГ, ОУХБ, "Монгол Олс дахь сургуулиас ажилд шилжих шилжилт", судалгаа, 2006 й.

хэлэлцээрийн дагуу хууль ёсоор ажиллах хүчний цагаачлалд хамрагдах боломж мүү байгаагаас хууль бусаар ажиллаж байгаатай ч холбоотой бөгөөд тэд хил дамжуулан худалдаалагдах эрсдэлд хүртэл хүрч байна.

2007 оны байдлаар Япон, БНСҮ, Чех, Унгар улсуудад 15,0 мянган гаруй хүн албан ёсоор ажиллаж байгаагийн 75-80 хувь нь 20-34 наасны залуучууд байна. 2004 онд хийсэн “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгаанаас харахад АНУ-д ажиллагч эрэгтэйчүүдийн 52,5 хувь, эмэгтэйчүүдийн 68,5 хувь нь; БНСҮ-д ажиллагч эрэгтэйчүүдийн 52,5 хувь, эмэгтэйчүүдийн 53,9 хувь нь дээд боловсролтой байгаа нь мэргэжил, боловсролтой залуучууд гадаадад шилжих хөдөлгөөнд оролцох магадлал өндөр үзүүлэлттэй байна. Түүнчлэн, эдгээр залуучуудын бараг тал хувь нь Монголд байхдаа хөдөлмөр эрхэлдэггүй байжээ.

Хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш байдлыг хангахад төр хариушлагатай оролцох үүргээ биелүүлж, хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгахад нөлөөлөхүйц бие даасан хуулийг батлан, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Монгол Улсын хэмжээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд гарч буй өөрчлөлтийг тодруулсан жендэрийн дүн шинжилгээ, судалгааны мэдээлэл хомс байна. Эмэгтэйчүүдийн нийгэм, гэр бүлдээ гүйцэтгэж буй үүргийг эн тэнцүү үнэлж, улмаар эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг дэмжих, түүний дотор хүүхэд төрүүлсний дараагаар ажилдаа эргэн ороход дахин мэргэшүүлэх төрийн бодлого үгүйлэгдэж байна.

2.5 Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн асуудал

Монгол Улсын хувьд МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд арчиллыг улам төгөлдөржүүлж, сайн засаглалыг төлөвшигүүлэх, ил тод нээлттэй байдлыг хөгжүүлэх, хариушлагатай, ёс зүйтэй улс төрийг батжуулах, иргэний арчилсан нийгмийг төлөвшигүүлэхэд эмэгтэйчүүд чухал үүрэг гүйцэтгэх ёстой.

Жендерийн эрх мэдлийг хуваарилалт хуулиар баталгаажсан хэдий боловч амьдралд бодитой хэрэгжих таатай орчин бүрдээгүй, бүрдтэл нилээд хугацаа шаардагдах нь сүүлийн 2 удаагийн парламентийн сонгуулийн дүнгээс харуулав. Энэ нь өнөөгийн манай нийгэмд жендерийн үүрэг хариушлагыг хуваарилах бодлогын чиг хандлага бодитой хэрэгжиж чадахгүй байгаагийн нэг илрэл юм.

Эмэгтэйчүүдийн улс төрийн ба удирдах түвшинд оролцох оролцоо өмнөх тогтолцооны үеэс буурсан гажуудлыг арилгах чиглэлээр Жендерийн тэгш байдлыг хангах үнлэсний хөтөлбөр болон Мянганы хөгжлийн зорилтод эмэгтэйчүүдийн төлөөллийг улс төрийн удирдах болон шийдвэр гаргах түвшин, түүнчлэн, төрийн удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 2015 он гэхэд 15-30-д хүргэх зорилт тавьсан билээ.

Төрийн алба хаах тэгш боломж

Албан тушаал ахих тутам эмэгтэйчүүд цөөнх болдог. Судлаачдын дүгнэж байгаагаар “эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд ажиллахын тулд олонд танигдах, танигдахын тулд өндөр алба хаших хэрэгтэй”¹⁸ гэжээ.

Төрийн захиргаанд өндөр албан тушаал хашиж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь хангалтгүй байна. 2006 оны байдлаар төрийн захиргааны албан хаагчдын 53.7 хувийг эзэлж буй эмэгтэйчүүд, тэргүүн түшмэлд 0.2 хувь, эрхэлсэн түшмэлд 1 хувь нь алба хашиж байгаа нь Төрийн албаны тухай хуульд “иргэнд хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албандаа орох адил тэгш боломжтой байх” зарчим эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд ижил тэгш үйлчилж байгаа гэж үзэх нь өрөөсгөл байна. Энэ нь эмэгтэйчүүд төрийн алба

18 Б.Тогтохбаяр, Монголын хэвлэл мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх: өчигдөр, өнөөдөр, “Жендерийн хэвшмэл ойлголт, улс төр ба хэвлэл мэдээлэл” бага хурал, 2007 оны 6 дугаар сарын 16-ны өдөр.

хаших тэгш боломжоор хангагдахгүй, тэдний сонгуульд нэрээ дэвшүүлэх, сонгогдох эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байгаа юм.

Хүснэгт 4. Төрийн захиргааны албан тушаал, хүйсээр, 2006 он

Албан тушаалын ангилаал, хүнээр

	Бүгд	Үүнээс эмэгтэй	Эмэгтэйчүүдийн эзлэх хувь
Тэргүүн түшмэл	72	10	13.8
Эрхэлсэн түшмэл	288	53	18.4
Ахлах түшмэл	1626	681	41.8
Дэс түшмэл	5216	3130	60.0
Туслах түшмэл	2261	1208	53.4
Бүгд	9463	5082	53.7

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөлийн ажлын алба, 2005 он

Зураг 4. Монгол Улсын төрийн захиргааны албан хаагчдын тоо, түүнд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин



Эх сурвалж. Монгол Улсын статистикийн эмхтгэл, YСГ, 2006 он

Манай орны улс төрийн болон удирдах өндөр албан тушаалд 2006 оны байдлаар эмэгтэйчүүд зөвхөн 5.2 хувьтай байгаа нь МХЗ-д дэвшүүлсэн зорилтын хэрэгжильт хангалтгүй, улмаар Монголын эмэгтэйчүүдийн боловсрол, мэргэжлийн түвшинтэй харьцуулбал энэ нь шударга бүс, хөгжил дэвшил дэх эмэгтэйчүүдийн үүрэг оролцоог дутуу үнэлж байгаагийн нэг илрэл гэж үзэх үндэслэлийг бий болгож байна.

Хүснэгт 5. Улс төрийн болон удирдах өндөр албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн тоо

Улс төрийн болон удирдах өндөр албан тушаал	2000 он		2006 он	
	Нийт	Үүнээс эмэгтэй	Нийт	Үүнээс эмэгтэй
Монгол Улсын Ерөнхийлөгч	1	0	1	0
Монгол Улсын их хурлын дарга	1	0	1	0
Ерөнхий сайд	1	0	1	0
Улсын их хурлын дэд дарга	1	0	1	0
Улсын их хурлын гишүүн	76	9	76	5
Засгийн газрын гишүүн	11	1	18	1
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	1	0	1	0
Дэд сайд	11	1	18	0
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	2	1	2	1
Аймаг, нийслэлийн Засаг дарга	22	0	22	0
Төрийн тусгай газрын дарга	10	1	10	1
Нийт	137	13	151	8
Эмэгтэйчүүдийн эзлэх хувь		9.4		5.2

Эх сурвалж: Зохицой хөгжлийн жендер төв, Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо судалгаа, 2006 он

Эмэгтэйчүүдийн сонгогдох эрх ба түүний баталгаа

Эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг ИУТЭОУП¹⁹, ЭАБХҮК²⁰, ЭУЭК²¹, АУАБХҮК²² зэрэг олон улсын гэрээгээр баталгаажуулсан бөгөөд Монгол Улс нь соёрхон баталсан тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх²³ үүрэгтэй. Түүнчлэн, сонгогдох эрх нь Монгол Улсын Үндсэн хууль (Арванзургадугаар зүйлийн 9), Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай (6, 28.2 дугаар зүйл), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай (4 дүгээр зүйл), Орон нутгийн сонгуулийн тухай хуулиар (7 дугаар зүйл) тус тус баталгаажсан.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн сонгогдох эрх нь хуулийн хүрээнд баталгаажсан хэдий ч эдийн засаг, улс төр, нийгмийн салбарт энэ баталгаа нь хангалтгүй түвшинд байж, улмаар эмэгтэйчүүдийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй байгаагийн эсрэг төрөөс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг болох тусгай арга хэмжээг авагдахгүй байгаатай холбоотой юм.

Монгол Улс нь ардчилсан хэлбэрээр ҮИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг 4 дэх удаа зохион байгуулж байгаа ч сонгогдох эрхийн хэрэгжилт, тэр дундаа эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийн хэрэгжилтийн байдлыг төрийн зүгээс тусгайлан судалж, дүн шинжилгээ хийн, дараагийн сонгуулийн үйл явцад хэрэглэх ямар ч стратеги төлөвлөгөөгүй хэрэгжүүлж байна.

2006 онд (2004 оны сонгуулийн дүнгээр) 6.5 хувьтай байгаа нь 2000 онд хүрсэн амжилтаасаа ухарчээ. Үндэсний парламентад сууж буй эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх боллогыг түүштэй дэмжихгүй бол 2015 онд 30 хувьд хүргэх зорилтоо хангаж чадахгүй юм.

19 Иргэний улс төрийн эрхийн олон улсын пакт, A/RES/2200 A, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1948 он, Монгол Улс 1974 онд соёрхон баталсан. www.legalinfo.mn вэбсайтаас үзэх боломжтой (2007.06.15) 29 дүгээр зүйлийн а, б заалт


20 Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, A/RES/34 180, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1979 он, Монгол Улс 1981 онд соёрхон баталсан. 7 дугаар зүйлийн “а”

21 Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц, A/RES/640 (VII), НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1952 он, Монгол улс 1954 онд соёрхон баталсан. 1,2 дугаар зүйл

22 Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, A/RES/2106 A, НҮБ-ын Ерөнхий Ассамблей, 1965 он, Монгол Улс 1969 онд соёрхон баталсан. 5 дугаар зүйлийн “с” заалт

23 Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он, Аравдугаар зүйлийн 2-дахь хэсэгт

Зураг 5. Үндэсний парламентад нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь



Мэдээллийн эх сурвалж: Сонгуулийн ерөнхий хороо, 2004 он.

Өнөөгийн байдааар аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 24.6-д хүрсэн нь орон нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх харьцангуй өндөр, нийгэмд танигдсан, нэр хүндтэй, чадавхитай эмэгтэйчүүд олон байгааг илэрхийлж байна. Гэсэн ч эдгээр эмэгтэйчүүдийн парламентын сонгуульд өрсөлдөх боломж хязгаарлагдмал, сонгуульд нэрээ дэвшүүлэхэд тэдний, нэр хүндээс үл хамаарсан тогтолцооны доголдлын хүчин зүйл үйлчилж байна.

Зураг 6. ҮИХ, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, 2006 он, хүйсээр



Эх сурвалж: УСГ, 2006 оны эмхтгэл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн товchoон, CEX, 2005 он.

Тайлбар: Сум дүүргүүдийн ИТХ-ын төлөөлөгчдийн нийт тоо 6720 боловч Сүхбаатар аймгийн зарим сумдын дүн хүйсээр байгаагүй тул энэ аймгийн судалгааны дүнг хасаж, үлдсэн сум, дүүргээр гаргасан.

2006 оны байдааар ҮИХ-ын гишүүдийн 6,6 хувь нь эмэгтэйчүүд, аймаг, нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн 14 хувь нь эмэгтэйчүүд, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн 29,3 хувь нь эмэгтэйчүүд байна.

Бүх шатны ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга нарын 13.9 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба энэ нь зөвхөн сум, дүүргийн ИХТ-ын тэргүүлэгчдэд эзэлж буй хувь юм. Аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргад эмэгтэйчүүд байхгүй, орон нутгийн удирдлагын түвшинд

эмэгтэйчүүдэл шийдвэр гаргах эрх мэдэл, боломжгүй байна.

Хүснэгт 6. УИХ-ын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдийн эзлэх хувь, бүсээр

Бүс	УИХ		Аймаг, нийслэлийн ИТХ		Сум, дүүргийн ИТХ	
	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй	Эмэгтэй	Эрэгтэй
Баруун бүс	7.1	92.9	7.14	92.86	17.22	82.78
Зүүн бүс	12.5	87.5	15.56	84.44	36.29	63.71
Төвийн бүс	0.0	100.0	17.28	82.72	25.21	74.79
Хангайн бүс	0.0	100.0	14.60	85.40	29.29	70.71
Улаанбаатар	15.0	85.0	15.00	85.00	38.04	61.96
Нийт	6.6	93.4	14.0	86.0	29.3	70.7

Эх сурвалж: Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн товчоон, CEX, 2005, 2004 онуудын УИХ-ын сонгуулийн дүн, CEX-ны шахим хуудас.

УИХ-ын 1992, 1996, 2000, 2004 оны сонгуулийн дүнгээс сонгогдсон эмэгтэй гишүүдийг нэр дэвшсэн эмэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэй нэр дэвшигчдийн эзлэх хувь байнга өсч, харин сонгогдсон эмэгтэйчүүдийн хувь буурсан байна.²⁴

Манай улс хууль тогтоох дээд байгууллагад сонгогдон ажиллаж буй эмэгтэйчүүдийн оролцоогоор дэлхийн 189 орноос 147-д жагсаж, сүүл мушгиж,²⁵ азийн бусад орнуудын 15.1 дунджаас даруй 2 дахин бага байна.²⁶

Хүснэгт 7. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид болон сонгогдсон гишүүд

1992, 1996, 2000, 2004 онуудад

Онууд	УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид		УИХ-д сонгогдсон гишүүд	
	Нийт	Үүнээс эмэгтэй	Нийт	Үүнээс эмэгтэй
1992	298	23	76	3
1996	302	28	76	7
2000	603	66	76	9
2004	249	33	76	5

Эх сурвалж: Монгол Улсын сонгуулийн ерөнхий хороо, 2006 он.

1992 оны сонгуулиар УИХ-д МАХН 69 суудал авснаас 3 эмэгтэй, Ардчилсан эвсэл 6 суудал /MYAH –4, МСДН-2/ бус над болон бие даагчдаас 1 суудал авчээ.

1996 оны сонгуулиар УИХ-д Ардчилсан холбоо эвсэл 51 суудал авснаас 6 нь эмэгтэй, 1998 оны нөхөн сонгуулиар дахин 1 эмэгтэй буюу 7 эмэгтэй, МАХН 25 суудал авснаас 1 эмэгтэй, нийт 8 эмэгтэй сонгогдов.

2000 оны сонгуулиар МАХН үнэмлэхүй олонхи буюу 72 суудал авснаас 7 эмэгтэй, 2001 оны нөхөн сонгуулиар дахин 1 эмэгтэй, ИЗН-аас 1 суудал авсан нь эмэгтэй төлөөлөл байлаа. 2000 оны сонгуулиар нийт 9 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогджээ.

2004 оны сонгуулиар МАХН хамгийн олон суудалтай буюу 35 суудал авснаас 3 эмэгтэй, ИЗН-аас 2 суудал авснаас 1 эмэгтэй, Ардчилсан эвслээс 1 эмэгтэй нийт 5 эмэгтэй УИХ-ын гишүүнээр сонгогдов.

Засгийн газраас 1999 онд ЭАБХҮК-ийн хороонд хүргүүлсэн үндэсний илтгэлдээ “эмэгтэйчүүдийн оролцоо, шийдвэр гаргах түвшинд бага байгаагийн нэг шалтгаан нь

24 Т.Амгалан. “Мянганы хөгжлийн зорилт: Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо: Жендерийн хэвшмэл ойлголт, улс төр ба хэвлэл мэдээлэл, бага хурал, 2007 оны 6 дугаар сарын 16-ны өдөр.

25 Үндэсний парламент дэх эмэгтэйчүүд <http://www.ipu.org/wmn-e/arc/classif300906.htm> (2007.06.08)

26 15-тай ижил

эмэгтэйчүүдийн идэвхи санаачлага султай холбоотой” гэжээ.²⁷ Гэтэл сонгуульд нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн тоо жил ирэх тутам өсөж байгаа нь эсрэгээр эмэгтэйчүүд идэвхитэй байгааг харуулж байна.

Харин НҮБ-ын ЭАБХҮК-ийн хороо, Монгол Улсын Засгийн газрын 3,4 дүгээр ээлжит илтгэлийг хэлэлцээд, зөвлөмжид “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо бага байгаа болон түүнд Засгийн газраас тодорхой алхам хийгээгүй болоход шүүмжлэлтэй хандсан.²⁸ Тус зөвлөмжид эмэгтэйчүүдийн боловсролын салбарт үзүүлсэн өндөр амжилт нь хууль тогтоох, гүйцэтгэх, орон нутгийн хуралд оролцоход нөлөө үзүүлээгүй болохыг тэмдэглэж,²⁹ Засгийн газарт “Эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралд оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий түр тусгай арга хэмжээ авах, олон нийтийг гэгээрүүлэх, хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг авч хэрэгжүүлэх”-ийг зөвлөжээ.³⁰

Хүснэгт 8. УИХ-ын удирдлага, зохион байгуулалт, хүйсээр, 2007 он

	Бүгд	Үүнээс эмэгтэй
Улсын их хурлын дарга	1	
Улсын их хурлын дэд дарга	1	
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	1	1
Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо	1	
Нийгмийн бодлогын байнгын хороо	1	1
Төрийн байгуулалтын байнгын хороо	1	
Төсвийн байнгын хороо	1	
Хууль зүйн байнгын хороо	1	
Эдийн засгийн байнгын хороо	1	
Тусгай хяналтын байнгын хороо	1	
Ёс зүйн дэд хороо	1	
Нутгийн өөрийн удирдлагын дэд хороо	1	
Төсвийн зарлагын хяналтын дэд хороо	1	
Хүний эрхийн дэд хороо	1	
Бүгд	14	2

Эх сурвалж: УИХ-ын мэдээлэл судалгаа, лавламжийн алба. 2007 он

Гэвч олон улсын зөвлөмжийг үл харгалзан, Монгол Улсын МХЗ болох 2008 онд 20 хувь, 2012 онд 35 хувьд сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн тоог хүргэх зорилтоо умартан 2007 оны 12 дугаар сард УИХ-ын сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийн квотыг (30%) цуцлав. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй, эрэгтэйчүүдийн ялгаатай байдлыг арилгахад түр тусгай арга хэмжээг авах нь зайлшгүй болохыг олон улс орнууд хүлээн зөвшөөрсөн байдаг. 2006 оны байдлаар хууль тогтоох дээд байгууллагын сонгуульд нийт 50 орон үндсэн хууль, сонгуулийн хуулиар квот тогтоосон байдалтай байна.³¹

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад үндэсний ухамсар сэргэхийн хамт уламжлал, ёс заншлаа дээдлэх хандлага улам хүчээ авч, жендерийн хэвшмэл ойлголтыг улам бэхжүүлж, олон нийтийн жендерийн тэгш байдлын ойлголт, түүнд хандах хандлагад сөргөөр нөлөөлж, улмаар улс төрийн намуудын бодлого ч нөлөөлөх боллоо. Сонгуулийн үеэр ардчилсан

27 ЭАБХҮК-ийн хэрэгжилтийн талаархи ЗГ-ын 3,4 дүгээр ээлжит илтгэл, МУЗГ, CEDAW/C/MNG/3-4, 1999 он
[http://www.unhchr.ch/tbs/doc.nsf \(2007.06.12\), pp 7](http://www.unhchr.ch/tbs/doc.nsf (2007.06.12), pp 7)

28 Зөвлөмж, НҮБ-ын ЭАБХҮК-ийн холбоо, 2001 он, A/56/38 (Part 1), 249-р фараграф

29 Тэмдэглэл 23, 249-р фараграф

30 Тэмдэглэл 23, 260-р фараграф

31 [http://www.quotaproject.org/faq.cfm \(2007.06.20\)](http://www.quotaproject.org/faq.cfm (2007.06.20))

сонгуулийн зарчим ихээхэн алдагдаж эхэлсэн нь бүх л сонгогдогчид, сонгогчдын эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй, энэхүү сөрөг үр дагаврыг илүүтэй эмэгтэй нэр дэвшигчид хүртэх магадлал өндөр болов.

2.6 Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх үйл хэрэг дэх жендерийн үзэл баримтлал

Монгол Улс МХЗ-дад тодорхойлсон “Хүний эрх, шударга ёсыг тогтоох, сайн засаглалыг бэхжүүлэх” дэвшүүлсэн зорилгод жендерийн шударга ёсыг тогтоох асуудлыг хамруулах явдал юм.

Жендерийн шударга ёс, тэгш эрхийн үзэл баримтлал нь гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, тэгш сонголт, үр дүнгийн тэгш байдлын тухай асуудалтай нягт холбоотой байдаг.

Монгол Улс Үндсэн хуульдаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрхийг баталгаажуулж, Засгийн газар эмэгтэйчүүдийн эрх, тэгш байдлыг хангах олон улсын конвенциудад нэгдэн орж, засгийн газраас жендерийн тэгш байдлыг хангах асуудлаарх Үндэсний хороог байгуулсан нь тэгш байдлыг дэмжих, таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаагийн илэрхийлэл билээ.

Гэвч нийгэмд жендерийн тэгш бус байдал, шударга ёс алдагдаж, өнөөдөр баян, ядуу, эмэгтэй эрэгтэй, хөгшин, залуу, нийгмийн эрх дарх бүхий бүлгүүд, гадуурхагдсан хэсгүүдийн хооронд бий болсон тэнцвэргүй эрх мэдэл, шударга бус байдал нь ядуурлыг бууруулах, жендерийн тэгш байдлыг хангах, сайн засаглалыг бэхжүүлэх, хүний эрхийг баталгаажуулах боломжийг улам бүр хязгаарлаж байна.

Жендэрт суурилсан хүчирхийлэл

Төр засаг тууштайгаар анхаарлаа хандуулж чадахгүй байгаа хүний эрхийн томоохон асуудал нь жендерт суурилсан хүчирхийлэл, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх асуудал юм. Жендерт суурилсан хүчирхийлэлд нийгэм, эдийн засаг, газар зүйн байршил, хил хязгаар байхгүй бөгөөд энэ нь жендерийн тэгш бус байдлын илэрхийлэл болж байдаг.³²

Жендерийн ялгаанаас үүдэлтэй хүчирхийлэл нь дийлэнхдээ эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн байдаг нь олон судалгааны дүнгээс харагддаг. Хэдийгээр энэ нь нийгэм ба хувь хүнээс шалтгаалан янз бүрийн хэлбэрээр илэрч болох боловч мөн чанар нь гэр бүл, нийгмийн харилцаан дахь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш бус харилцаанд байдаг.

Манай улсад жендерт суурилсан хүчирхийлийн асуудлын хүрээнд эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэж буй гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг зэргийн талаар нилээд яригдаж байна. Хамгийн аюултай нь, жендерт суурилан хүчирхийлэл нийгмийн харилцааны аль ч хүрээнд тохиолдоор байна.³³

Хүний эрхийн томоохон зөрчлүүдэд аль нэг хүйсийг нөгөөгөөс нь илт доогуур байдалд оруулан шууд бус ялгаварлан гадуурхах явдал багтдаг. Энэ нь жендерийн хатуу тогтсон хэвшмэл сэтгэлгээтэй шууд холбоотой. Үүнийг таслан зогсоохын тулд шууд болон шууд бус ялгаварлан гадуурхахыг хуулийн хүрээнд тодорхой тусгаж, тайлбарлан, мөрдүүлэх шаардлагатай юм.

Хүний эрхийг баталгаажуулах олон хууль, журам гарч байгаа боловч амьдралд тэр бүр хэрэгжихгүй, олон улсын гэрээ, конвенциид заасан үүргийн дагуу төрөөс нэмэлт арга хэмжээ авахгүй зэрэг байдал нь төрийг эргээд өөрийг нь охид, эмэгтэйчүүдийг хүчээр биеийг үнэлүүлэх явдалыг зохион байгуулж буй бүлэг, этгээдийг шийтгэж чадахгүйд

32 НУБХАС, Дэлхийн хүн амын байдал 2005 оны илтгэл.

33 НУБЭС, ХЭХТ, ХЭҮТ, ЭЯГБХУТКХХҮСТ, “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл ба хууль эрх зүйн орчин” судалгаа, 2002 он.

хүргэж, охид хөвгүүдийг худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэхэд хүчин мөхөсдүүлдэг.

Гэр бүлийн хүчирхийлэл нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн, нийгмийн эрүүл мэнд, эдийн засгийн хөгжилд хүчтэй сөрөг нөлөө үзүүлдэг гэмт хэрэг билээ. Гэтэл өнөөдөр Монголд далд, хэрцгий шинжтэйгээр үйлдэгдэг гэр бүлийн хүчирхийлэл улам нэмэгдэж, цагдаагийн байгууллагад хандсан нийт гэмт хэрэг, зөрчлийн дуудлагын 50 хувийг эзэлж байна³⁴. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг түр хамгаалах байраар 2002-2006 онуудад үйлчлүүлэгчдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байв. Эдгээр хохирогчдын 4 хүн тутмын нэг нь амиа хорлох оролдлого хийж байжээ.³⁵ Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн ихэнх нь жирэмсэн үедээ зодуулдаг байна.

Монгол Улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталсан нь эмэгтэйчүүд гэр бүлдээ айdas түгшүүргүй амьдрах эрхийг төрөөс баталгаажуулж өгсөн чухал алхмын нэг болсон төдийгүй нийгмийн энэхүү сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх тогтолцоо, арга хэрэгслийг бүрдүүлэх эх сүурь тавигдсан. Гэсэн хэдий ч хуулийг батлаад нэлээд хэдэн жил болж байхад төрийн байгууллагуудын ойлголт ялгаатай, чадавхи бүрдээгүй байгаагаас хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Олон нийтийн хэвлэл мэдээлэл дэх жендерийн асуудал

Жендерийн тэгш байдлыг хангах урт хугацааны үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд мэдээллийн хэрэгслийг өргөнөөр татан оролцуулах, тэлгээрийн үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, хэвлэл мэдээллийн хөтөлбөрийн бодлого, үйл ажиллагааны жендерийн мэдрэмжийг сайжруулах талаар олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тусгайлан заасан байдаг.

Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөх бүрт хүмүүсийн итгэл үнэмшил, үзэл бодол, үнэт зүйлс, амьдралын үнэлэмж нэгэн адил өөрчлөгдөж байдаг. Өнөөдөр бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл, ялангуяа интернэт мэдээлэл нь хүмүүсийн үзэл бодол, охид хөвгүүдийн амьдралын хэв маяг төдийгүй төр засгийн бодлогод бодитой нөлөө үзүүлж чадаж байна.

Аливаа хүний нэр төр нь нийгмийн үнэт зүйл болдгийг бид бүхэн мэднэ. Хэвлэл мэдээллээр хувь хүний амьдралыг бичихдээ тодорхой хил хязгаартай байх сэтгүүл зүйн ёс зүй алдагдаж байгааг бид харж байна. Mash олон хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд эмэгтэйчүүдийн амьдралын олон талт байдал, идэвхитэй үйл ажиллагаа, нийгмийн хөгжлийн бүхий л үйл явцад оруулж буй хувь нэмрийг нь зохистой, тэнцвэртэй байдлаар үзүүлэх тал дээр дутагдалтай ажиллаж байна.

Хэвлэл, мэдээлэл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх, эмэгтэй хүний тухай нийтлэл, нэвтрүүлэг, нэн ялангуяа хүчирхийлэлтэй холбоотой мэдээ мэдээлэл тэлгээрийн эрхийг хамгаалах талаас нь бус, харин сөргөөр дүрслэх, буруутгах байдлаар илэрхийлэх хандлага газар авчээ. Энэ нь эмэгтэйчүүдийг нийгмийн амьдралд оролцоход сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй нийгэмд тогтсон жендерийн хэвшмэл ойлголтыг арилгах бус, хэвээр байлгахад түлхэц болж байна. Тухайлбал, эмэгтэй улс төрчдийн талаар өгүүлсэн мэдээллийн судалгаанд дүгнэлт хийхэд судлагдсан нийт мэдээ, материалын 20 гаруйхан хувьд эмэгтэй улс төрчдийг эерэг талаас, 7 хувьд нь төвийг сахисан, харин 70 гаруй хувьд сөрөг талаас өгүүлсэн байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөрийн чиг хандлагыг жендерийн мэдрэмжтэй болгох үүднээс одоогийн явуулж буй бодлогод жендерийн дүн шинжилгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай байна. Хэвлэл мэдээллийн хүрээнд

34 ХЭҮТ, ЗХЖТ “Гэр бүл дэх хүчирхийлэл-Цагдаагийн ажилтын санаа бодол” судалгаа, 2004 он.

35 ХЭҮТ-ийн төр хамгаалах байрны үйлчилгээний мэдээллийн сан, 2006 он.

жендэрийн тэгш байдлыг хангах нийгмийн ухамсрыг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхүйц чадавхийг бүрдүүлэх нь эргээд нийгэмдээ чухал ач холбогдолтой юм.

Өмчлөх эрх ба жендэрийн асуудал

Өмчлөх эрхийн эдийн засгийн ухагдахууны хувьд жендэрийн холбогдолтой асуудлыг хөндөх нь чухал. Эд хөрөнгө болон орлоготой харьцах харилцааны хэлбэрийг тухайн хөрөнгө буюу орлогыг өмчлөх эрхээс ялгах хэрэгтэй. Хэдийгээр хуулиар өвлөх эрх нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хувьд адилхан ч, эмэгтэйчүүд өмчлөх эрхээ эдлэхгүйн зэрэгшээ, сайн дураараа татгалзах явдал гарч байна.

Монгол Улсын хуулиар эмэгтэй хүн гэрлэж байж, газар эзэмших эрхтэй байна. Хөрөнгө эзэмших жендэрийн ялгаа нь хуулиар заасан эрхээ эдлэх хэрэгжилтийн үйл явцад илүү илэрч байна. Өнөөдөр гэр бүлийн хөрөнгө хоёр төрлийн эд хөрөнгөөс бүрдэж, гэр бүлийн хуваарыг хөрөнгө³⁶, гэр бүл хамтран амьдарсан хугацаанд бий болох хөрөнгө буюу хамтран өмчлөх хөрөнгө хамаардаг. Гэр бүлийн өмчлөх эрхийн тухай хуулийн заалт нь жендэрийн гажуудлыг бий болгосон³⁷ төдийгүй бусад хууль, журмуудтай зөрчилдэж байна.

МХЗ-уудыг жендэрийн өнцгөөс харж дүгнэлт хийх нь Монгол Улсын МХЗ-ууд болон МХЗ-уудад суурисан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг амьдралд хэрэгжүүлэхэд ихээхэн чухал ач холбогдолтой. Эцэст нь бодлогын зорилтуудын үр дүн, үр нөлөө нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн амьдралын чанарт гарсан өөрчлөлтөөр хэмжигдэнэ. Иймд МХЗ-уудын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, жендэрийн үзэл баримтлалыг үйл хэрэг болгох улс төрийн хүсэл эрмэлзлийг төлөвшүүлэх, хүйсээр ангилсан тоо мэдээлэл, баримтуудыг гаргах, боловсруулах, дүн шинжилгээ хийх ажлуудыг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай. Энэ нь МХЗ-ууд болон жендэрийн тэгш байдлыг хангах бодлогын эцсийн үр дүнг илүү бодитой болгоход нөлөөлнө.

36 ИХ-ийн 127 дугаар зүйл, Гэрлэхийн өмнө олж авсан эд хөрөнгө, өв, бэлэглэлийн журмаар олж авсан гэр бүлийн гишүүний хуваарыг хөрөнгө.

37 ИХ-ийн 129 дүгээр зүйлийн 129.5-д гэр бүлийн гишүүнд ноогдох эд хөрөнгийн хэсгийг тодорхойлохдоо гэрийн ажил хийх, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг жендэрийн холбогдолтой үндэслэлийг заагаагүй байдаг.

БААСТЫН БОЛД-ЭРДЭНЭ



Олон улсын сэтгүүлч. Сэтгүүл зүйн доктор, дэд профессор. МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн багш, Монгол Улсын ЕТГ-ын Хэвлэл мэдээллийн албаны дарга.

Эрдэм шинжилгээний ажил, судалгааны бүтээлүүд

“Олон нийтийн улс төрийн ухамсар төлөвшихөд сонин хэвлэл нөлөөлөх нь” нэг сэдэвт зохиол (1999),
“Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл” нэг сэдэвт бүтээл (1999)
“Реклам, харилцаа, билэгдэл” сурх бичиг (2001)
“Телевизийн реклам” гарын авлага (2002)
“Сонини дизайн” сурх бичиг (2004)
“Олон нийтийн харилцаа” сурх бичиг (2007)
“Сэтгүүл зүйн сургалтын өнөөгийн байдал” (1998)

“Өдөр тутмын сонинуудын нийгэм-улс төрийн сэдэвтэй мэдээний эх сурвалжийг судлах нь” (2000)

“Сэтгүүл зүйн сургалтыг боловсронгуй болгох нь” (2001)

“Олон нийтийн санал бодол, чөлөөт хэвлэлийн төлөвшил, хандлага», 2002

“Сэтгүүлзүйн сургалтын стандарт” 2004

МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ЭРХ, ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛД

Амьдрал хэмээгч үл төгсөх зөрчил, зөвшилцөл тэдгээрийн үр дагаврын дунд хувьсан өөрчлөгдөж байdag амьд ертөнц юм. Тэр дундаа үзэл бодол, санаа сэтгэл, эрх ашиг, сонирхол тэр бүг хэл амт таашаалыг хүртэл агуулдаг оюун санааны нийцэл хийгээд үгүйсгэлийн орон зайд хязгаар үгүй билээ. Нийгмийг хүн бүтээж, түүний үнэлэмж хандлага, ойлголт төсөөллөөр оршин тогтнож байдгийг эш болговоос хичнээн хүн зон байна төчнөөн сайн муу, сайхан муухай, үнэн худал байх нь ойлгомжтой. Тэгэхлээр хүмүүн бидэнд үнэн, зөв үзэл хандлага тэр байг гэхэд голч баримжаа юу юунаас илүү чухал болох нь. Энэ л өнцөг, “ценх”-оор хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн өмнө, хэрэглэгчийнхээ өмнө үүрэг хариуцлага хүлээж, тэр түвшин, хүрээгээрээ эрх мэдлийн тогтолцоо болж байх учиртай. Нэн ялангуяа нийгмийн шинэ орчин ахуй, үнэлэмж, сэтгэхүйн өөрчлөлт бүхий шилжилтийн энэ цаг үед үнэнийг мэдэх нийгмийн “эрх”, түүнийг хүргэх хэвлэлийн “үүрэг” онцгой нөлөө бүхий болоод байна.

Нөгөө талаас нийгмийн шинжлэх ухааны хоёр өөр хандлага болох бие хүнийг дээдлэгч эсхүл хамт нийтийн дэг журмыг онцлох тухай үзэл баримтлалын дунд хэвлэл мэдээллийн хэрэгслийнхээ үүрэг, байр суурийг томьёолох сонголтын өмнө аргагүйдээд байгаа нь бидний үнэн. Энд асуудлын мөн чанар нэг талаас нүүдэлчдийн, дорнын төр засаг, бүлэг зиндааг дээдлэдэг сэтгэхүй болон зах зээлийн, ардчилсан нийгмийн хувь хүний бие даасан байдлыг онцолдог амьдралын хэв маягийн дунд тодорхойгүй орхигдоод байна гэсэн үг. Мэдээж хамт нийтийн онол нь дорны ухааны эш үндэстэй нийцэн, нийгмийг бие хүнээс илүүд үздэг ч, харамсалтай нь төгсгөл нь коммунизм, фашизм хэмээх нийгмийг инженерчлэгч үзэл санааны туйлшралд хүргэдэг аюултай, харин бие хүнийг дээдлэх нь бидэнд дэндүү хол, язгуургүй байгаа нь бас тойрохын аргагүй үнэн...

Тиймээс бие хүнийг дээдлэгч үзэл номлолын зарчимд тулгуурлан, хамт нийтийн зарим нэг “санааг” хүлээн авах нь юу юунаас илүү зөв болоод байна. Үүнийг ч нийгмийн өмнө хариуцлагатай сэтгүүл зүйн онол хандлага агуулж чадлагаараа тоталитар хандлага уруу хэлбийх аюулыг тойрч гарсан юм. Энэ нь хэт төвлөрөл, төрийн хяналт зохицуулалт

нь дарангуйлал уруу зайлшгүй хөтлөхийг мэдэrsэн улс төрийн боллогын төдийгүй хэвлэл мэдээлийнхэн зөвхөн ашиг орлого бус нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариушлагаа ухамсарласны үр дүн гэж үздэг. Түүнчлэн, өнгөрсөн зууны сүүлийн хагаст эдийн засгийн хүрээнд ч үйлдвэрлэгчид, худалдаачид хувийн эрх ашиг, сонирхлоо дээдэлснээр нийгмийн баялгийг бүтээдэг тухай үзэл, итгэл үнэмшлээ залруулж, нийгмийн өмнө тодорхой хариушлага хүлээх болсноо зөвшөөрсөн юм.

Гэхдээ хэвлэлийнхний хувьд өв уламжлан ирсэн “хязгааргүй” эрх чөлөөгөө, хариушлагаар солих нь амаргүй замаар явж ирсэн юм. Бүр XIX зууны дунд үеэс эхэлсэн боловсролтой, өөрийн гэсэн амьдралын зарчимтай уншигчдал татагдах болсон сэтгүүлзүйн зарим төлөөлөгчид мэргэжлийн ёс зүйн мөрдлөгийг санаачилж байсан эхлэл, сургалтын тогтолцооны төлөвшил, Ж.Пулицерийн нийгмийн эрх ашгийг хамгаалан бизнесээ өргөжүүлсэн туршлага энэ бүхэн шинэчлэлтийн хөдөлгөгч хүч нь байлаа. Гэвч үйл явц тийм ч санаснаар, хурдан өрнөөгүй бөгөөд 1947 онд гарсан Хэвлэл эрх чөлөөний асуудал эрхэлсэн комиссын илтгэлээр сая асуудал тодорхой болсон юм. Комисс орчин үеийн нийгмийн шаардаж буй мэдээлийн орчинд зайлшгүй баримтлах ёстой таван үндсэн эрэлтийг тодорхойлжээ. Үүнд:

Нэгдүгээрт: комиссын томъёолсноор хэвлэл “цаг үеийн үйл явдлын тухай үнэн бодит, бүрэн дүүрэн, нягтлан үзсэн тоймыг” мэдээлэх үүрэгтэй ажээ. Түүнчлэн, уншигчдал баримт ба үзэл бодлын ялгааг тодотгон зааглан өгч байхыг онцолжээ. Тиймээс мэдээлийг бодитой, хувийн үзэл хандлагаас ангид, бүхий л тал, хүчин зүйлийг тэнцвэртэйгээр нэгтгэн боловсруулах үүрэг хариушлага мэдээлийн хэрэгсэлд зайлшгүй зүйл болов. Комисс ч асуудлыг бүр тодорхойгоор “Нийтлэгдэж буй баримт үнэн байх нь хангальтай биш. Одоо баримтын тухай үнэнийг мэдээлэх нь шаардлагатай болжээ” хэмээн томъёолжээ.

Хоёрдугаарт: хэвлэл мэдээлэл нь “нийгмийн үзэл бодол ба байр суурийн солилцооны индэр” байх ёстой ажээ. Нэн ялангуяа томоохон мэдээлийн байгууллагуудад өөрсдийгөө нийгмийн шүүмжлэл, үзэл бодлын солилцооны талбар гэдгээ мартах ёсгүйг онцлон тэмдэглэжээ. Мэдээлийн “аварга”-үүд олон нийтийн санаа бодолд тулгуурлан, нийтлэл нэвтрүүлгийн баримт агуулгаа сонгох, өөрсдийн үзэл, үнэлэмжээр үйл явдал, асуудал хандахаас татгалзах, эзэмшигч, эздийн байр суурийг бус, харин тал бүрийн эх сурвалж, хүчин зүйлийн хүрээнд тайлбар дүгнэлтээ тодорхойлох хэрэгтэй гэжээ. Учир нь либертари үзлийг эхэн үед төр засаг, эрх баригчид нийгмийн чөлөөт дуу хоолойны “дайсан” байсан бол өдгөө томоохон мэдээлийн компаниуд хувь хүний үзэл бодлыг “дарангуйлагч” болж хувирах аюул бодитой болжээ.

Гуравдугаарт: хэвлэл мэдээлийн хэрэгсэл нь нийгмийн бүх бүлэг, давхарга, хүрээний “дүр зургийг” тусгагч, илэрхийлэгч байх ёстой ажээ. Үүнд цагаачид үндэсний шөөнх хөгжлийн бэрхшээлтэй иргэл зэрэг нийгмийн хүрээний тухай үнэн бодит, байр суурь, эрх ашгийг нь тодотгосон мэдээлийн “урсгал”-ын ач холбогдол онцгой болсныг эсвэл тэдний дүр төрх, амьдрал ахуйг сөрөг, худал хуурмаг ойлголт, эсхүл “өрөвдөлтэй” мэтээр төсөөлдөг сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэйг дэлгэрүүлэн тайлбарлажээ.

Дөрөвдүгээрт: нийгмийн эрхэм, үнэлэмж, үнэт зүйлийг илэрхийлэх, баталгаажуулах үүрэг байна. Энэ бол хэвлэл мэдээлийнхний тэргүүн зэргийн нийгмийн өмнө хүлээсэн үүрэг гэжээ. Сонин хэвлэлийн редакцийн нүүр, телевизийн тоймын цаг, кино найруулагчийн шийдэл зэрэг нь нийгмийн үнэлэмжийг илэрхийлэгч, хүндэтгэгч төдийгүй тийм уламжлалыг баталгаажуулагч үүргээр хэм хэмжээ нь тодорхойлогдох ажээ.

Тавдугаарт: нийгмийн мэдээлэл авах, мэдээлэлтэй байх эрхийг хангах ёстой гэжээ. Комиссын үзэж байснаар баримт мэдээлийн үнэлэмж, шалгуур нь цаг үеийн өргөн хүрээний, олон талт байдлаар тодорхойлогдох болжээ. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээлэл

нь аль болох нийгмийн өргөн хүрээг хамарч буй эсэхээрээ л “мэдээллийн эрх чөлөө” хэмээх ойлголтыг тодотгох болно гэсэн үг болжээ.

Нийгмийн өмнө хариушлагатай сэтгүүлзүйн онолоор бол төр засаг хэвлэлийн эрх чөлөөг хянаж хязгаарлах эрх үгүй төдийгүй харин ч түүнийг хөгжүүлэхэд дэм тус болох ёстай гэнэ. Төр засаг нь нийгмийг мэдээллээр хангах сэтгүүлзүйн үйл ажиллагааг дэмжиж, тийм нээлттэй харилцааны орчныг бүрдүүлэх эрх зүйн баталгаа, эдийн засгийн боломж, чөлөөт мэдээллийн эсрэг аливаа үйлдлийн хязгаарлалт зэрэг бодлого, шийдвэрээр нөлөөлөх үүрэгтэй болно. Гэхдээ энэ нь мэдээллийн үйл амьдралд шууд оролцоно, зохицуулна гэсэн үг биш бөгөөд ердөө л үзэл болдоо илэрхийлэх эрх чөлөөг улс төрийн “золиос, өгөөш” болгохгүй байхад тусална гэсэн үг юм. Тэгээд ч тэр хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахгүй, түүнд шууд нөлөөлөхгүй байх нь ёс зүйн үүрэг, зайлшгүй мөрдлөг нь байдаг.

Ийнхүү дээрх зүйл заалтуудаас ч сэтгүүлчийн ажил мэргэжлийн төдийгүй манай нийгмийн харилцаа, улс орны хөгжил дэвшилд ч нэлээд чухал асуудал болоод байгаа “үнэн бодит мэдээллийг түгээх эрх хариушлага”-ын тухай сэдвийг сонгон өөрийн үзэл болдоо тэрлэхээр шийдсэн минь учиртай. Энэ тухай яриа хэдийгээр сэтгүүлч нөхдийн дунд багагүй байдаг ч дахин дахин нягталж, нийгмийн оюун санааны дархлааг бий болгох асуудлын хувьд үнэхээр чухал болоод байгаа билээ. Мөн үнэнийг мэдэх нийгмийн эрхийн өмнө хэвлэл мэдээллийнхэн хариушлага хүлээхийн учир нь нэгдүгээрт: үнэн бодит мэдээлэл үүгүйгээр нийгмийн санаа бодол, цаашилбал, хандлага, үнэлэмж төөрөлдөх, хоёрдугаарт: энэхүү олон нийтийн төөрөгдөл нь манай нийгмийн хөгжлийн жинхэнэ гарш боломжийг бүрхэгдүүлэх, гуравдугаарт: мэдээж энэ бүхэн нь аливаа асуудалд зөв шийдвэр, холч алхам хийхэд саад тээг болсоор байна. Тиймээс улс төрийн болон эдийн засгийн бүлэглэлийн явцуу сонирхлыг бус улс нийгмийнхээ эрх ашгийг дээдэлсэн, хэн нэгний цаг үеийн, зуур бодол сэтгэлд нийцсэн үг тайлбарын туйлшралд авталаа асуудлын мөн чанар, учир шалтгааныг тодотгосон сэтгүүлзүй хэрэгтэй байгааг хэлэх гэсэн юм. Ингээд үнэн бодит мэдээлэл түгээх эрх хариушлагын талаар санал болдоо хэлье.

1. Өнөөдөр улс орны маань тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн талаарх үзэл баримтлалд дэлхий дахинаа өрнөж буй даяарчлал, арчилал, мэдээллийн технологийн эрс шинэчлэлийн давалгаагаар эрс хувьсан өөрчлөгдөж, олон олон шинэ асуулт хариултаа нэхэх боллоо. Гэхдээ энэ бүхэнд хариулт өгөхөд хамгийн чухал нь бил өөр хоорондоо эв нэгдэлтэй, гадаад талдаа идэвхтэй харилцаатай байж гэмээ нь энэ их өөрчлөлтийн давалгаан дунд улс гэр хэмээх хөлөг онгоцоо зөв залуурдаж, бас урагшлах болно. Энэ бол билний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа төдийгүй түүний эх сурвалж юм. Харин тусгаар тогтносон, бүрэн эрхт улс орон байхын учир нь үндэстний сэргэн мандалт, хөгжил дэвшил юм. Мэдээж хөгжил дэвшлийн уг үндэс нь бүтээн байгуулалт боловч түүний өсөн төлжих шимт хөрс нь шударга ёс, хариушлагыг дээдлэх ёс билээ.

Монгол оронд шударга ёс алдагдсан, хариушлагагүй байдал даамжирсан тухай яриа дэндүү их байна. Бүр нүд дасаж, анхаарал татахaa болитол ярьж бичих боллоо.

Гэхдээ шударга ёс, үнэнийг тогтоох нь зөвхөн хууль хяналтын байгууллагын ажил үүрэг гэж ойлгох нь учир дутагдалтай. Үнэний дэns ч дан ганц эрхзүйн баримт бичигт оршдог зүйл биш ээ. Үнэний үр дагавар нийгмийн харилцаа, бодит амьдралын салаа мөчир бүрд ул мөрөө үлдээж, цаг хугацааны их орон зайл эрхшээдэг жамтай. Тиймээс үнэнийг олж, түүнийг цаг үе, нийгмийнхээ сайн сайхан, ирээдүйн хөтөч болгох нь бил бүхний үүрэг, зорилго болоод байна. Үнэний цөм ч нийгмийн амьдралд, хүмүүсийн санаа бодолд, бодит ахуй байдалд байгаа нь хөдөлшгүй нотолгоо. Нөгөө талаар үнэнийг хий хоосон дээдлэн магтаж, шүтэх эсвэл үгүйсгэн тийм зүйл ер байхгүй мэт аашлахын аль аль нь улс нийгэмд ч, хувь хүнд ч хэрэггүй. Харин үнэнийг зөв үед, байх ёстай газар нь тавьж, бэрхшээлтэй,

тулгамдаж буй саад бүхнээ гэтэлгэн арилгагч зам мөр болгох ёстой.

2. Хувь хүн ч тэр, ардчилсан нийгэм ч тэр төгс төгөлдөр бурхны бүтээл биш ээ. Үүнийг бил өнгөрсөн хорь шахам жилийн туулж ирсэн туршлагаасаа, эрт цагийн түүх шастираас ч эргэн харж, ойлгож болно. Алдаа оноо ээлжлэн байдаг нь хүмүүний ертөнцийн жам ёс. Гэхдээ эцсийн эцэст хүн, улс гэр хөгжиж, дэвшиж байсан бас байгаа нь хүмүүний жам ёс. Мөн тэр бүхэнд хөгжлийн хүч, хөдөлгүүр нь үнэн байсан нь бас жам ёс. Үнэн ялж, бүхнийг урагшлуулж зарим үед аажим, зарим цагт эрс хөгжлийг дагуулж ирсэн. Тэгэхлээр нийгэм цаг үеийн маань үнэн гэдэг биднээс, хүнээс хол хөндий, хaa нэгтээ даяанчлан суудаг “гүн ухаантан” биш ээ. Үнэн бидний дунд оршиж, алдаа онооны маань шалтгаан болж байдаг. Энэ бол эртнээс нааш хэлцэж ирсэн алдаа онооны дэнсэн дээр үнэнийг олдог үг, ухааны маань уг сурвалж билээ. Тиймээс бидэнд үнэнийг мэдэх хэрэг, зайлшгүй шалтгаан байна гэсэн үг. Сайн муугаа ил тод ярихаасаа илүү түүнд оршиж буй үнэнийг мэдэх хэрэгтэй байна гэсэн үг.

Энэ үгээрээ би улс нийгмийн энэ чухал хэрэгт сэтгүүлчид та бүхний үүрэг онцгой болж байгааг сануулах гэсэн юм. Үг хэлэх эрх чөлөөний үнэ цэнэ нь ч үнэнийг мэдэхэд оршино. Бид энэ эрх чөлөөг арван долоон жил бартаатай хүнд хэцүү замаар тээж өнөөдрийг хүргэлээ. Оносон мөр алдсан зүйл ч хaa хаанаа байлаа. Одоо бид үнэнийг мэдэх төрөлх эрхийнхээ “ид шид”-ийг үзэх цаг болжээ. Бидний өмнө үнэн худал нь үл мэдэгдэх хов жив, цуурхал, мэдэмхийрэл, үгүйсгэлийн манан байна. Харин тэр манан, харанхуйг гийгүүлэх цорын ганц гэрэл гэгээ нь үнэнийг мэдэх эрх чөлөө л байна. Бид худал гүтгэлэг, хов живийн их хашгираан, хэрүүл тэмцлийн хөлөг онгоц дээр байна. Тиймээс хөлөг онгоц маань хаашаа ч үгүй, дордоо эргэсээр зарим үед хөдлөвч, эргэж хургасаар байна. Тэгэхлээр энэ их дуу чимээг нэгэн зүгт чиглүүлж, гагшүү үнэн үгийг сонсох цаг болжээ. Үүнд л мэдээлэлтэй байх, үзэл бодолтой байх, эрх чөлөөний маань хэрэг гарна. Олон ургальч үзэл, мэтгэлцээн нийгмийн эрүүл саруул чигч хөгжилаа хэрэгтэй ч эцсийн зорилго маань хараахан биш юм аа. Бидний зорилго бол олон янзын үзэл бодол эрх ашгийг тэнцвэржүүлэн нэгтгэж, үнэнийг мэдэх, тэгснээрээ улс гэрийнхээ хөлгийн жолоог зөв залуурдахад оршиж байгаа юм. Энэ зорилго дор үгээ хэлж, үзэл бодлоо илэрхийлэхийн утга шалтгаан байгаа юм. Тэгэхлээр зөв залуур үнэн зөв мэдлэг, мэдээлэлтэй нийгмийн гарп байх нь ойлгомжтой. Тийм үг, үзэл санаа эрдэмтэнд ч, ард иргэдэд ч бүр хүүхэд багачуудад ч ус агаар мэт хэрэгтэй байна.

3. Бидний амьдарч буй цаг үеийн өөрчлөлтийн хурд хэзээ хэзээнээс илүү эрчтэй, хэмнэлтэй болжээ. Байгаль дэлхий, цаг агаар, хүн төрөлхтөн ч бидний санаж байснаас илүү ихээр өөрчлөгдөж байна. Дэлхийн эдийн засаг, улс төрийн харилцаа, улс орнуудын эрх ашиг, сонирхол ч хувьсан шинэчлэгдэж байна. Энэ бүхний үр дагавар болон шинэ шинэ асуудал, бэрхшээл, зорилт биднээс хариу шийдлээ хүлээн даллан байна. Цаг үе, өөрчлөлтийг ойлгоход төрд ч, түмэн олонд ч хялбар бус байна. Өөрөөр хэлбэл, цаг үеэ ойлгох учир шалтгаан, мөн чанар олон тал, өнцөгтэйн дээр хувьсан өөрчлөгдөх нь хурдан түргэн байна.

Тиймээс үнэнийг мэдэх эрх маань магадгүй боломж хүсэл гэхээсээ илүү нийгмийн эрэлт хэрэгцээ, зайлшгүй зүйл болжээ. Тэгэхлээр үнэний эрэлч сэтгүүлчийн нийгмийн өмнө хүлээх үүрэг, оролцоо чухал бөгөөд хариуслагатай болж байна. Тэр дундаа мэдлэг, мэдээллийн эрин зуунд үнэний үнэ цэнэ, нефть, алнаас ч хэд дахин илүү өсч цаашид ч нэмэгдсээр байх нь. Мэдлэг үнэн байж мэдлэг болдог шиг мэдээлэл ч бодитой байх ёстой. Үгүй ядаж монголчууд бидний ярьдгаар “дүн нуруутай” байх учиртай. Өөрчлөлт хувьслаар дүүрэн цаг үеийн мэдээлэл “дүн нуруутай” байж, сая ашигтай, үнэ цэнэтэй болно. Үнийн өсөлт, ядуурал, ажилгүйдэл, авлига манай нийгэмд бүгшсаар байгааг ярих

ёстай. Гэхдээ өнөөдөр эдгээр зүй бус үзэгдлийн учир шалтгаан, уг сурвалжийг бодитой, “дүн нуруутай” нийгэм олон нийтэд хүргэх нь юу юнаас чухал болоод байна. Энэ бүхэн оршиж байгаагийн учир холбогдол, гадаад дотоод хүчин зүйл, нөлөө, үр дагаврыг мэдэх нь чухал байна. Хэн нэгний үгээр, нэгэн зүйл, таамгаар хэтийтгэн туйлширч бүхнийг тайлбарлан, хамгаалах нь хялбар боловч бодит үнэнд нийцэхгүй зүйл болох нь ойлгомжтой. Энэ бол дүн нуруутай тайлбар хандлага ч биш. Даяарчлал, мэдээллийн эрин үед бүр ч учир дутагдалтай үг, тайлбар болно. Тэгэхлээр талхыг цагаан будаагаар биш үр тарианы гурилаар жигнэх ёстайн адил мэдээллийг үнэнээр, үгүй ядаж дүн нуруутай үг тайлбараар бүтээж байж сая хэрэгтэй, ашигтай бүтээл болох нь ээ. Олон түмэн бодит мэдээллийг хүсэн эрэлхийлдгийн учир ч тархи оюуныхаа цангааг тайлахад оршиж буй хэрэг. Үүнийг би мэдээлэл үнэн бодитой байх хариуцлагатай байхын утга учир гэж үзэж байна. Бас олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нийгмийн өмнө хүлээх хариуцлага, үнэ цэнийн чин санаа юм.

4. Хариуцлагатай байна гэдэг ч үүрэг хүлээхийн нэр. Гэхдээ бас эрхтэй гэдгийг нь ч хүлээн зөвшөөрөх ёстай. Үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй байж, үүрэг хариуцлагын тухай ярих нь ойлгомжтой. Тэгээд ч төр засгийн үүргийг нийгмийн мэдээлэл авах, үзэл бодлоо түгээх эрх чөлөөг баталгаажуулж, хамгаалах хэмээн томьёолдог. Тийм ч байх ёстай. Гэхдээ бас нийгэм зөв голч үзэл бодолтой байхын тулд үнэнийг мэдэх эрхтэй. Энэ эрхийг баталгаажуулж хамгаалах нь хэвлэл мэдээллийнхний үүрэг бас эрх мэдэл нь. Харин нийгэм нь олж авсан мэдээллийнхээ хүрээнд өөрийн эрх ашиг, үнэлэмжээ тодорхойлж, түүгээрээ төр засгийг шахаж шаардаж, шүүмжилж бас дэмжиж байх эрхээ эдэлж байх учиртай. Тиймээс ч төр засаг, нийгмийн амьдралыг зохицуулж, хөгжин дэвших таатай орчныг нь бүрдүүлэх үүрэгтэй бөгөөд бас тодорхой эрх мэдэлтэй байхын учиртай. Энэхүү гурвалсан холбоонд л үнэнийг мэдэх үүрэг зорилго, мөн хариуцлагын учир шалтгаан байгаа юм.

Хөөргөн магтах, гүтгэн доромжлохын аль нь ч тэр үнэнд үл нийцэхийн учир ч эрх хариуцлагын холбоонд байна. Цаг үе маань ч үнэнийг мэдээлэх эрх хариуцлагын холбоог сэтгүүлчдээс хүсэж бас шаардаж байна. Мэдээж хариуцлагыг дан ганц сэтгүүлчдээс шаардаж байна гэвэл эндүүрэл болно.

5. Нөгөө талаар өнгөрсөн хориод жилд төр засаг, албан тушаалтны хариуцлагыг сонгуулийн дүн, сэтгүүлчдийн шүүмжлэл, эдийн засгийн хоцрогдол, улс төрийн хямралаар иш үндэс болгон дүгнэж цэгнэж, багагүй ярьж ирсэн. Бүрэн дүүрэн биш ч төрд зохих оноо, дүнг нь өгсөөр ч ирсэн. Харин хэвлэл мэдээллийнхэний үүрэг хариуцлагын тухай саяхнаас ярьж, хэлэлцэж, бодож эхэлсэн нь нууц биш ээ. Тиймээс сэтгүүлчид юу хүссэнээ хэлж, бичиж бас тулгаж түүндээ эрдэж явсан нь нууц биш ээ. Нөгөөтэйгүүр сэтгүүлчдийн хариуцлагын тухай зөвхөн ярих бус бүр бодит зүйл болгох нь цаг үеийн шаардлага болоод байгаа нь нууц биш ээ. Гэхдээ энд хэн нэгэн хүний өмнө, эсвэл улс төрийн намын өмнө бүр төрийн өмнө хүлээх хариуцлагын тухай яриагүй шүү. Сэтгүүлч хүн нийгмийнхээ өмнө, түүний үнэнийг мэдэх эрхийнх нь өмнө хариуцлага хүлээх ёстай гэсэн юм.

Эцэст нь хэлэхэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хүний туйлын дээд эрх зориг, тэр дундаа бусдын эрх ашгаас өөрийнхийг илүүд үзэх, нийгмийн үнэлэмж, дэг журмыг үл ойшоох “дарх” хэмээн ойлгож болохгүй. Бурхнаас хүнд заясан төрөлх хишиг болох эрх чөлөө хэмээх ойлголт нь төр засгийн дарангуйллыг яллах түүхэн үүргээ гүйцэтгээд нэгэнт өнгөрчээ. Тиймээс өнөөдөр бил хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлыг өөрөөр үзэх, эргэн харах нь зайлшгүй зүйл болоод байгаа ажгүү.



ЖУРМЭДИЙН ЗАНАА

Иргэдийн Альянс төвийн захирал. Үндэсний Соёмбо хөдөлгөөний
ерөнхий зохицуулагч, ХЭҮТ-ийн удирдлагын зөвлөлийн гишүүн, МҮОНРТ-
ийн Үндэсний зөвлөлийн гишүүн.

ТЭГШ ЭРХ БА ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТУХАЙ АСУУДЛУУД

Нэг. Жендэрийн тэгш эрхийн хууль ба эрхзүйн хүрээ

1948 оны 12 дугаар сарын 10-нд Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр, төр эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заясан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстой”, 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг ямар ч ялгаваргүйгээр, арьс үндэс, арьс өнгө, **хүйс**, хэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, язгуур угсаа, бусад байдлын ялгааг эс харгалzan ямар ч гадуурхалгүй эдлэх ёстой”, 28 дугаар зүйлд “Хүн бүр энэ тунхаглалд заасан эрх, эрх чөлөөг бүрэн эдэлж болохуйц нийгмийн болон олон улсын дэг журамд аж төрөх эрхтэй” хэмээн тунхагласан.

1974 онд Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 1-д “Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгертээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьс өнгө, **хүйс**, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй”, тус зүйлийн 2-т “Энэ талаар дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж буюу бусад арга хэмжээнд заагаагүй бол энэхүү пактад оролцогч улс бүр өөр өөрслийн Үндсэн хуулийн горим журам болон энэхүү пактын заалтад нийцүүлэн түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагах хууль, тогтоомж буюу бусад шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй” гэж заасан.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө, чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин, шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж баталгаажуулсан.

Монгол Улс хүний эрх, эрх чөлөөний асуудлаарх 40 гаруй олон улсын гэрээ, конвенциид нэгдэн орсон ба Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж баталгаажуулсан.

Дээрхээс гадна хүний эрх, эрх чөлөө, эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш эрхийн асуудлаар олон улс, дэлхийн хэмжээнд зохион байгуулагдаж байсан Бага хурлуудад^{38[1]}, Монгол Улсын Засгийн газар оролцож, тухайн хурлуудаас гарсан шийдвэрүүдийг, НҮБ-ын Тунхаг бичгүүдийг^{39[2]} бодит амьдралд хэрэгжүүлэх, үүний тулд шаардлагатай бүх арга хэмжээ, тухайлан хууль тогтоох, эрхзүйн орчныг бүрдүүлэх үүрэгтэй байдаг.

Түүнчлэн, 2001 онд УИХ-ын 41 дүгээр тогтоол “Хүний эрхийг хангах хөтөлбөр”, 2005 онд 25 дугаар тогтоол “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилт”, Засгийн газрын 2002 оны 274 дүгээр тогтоол “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” зэрэг тогтоолуудаар батлагдсан эрх зүйн эдгээр актууд нь хууль, эрх зүйн зохицуулалтын нэн шаардлагатай бичиг баримтууд болно.

Дээр дурдсан олон улсын болон Монгол Улсын хуульд заасан зарим заалтад үндэслэн Жендэрийн тэгш эрхийн тухай хуулийг боловсруулах, батлах, зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх нь Монгол Улсын үүрэг бөлгөө.

Хоёр. Жендэрийн тэгш эрх ба Хүний эрх

Жендэрийн тэгш эрхийн үзэл баримтлал нь гэр бүл, нийгмийн бүх хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломж, үр дүнгийн тэгш байдлын тухай асуудалтай нягт холбоотой. Тодруулбал, жендэрийн тэгш эрх, хүний эрх хэмээх асуудлууд нь нэг зоосны хоёр талтай адил юм. Ер нь аливаа тэгш байдлын тухай ухагдахуун нь тодорхой байдлаар хийсвэрлэгдсэн сэтгэлгээний үр дүн^{40[5]} бөгөөд тэгш/тэнцүү буюу аливаа тэгшигтгэлийн тухай математик ба геометрийн ойлголтод суурилдаг.

Гэхдээ “тэгш байдлын тухай нийгмийн ойлголт нь математикийн тоон тэнцэтгэл шиг төгс хийсвэрлэгдсэн байдаггүй”^{41[6]}, харин “эрх чөлөөт хүмүүсийн харилцааны тэнцүү чанарт (эквивалент) байдал, харьцуулан жишсэн байдлыг илэрхийлдэг”^{42[7]}, “тийм байдлыг шаарддаг”^{43[8]} байна. Тэгш байдлын философи нь эрх чөлөөт хүмүүсийн (эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн) тэгш байдал, нийтлэг ба түгээмэл цар хүрээ, тэгш хэм хэмжээнд үндэслэдэг.

Тийм учраас математик (тоо, хэмжээ, жин зэрэг) ба геометрийн тэгш (хэмжил зүйн хамаарлын) байдалд суурилсан эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүдийн тэгш байдлын тухай ойлголт нь хүн, нийгмийн хөгжлийн явцад хүний эрх, эрх чөлөө, тэгш эрхийн хэм хэмжээ, зарчим, хандлага, үзэл баримтлалын тэгш байдлын тухай хийсвэрлэгдсэн ухагдахуун болж хөгжсөн. Хүн төрөлхтний төлөөлөл болох эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрх, тэгш байдлыг хангах хууль эрхзүйн орчин бүрдүүлэх эх сурвалж нь гэр бүл, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хүрээнд тэдний “эрх зүйн (тэгш байдлын) этгээд байх чадамжийг хүлээн зөвшөөрөх асуудалтай холбоотой”^{44[9]} ойлголт юм.

38 [1] 1975 он. Мехико хот. 1980 он. Копенгаген хот. 1985 он. Найроби хот. Энэхүү хурлаар “Эмэгтэйчүүдийн дэвшлийн 2000 он хүртлэх алсын хараатай Найробын стратеги”-г батласан бөгөөд түүний гол зорилго нь нийгмийн амьдралын бүх салбарт эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийг ялгаварлах бүх хэлбэрийг устгах явдал гэж үзжээ. 1995 оны 9 дүгээр сарын 4-15-ны өдруүд. Бээжин хотод хуралдсан дэлхийн Дөрөвдүгээр бага хурал. Тус хурал Бээжингийн Тунхаглалыг батласан ба “хөгжлийн үйл явцад эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн татан оролцуулах, тэдний нийгмийн статусийг сайжруулах, сурч боловсрох боломжийг улам өгөн болгохыг” уриалсан байна. 1993 онд Вена хотноо болсон Хүний эрхийн дэлхийн бага хурлаас хүний эрх, тэгш эрх, эмэгтэйчүүдийн эрхийг хангах асуудлыг онцгойлон авч үзсэн.

39 [2] Хөгжих эрх гэдгийг анх 1977 онд НҮБ-ын Хүний эрхийн комиссоос гаргаж байсан ба 1986 онд Ерөнхий Ассемблейгаас “Хөгжих эрхийн тухай тунхаглал”-ыг баталсан. Тунхаглал “хөгжих эрх нь хүн бүрийн салшгүй эрх. Тиймээс хүн бүр хүний эрх, эрх чөлөөг бүрэн хэмжээгээр хэрэгжих эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг буй болгоход оролцох, хувь нэмрээ оруулж, үр шимийг нь хүртэх эрхтэй юм” гэжээ.

40 [5] Д.Лүндээжанцан нар. “Эрх зүйн философи” 2000 он. 12-р тал. (2+2=4, 50% = 50% гэх мэт тэгш байдлыг харуулсан тоон утгатай нэгэн адил ойлгогддог хийсвэр ухагдахуун)

41 [6] Мөн тэнд

42 [7] Мөн тэнд

43 [8] Мөн тэнд

44 [9] мөн тэнд.

Ер нь жендерийн (эрэгтэй, эмэгтэйчүүдийн) тэгш байдлын тухай үзэл баримтлал бол “эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалийн хүйсийн (секс) болон нийгмийн хүйсийн (жендерийн) ялгааг тэгш эрх, тэгш байдлын үзэл баримтлалтай хольж хутгахгүй байх” хэмээх үзэл санаанд тулгуурладаг. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаа, оюун ухаан, бие мах бодь зэрэг бодит ба бодит бус ялгаанууд нь ялгаварлан гадуурхагдах, тэгш бус үзэгдэх учир, шалтгаан биш юм гэдгийг хэлж байна.

Нөгөөтэйгүүр, эрэгтэй хүний муу шинж болгоныг “эмэгтэй хүн шиг, чавганц шиг” гэх, эмэгтэй хүний сайн талуудыг сайшаахдаа “эр хүн шиг гүндүүгүй” гэх, “эр зориг”, “эр хурга” гэх мэтчилэн хүч, чадал, чадварыг эр хүйсээр төлөөлүүлэн билэгдэн ялгаварлах нь тэгш байдал, шударга ёсны үзэл баримтлалд нийшэхгүй ба эрэгтэй, эмэгтэй хүнд байдаг шинж чанарын алиныг нь ч эр (*masculine*), эм (*feminine*) шинж гэж тухайлан ялгахад бэрх^{45[10]}, ингэж үзэх нь эрэгтэйчүүдийн эрх давамгайлсан нийгмийн байгууллын бүтээсэн зохиомол зүйл гэж үздэг.

Эдгээрийг тайлбарлахын мөн чанар бол жендерийн тэгш байдал, жендерийн тэгш эрхийн тухай онол, үзэл баримтлалын учир утга нь угтаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалийн ба нийгмийн хүйсийн хувьд ялгаатай ч үүгээр нь “далимдуулж” ялгавартай хандах буюу ялгаварлан гадуурхаж харьцахыг арилгах, ингэснээр Үндсэн хуульд заасан “ардчилсан, хүмүүнлэг” нийгмийг цогцуулсан хөгжүүлэх зорилгод нийцэж, зохистой хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэхэд хувь нэмэр болно. Өөрөөр хэлбэл, байгалийн хүйсийн болон нийгмийн хүйсийн ялгаатай байдлаасаа болж гэр бүл, төр, зах зээл, олон нийтийн хүрээнд ялгаварлалд өртөх, улмаар шууд ба шууд бус хэлбэрээр хохирох, ашиггүй байдалд байх нь бие хүн, нийгмийн хөгжилд саад болж байгаа олон шалтаг, шалтгааныг арилгах үндсэн арга зам болдог.

Ялгаварлан гадуурхах нь Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид заасан хүний эрхийн эсрэг үйл ажиллагаа болж, ХҮН хэмээх оюун ухаан нандин чанар бүхий биетийг эд, юмсаас дорд үзэж байгаагийн илрэл болдог. Санаа зовоож байгаа асуудлын чухал нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн үзэж, аливаа ялгаварлалыг бүх түвшинд арилгаж чадлаггүйгээс гол төлөв эмэгтэйчүүд баталгаатай эдлэх ёстой^{46[11]} тэгш эрхээ^{47[12]} бодитойгоор эдлэх боломжгүй болоход хүргэдэг.

Гурав. Жендерийн тэгш эрх ба хөгжил

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг улс төр, нийгэм-соёл, эдийн засаг болон гэр бүлийн хүрээнд хангах явдал нь улс орны хөгжилтэй шууд холбоотой байдгийг дэлхийн олон орны жишээн дээр олон судалгаа, дүн шинжилгээгээр баталсан бөлгөө.

Нийгэмд аливаа хүн жендерээр ялгаварлан гадуурхагдсанаас үүдсэн тэгш бус байдал, ядуурал, ажилгүйдэл, хүчирхийлэл, боловсрол ба ухамсын доройтол, хариуцлагагүй үйлдлүүд зэрэг нь тухайн улс орны хөгжилд хүнд цохилт болж, ноцтой саад бэрхшээл учруулдаг.

Ялгаварлан гадуурхалд өртсөн аль ч хүн өөрийн авьяас, чадварыг бүрэн хөгжүүлж чадлаггүй, хөгжүүлж чадсан байлаа ч түүнийгээ бүрэн ашиглаж гэр бүл, улс орныхоо хөгжилд хувь нэмэрлэх тэгш эрхийг эдэлж чадлаггүй. Мөн үүнээс үүдсэн улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын тэгш бус байдал нь оновчгүй, хариуцлагагүй, хүн амын бүлгүүдийн санал бодлыг бүрэн тусгаагүй, явцуу ашиг сонирхол үйлчилсэн ардчилсан бус, хүний

45 [10] Gender equity: Political Feminism goes to School. Lydia Percival Meuret.

46 [11] Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургаа дугаар зүйлд заасан “Монгол улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гэснийг зөрчиж байна.

47 [12] 2002 онд батласан Словян улсын хуулийн 4 дүгээр зүйлд “Жендерийн тэгш эрх гэж эрэгтэй, эмэгтэйчүүд нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах замаар хувийн мэдлэг чадвараа хөгжүүлэх, хөгжлийн үр дүнгээс адил хэмжээгээр хувь хүртэж нийтийн болон хувийн амьдралын бүхий л хүрээнд тэгш оролцох, эрхэйн тэгш байдал, тэгш боломжтой байхыг ойлгоно” гэж томъёолсон байна.

эрхийг зөрчсөн шийдвэр, бодлого гаргахад хүргэж, улмаар авлигын үндэс суурийг бүрдүүлэхэд хүчтэй нөлөө үзүүлдэг. Ийнхүү гаргасан шийдвэр, бодлого зэрэг нь улс орны улс төрийн хөгжилд саад тогтор болоод зогсохгүй нийгэм-соёл, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлдөг нь тодорхой билээ.

Жендэрийн тэгш байдал нь хөгжлийн гол асуудал, хөгжлийн биеэ даасан нэгэн чухал зорилт, стратеги мөн. Жендэрийн тэгш байдлыг хангаснаар аливаа улс орон эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж, үр өгөөжтэй төр, засгийн чадавхийг нэмэгдүүлэн бэхжүүлдэг. Жендер бол нөгөө талаар хөгжлийн үр ашгийн тухай асуудал бөгөөд зөвхөн эмэгтэйчүүдэд хандах улс төрийн зөв зүйтэй бодлого, эсвэл өгөөмөр сэтгэл бишээ. Олон улсад хийгдсэн судалгаануудаас үзэхэд эрэгтэй, эмэгтэйчүүд эрх, эрх чөлөөний байдал харьцангуй ижил байвал эдийн засгийн өсөлтийн хурд илүү түргэн, ядуучуудын байдал хурдан дээшлэх, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдийн амьдрал илүү сайхан, аих аюул багасаж, амгалан амьдрах нөхцлүүд бүрддэг байна.

Хүний эрхэд суурилсан хөгжлийн гол чиглэл нь НҮБ-аас удаа дараа батлан гаргаж байгаа олон улсын эрх зүйн^{48[13]} хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хүний эрхийн асуудалд жендэрийн тэгш эрхийн үзэл санаа, хандлага, зарчимд тулгуурладаг. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын өөр уламжлал, нөхцөл, байдал, олон урьгалч үзэлтэй нийгмийн амьдралд илүү хохирч байгаа жендэрийнх нь хүний эрхийн асуудалд хэрхэн хандаж, хэрхэн шийдвэрлэж байгаагаас тухайн орны хөгжлийн төрх, царай тодорхойлогддог. Улс орон эдийн засгийн хувьд хичнээн чадавхитай байлаа ч хүн амын 50 гаруй хувийн эзэлдэг эмэгтэйчүүдийн оюун санааны, боловсролын болон бусад нөөц, боломжийг нийгмийн хөгжлийн төлөө бүрэн дүүрэн ашиглаж эс чадваас тухайн орны хөгжлийн бодлого хэрэгжих явц удаашралтай, олон тохиолдолд үл биелэгдэх зорилт болж хувирдаг байна. Манай нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүнийг байгалийн болон нийгмийн хүйсийнх нь хувьд ялгаварлан үзэж байгаа уламжлалт сэтгэлгээ нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын орчин нь тухайн нийгэмд аль хүн /эрэгтэй, эмэгтэй/ жам ёсны болон хуульд заасан эрх, эрх чөлөөгөө өдлэх боломжийг ямагт хязгаарлаж, хүний өөрийнх нь болон түүний амьдарч байгаа нийгмийн хөгжилд ихээхэн саад болж байна.

Дөрөв. Жендэрийн тухай.

Хууль боловсруулагчид, судлаачид, төрөл бүрийн гэгээрэл сурталчилгааны үйл ажиллагаа явуулах хүн бүр жендэрийн болон жендэрийн тэгш байдал, тэгш эрхийн талаар дараах үндсэн мэдлэгтэй байхыг чухалчлан жендэрийн асуудлуудыг дараах байдлаар дэлгэрүүлж байна.

“Жендер” гэдэг англи үгийг нэр томъёоны олон толь бичигт “хүйс”^{49[14]} гэж орчуулсан байна. Энэ утгаар нь судлаачид **секс** (sex)-ийг бие махбодийн (биологийн) хүйс, **жендер** (gender)-ийг нийгмийн хүйс гэж нэрлэдэг. Гэхдээ Монгол хэлэнд “хүйс” хэмээх ухагдахуунаар орчуулагдаж буй **“жендер”** нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалийн шинж төрхийн буюу нөхөн үргижүйн ялгааны тухай ойлголтыг бус, харин эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн хүйсийн харилцааны тухай ойлголтыг илэрхийлдэг ажээ. “Жендер” хэмээх ухагдахуун нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд хэвшсэн зан үйл, тэдний үйл хөдлөл, нийгмийн зүгээс тэдэнд ногдуулсан үүрэг, хариуслага зэрэгтэй холбоотой ойлголт юм. Зүйрэн хэлбэл, эдийн засаг бол зөвхөн хоол хүнс, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн хуваарилах, борлуулах мэтээр хязгаарлагдах

48 [13] Хөгжих эрх гэдгийгanh 1977 онд НҮБ-ын Хүний эрхийн комиссоос гаргаж байсан ба 1986 онд Ерөнхий Ассемблейгаас “Хөгжих эрхийн тухай тунхаглал”-г батласан. Тунхаглал “хөгжих эрх нь хүн бүрийн салшгүй эрх. Тиймээс хүн бүр хүний эрх, эрх чөлөөг бүрэн хэмжээгээр хэрэгжих эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийг буй болгоход оролцох, хувь нэмрээ оруулж, үр шимийг нь хүртэх эрхтэй юм ” гэжээ.

49 [14] Англи- Монгол толь. Э. Чинбат. 2001 он.

ойлголт бус, түүнээс асар өргөн цар хүрээтэй үйл явц байдаг. Түүнчлэн, гэр бүлийн ба ураг төрлийн холбоо, харилцаа нь зөвхөн эр, эм хоёрын хоорондын харилцаа, үр хүүхэд төрүүлэх төдий асуудал бус, тэдний ухамсарт үйл амьдрал, зан заншил, ёс суртахуун, шашин шүтлэг, соёлын уламжлал зэрэг нийгмийн харилцааны хөгжилтэй нягт холбоотой үйл явц байдагтай адил юм.

Үүний адилаар “**жендер**” гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалийн буюу нөхөн үржихүйн шинж чанартай адилтгаж болохгүй, харин тэдний нийгмийн харилцааны ойлголт буюу нийгмийн хүйсийн тухай ухагдахуун юм. **Жишээлбэл:** эр хүнийг “хүчтэй хүйтэн” гэж үздэг хэдий ч “хүчтэй” хэмээх энэ үгээр оюуны ба бие бялдрын ямар шинж чанарыг томъёолдог болох нь ойлгомжгүй, эмэгтэй хүнийг “сул дорой хүйтэн” гэж үздэг атлаа тэдний оюуны ба бие бялдрын ямар шинж чанарыг нь “сул дорой” гэж үзэж байгаа зэрэг нь тодорхой бус байна. Ер нь аливаа хүний хүчтэй, эсвэл сул дорой талын ойлголтыг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн үүрэг, хариуцлага, эрх мэдэл, оролцоо, тэдний нийгмийн нөөц баялгаас хүртэх байдал зэргийг (иргэний нийгмийн үндсэн ухагдахууны талаас) харьцуулан үзэхэд тун бодитой бус зүйл юм.

Тэгэхлээр **хүйс** (англиар **секс**) гэдэг бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн байгалийн шинж төрхийн тухай ойлголт бөгөөд харин **жендер** гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нийгмийн амьд харилцааны тухай ойлголт юм. Тодруулж хэлбэл, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн **нийтлэг** (арыс өнгө, яс үндэс, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн байдал, боловсрол зэргээс үл хамаарах) ба байнга хувирч **өөрчлөгддөггүй биологийн** буюу байгалийн шинж төрхийн тухай ойлголтыг ХҮЙС хэмээн тодорхойлдог бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгмийн харилцаа нь соёл иргэншлийн орчин, он цагийн явцад хувиран өөрчлөх өөрчлөлт, нийгэм, эдийн засгийн сэргэн мандалт, бууралтын үеийн нөлөөнд хөрхэн ялгаатай байгаа зэрэг асуудлыг **ЖЕНДЭР** буюу нийгмийн хүйсийн тухай ойлголтоор тодорхойлдог байна.

Эрэгтэй, эмэгтэйчүүд байгалийн шинж төрхөөрөө ялгаатай байдгийн учир нь байгаль дахь бусад амьтдын адил тэдний нөхөн үржихүйн эрхтэн, түүний зохицолдоо, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагаа эрс ялгаатай төрдөг явдалтай шууд холбоотой юм.

Байгалийн жам ёсны дагуу эр, эм амьтад үр удмаа залгамжуулах, үр зулзагаа тээж төрүүлэх, түүнийг тэжээн бойжуулахдаа зөвхөн төрөлхийн зөн билэгтээ (**инстинкт**) захирагддаг. Харин байгаль, нийгмийн дээд төрөлт бүтээгдэхүүн, ухамсарт бодгаль, оюуны нарийн зохицлогоо бүхий эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрийн төрөлхийн болон үүсмэл зөн билгийн тусламжтайгаар амьдралын үй түмэн үйлдлүүдийг зохицуулах чадвартай төрдөг ажээ. Эрэгтэй, эмэгтэй хүний нөхөн үржихүйн эрхтэн, түүний зохицолдоо, гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны ялгаатай байдлыг эр, эм хүйсийн байгалийн төрөлхийн шинж чанар гэнэ. Харин хүмүүсийн үр хүүхдээ өсгөн бойжуулах, сурган хүмүүжүүлэх, олон нийтийн үйл хэрэгт оролцуулах зэрэг амьд үйл ажиллагааг хүний нийгмийн үүрэг, үйл ажиллагаа гэж тооцдог.

Хүмүүсийн үр хүүхдээ өсгөн бойжуулах, сурган хүмүүжүүлэх, эрдэм ном сургах, гэр орон, ахуй амьдралаа авч явах зэрэг нийгмийн олон талт үйл хэргийг шийдэхэд хувь хүний эрх мэдэл, үүрэг, оролцоо, үйл ажиллагаа, тэдний нөөц баялгаас хүртэх хэр хэмжээ зэрэг асуудал нь нийгмийн гарал, байдал, уламжлал, зан заншил, шашин шүтлэг, хууль эрх зүйн тогтолцоо, боловсрол зэрэг улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын орчноос шалтгаалсан харилцан адилгүй байдал нь эрэгтэй, эмэгтэй хүний жендерийн харилцааг тодорхойлж байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн жендерийн ялгааг гэр бүл, улс төр, эдийн засаг, нийгэм соёл гэсэн нийгмийн амьдралын (4) хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүс хүсэн хүлээж буй,

гэр бүл, нийгэмд зөвшөөрөгдөж буй, үнэлэгдэж буй хэм хэмжээгээр тодорхойлогдолг гэж үзэж байна. Жендерийн ялгаа нь гэр бүл, төр, зах зээл, олон нийтийн амьдралын хүрээнд эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлага, оролцооны төрх, байдлаар илэрдэг бол жендерийн ялгаварлал гэж жендерийн ялгааны асуудлыг аль нэг жендер нь нөгөөгөөсөө ДЭЭР/ДАВУУ ЭСВЭЛ ДООРД/СУЛ ДОРОЙ гэж үзэж байгааг хэлнэ.

Жендерийн тэгш эрхийн тухай хуульд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бодит тэгш байдлыг бий болгох үүднээс дараах 5 үндсэн зүйлийн дүн шинжилгээнд тулгуурлан боловсруулах шаардлагатай. Үүнд: 1. **ҮЙЛ АЖИЛЛАГАА** - Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хийж, гүйцэтгэж байгаа ажил, хөдөлмөр, 2. **НӨӨЦ БОЛОМЖ**- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд аливаа ажил, хөдөлмөрийг хийхдээ ямар нөөц, боломжоор хангагдаж байгаа, эсвэл үгүй байгаа, 3. **ҮҮРЭГ**- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагын ялгаа, 4. **ЭРХ МЭДЭЛ**- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэн нь шийдвэр гаргаж, хэний ашиг сонирхол хөнөөгдөж байгаа, 5. **ХУВЬ ОРОЛЦОО**- Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хэн нь хаана илүүтэй оролцож, хэн нь, хаана үлдэж байгаа байдлыг анхаарах нь чухал юм.

Жендерийн тэгш эрхийн асуудлыг **тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, төр засгийн амлалт үүргийн зарчим** гэсэн 3 үндсэн зарчимд нийцүүлж баталгаажуулан^{50[15]} хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагад суурилан ажиллах шаардлагатай байдаг.

Жендерийн зохистой хандлага гэдэг бол эмэгтэй хүний нөхөн үржихүйн үүргийг нийгмийн үүрэг^{51[16]} гэж үзэж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдралд эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангахад зохистой, нэмэлт арга хэмжээ авахыг засаг төрд үүрэг болгодог^{52[17]} юм. Энэхүү хандлага нь боломж, бололцооны түүнчлэн үр дүнгийн тэгш байдлыг чухалчилдаг төдийгүй амлалт, үүргийн зарчмын дагуу зохистой бүх арга хэмжээ авахыг^{53[18]} төр, засаг, аж ахуйн нэгж, байгууллагуудад үүрэг болгодог юм.

Жендерийн хамгаалах хандлага нь “эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс эмзэг, сүл дорой учир тэднийг хамгаалах, халамжлах шаардлагатай” хэмээх үзэл баримтлалд тулгуурладаг. Энэ хандлагын дутагдалтай тал нь хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг эдлэхэд ямагт хязгаарлаж байдаг. Тухайлбал, эмэгтэйчүүдийг хамгаалах нэрийдлээр эмэгтэйчүүд, охидыг цалин, орлого сайтай зарим “хүнд хүчир” гэж үздэг ажил хөдөлмөр эрхлэхийг хориглох нь эмэгтэйчүүдийн баталгаатай эдлэх эрхээ^{54[19]} тэгш эдлэхэд нь хязгаарлалт болж цалин орлогоо нэмэгдүүлэх, цаашилбал хөгжих эрхээ эдлэх боломжгүй болдог байна. Жишээ нь, Хөдөлмөрийн тухай хуулийн 100.1-д “Ажил олгогч нь жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насын хүүхэлтэй эхийг аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсан болон энэ хуулийн-д зааснаас тохиолдолд ажлаас халахыг хориглоно”, 102.1-д “Жирэмсэн эмэгтэй, найм хүртэл насын хүүхэлтэй эх, 16 хүртэлх насын хүүхэлтэй ганц бие эхийг өөрөө зөвшөөрөөгүй тохиолдолд шөнийн буюу илүү цагаар, түүнчлэн албан томилолтоор ажиллуулахыг хориглоно”, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах тухай хуульд “Хорин жил нийгмийн даатгал төлсөн, дөрөв түүнээс дээш

50 [15] Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйл. “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлэлнэ” гээд хүний эрх, эрх чөлөөг 18 заалтаар баталгаажуулж өгсөн. Энэ баталгаажсан эрхийг Монгол Улсын иргэн бүр, эрэгтэй эмэгтэйчүүд адил тэгш эдлэх ёстой юм.

51 [16] Найробын болон Бээжингийн бага хурлаас гаргасан тунхаглал болон үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн үндсэн зарчим.

52 [17] Үндсэн хуулийн Аравдуугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шудрагаар сахин биелүүлнэ”, 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон батласан буюу нэгдсэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэнэ” гэж заасан байдаг ба Арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсэн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан тул жендерийн зохистой хандлага бодитой хэрэгжих хууль эрхзүйн үндэстэй бөгөөд иргэд энэ эрхээ шаардах ёстой гэж үзэж байна.

53 [18] ЭЯГБХУК-ийн 3 дугаар зүйлд заасан.

54 [19] Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4-т “ажил, мэргэжилээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах...” гэж заасан.

хүүхэд төрүүлсэн эх өөрөө хүсвэл тэтгэвэрээ тогтоолгох эрхтэй” хэмээн эмэгтэй хүнийг хамгаалах хандлагатай заалтуудыг оруулсан нь эмэгтэй хүн Үндсэн хуульд заасны дагуу ажил, хөдөлмөрийг чөлөөтэй эрхлэхэд аливаа хязгаарлалт зохиомлоор бий болгох, тухайлбал, олон хүүхэдтэй эсвэл нялх хүүхэдтэй гэх мэтээр шалтаглан ажилд авахгүй байх тохиолдуудыг бий болгож байна^{55[20]}.

Жендерийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх/зөвшөөрүүлэх хандлага нь эрэгтэй, эмэгтэйчүүд хүйсийн хувьд ялгаатай учраас тэдэнд ялгавартай хандах үзэл баримтлал юм. Энэ хандлага нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс өөрийгөө болон бусдыг хэрхэн үзэж байгаа байдлаар илэрдэг. Жишээлбэл, “Эмэгтэй хүн насны хувьд эрт хөгширдөг тул тэтгэвэрт эрт гарах ёстой” гэсэн бодлогыг хууль тогтоогчид, ажил олгогчид баримтадаг байна^{56[21]}. Энэ үзэлд тулгуурлан эмэгтэйчүүдийг тэтгэврийн насанд хүрсэн гэдгээр шалтаглан тэдний ажлын туршлага, мэдлэг, чадварыг харгалзахгүйгээр Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасан^{57[22]} хөдөлмөрийн гэрээ цулах насны хязгаарын тухай заалтыг зөрчин тэтгэвэрт гарахыг элдэв хэлбэр, аргаар шаардлаг байна.

Эрэгтэйчүүдийг гэр бүл, эхнэр хүүхдээ тэжээх, өрх толгойлох, улс орныг тэргүүлдэг“ гэж үздэг уламжлалт ойлголт нь тэднийг “хүчтэй хүйстэн” гэж үзэх хандлагатай болгосон байна^{58[23]}. Эрэгтэйчүүд “хүчтэй хүйстэн” хэмээх уламжлалт үүргээ “нэр төртэй гүйцэтгэж чадахгүй байна” гэж үзсэнээс тэд нийгмийн, ялангуяа гэр бүлийн хүрээнд нэр хүндгүй болох явдал элбэг тохиолдог байна. Эрэгтэйчүүд “нэр хүндгүй болсон” үедээ үүнийгээ гол төлөв олон янзын сөрөг хэлбэрээр илэрхийлэх нь олоний байдаг. Жишээлбэл, тэд сэтгэл санааны хямралд орох, улмаар архи, согтууруулах ундааг зүй бусаар хэрэглэх, биеийн болон оюуны доройтолд орох, олон тохиолдолд гэмт хэрэг үйлдэх, бусдын муу нөлөөнд автах зэргээр уруудаж доройтох байдалд хүрэхийн зэрэгшээ зарим тохиолдолд өөрийгөө егүүтгэх оролдлого гаргадаг байна.

Тэгш байдлын ёс төдий хандлага нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд ажил, тэгш учир тэдэнд адилхан хандах ёстой гэсэн үзэл баримтлал юм. Өөрөөр хэлбэр, жендерийн тэгш эрхийн зарчимд үл нийцэх хандлагын нэг бол жендерийн ижилсгэх хандлага буюу тэгш байдлыг ёс төдий байдлаар тунхаглах загвар байдаг юм. Ийм хандлагын илрэл нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэгш эрхтэй хэмээн хуульд тунхагладаг хэдий ч тэдэнд бодит амьдрал дээр тэгш эрхээ эдлэх боломж, бололцоог засаг, төрөөс зохицтой байдлаар бий болгодоггүй, бодитой арга хэмжээ авдаггүй байх явдал юм. Жишээ нь, Монгол Улсын Үндсэн хуульд “эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд сонгох, сонгогдох эрх”-ийг баталгаатай эдэлнэ^{59[24]} гэж тунхагласан байтал хуульд заасан тэгш эрхээ эдлэх боломжийг хүн амын тал хувийг эзэлж байгаа^{60[25]} эмэгтэйчүүд, ялангуяа сонгогдох эрхээ эдлэх боломжийг хүн амын тал хувийг эзэлж байгаа

55 [20] Хуульд зөвхөн эмэгтэй хүнийг хамгаалах заалттай байвал гэр бүл, хүүхдийн нийгмийн болон эдийн засгийн эрх ашигт нийцдэггүй. Хэрэв хуульд эцэг, эх, эхнэр, нөхрийг аль алинд нь хамааралтай байдлаар хуульчлах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст илүү сонголт, илүү боломж бий болох юм. Судлаач.

56 [21] 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын мэдээгээр эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдээс дундажаар 5 пунктээр илүү насалдаг байна.

57 [22] Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3-т “ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн” бол ажил олгогчийн санаачлагараа тэтгэвэрт гаргаж болох тухай заалттай. Гэтэл Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах тухай хуулийн дагуу төрүүлсэн хүүхэд, 20 жил нийгмийн даатгалын санд даатгал төлсөн байдлаар шалтаглан эмэгтэйчүүдийг тэтгэвэрт гаргаж байгааг Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн үйлдэл гэж үзэж байна.

58 [23] Хүйс болон жендерийн аливаа ялгаа (нас, хүйс, боловсрол, шашин, гэр бүлийн байдал, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал) нь сайн, муу, хүчтэй, хүчгүй, сул,дорий гэх мэтээр тодорхойлогдох учиргүй юм. Жишээ нь, эрэгтэй хүн даахгүй байгаа ачаа тээшийг эмэгтэй хүн өлхөн өргөчих, эмэгтэй хүнтэй адил үйлэнд уран эрэгтэй хүн байх зэрэг олон жишээ байдаг бөгөөд, арга, билэг хоёрын аль нь илүү вэ гэсэнтэй адил утгагүй зүйл болох юм. Тиймээс аливаа ялгаа нь хэн нэгнийг ялгаварлан гадуурхах шалтгаан, шалтаг, үндэслэл болох учиргүй. Судлаач.

59 [24] Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” гээд арван найман заалтаар иргэдийн эдлэх ёстой эрх, эрх чөлөөг заасан боловч иргэд хуульд заасан эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэж чадахгүй байна. Судлаач.

60 [25] 2000 оны Хүн ам, орон сууцны тооллогоор эмэгтэйчүүд хүн амын 50,4 хувийг эзэлж байна.

нийгмийн, соёлын орчин бүрдээгүй хэвээр байна. Энэ талаар засаг, төрөөс, улс төрийн намуудаас хэрэгжүүлж байсан зохистой, үр дүнтэй, тууштай бодлого дутагдалтай, цогц бус байснаас шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо, хувь хэмжээ жендэрийн тэгш байдлын наад захын жишигт хүрээгүй байна.^{61[26]}

Монголын эмэгтэйчүүд гэр бүл, нийгмийн хөгжлийн идэвхитэй гишүүн байх боломж, бололцоогоор ямагт дутмаг, хүйс болон жендэрийн хувьд олон зууны турш “дорд” үзэгдэж ирснээс тэгш эрхээ эдлэх боломж, бололцоо нь алдагдсан байна. Үүнээс үүдэн эмэгтэй хүн өөртөө итгэх, өөрсдийнхөө мэдлэг, чадварыг зохистой үнэлэх, хуульд заасан иргэний эрхээ бодитойгоор эдлэх итгэл үнэмшил сул байгаа зэрэг байдлаас үр дүнгийн тэгш байдал ч алдагдсан гэж дүгнэж болно.^{62[27]} Тиймээс улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, чадавхижуулахад улс төрийн нам, засаг төр, төрийн бус байгууллагын зүгээс нэлээд цаг хугацаа, үйгагүй хүчин чармайлт шаардах асуудал болоод байна.

Дээр дурдсан жендэрийн хандлагууд нь нэг талаас эмэгтэйчүүд улс төр, нийгмийн амьдралд оролцох байдлыг хязгаарлах шалтаг, шалтгаан болдог ба хүн амын тал хувь нь гэр бүл, нийгмийн хөгжлийн идэвхитэй гишүүн байх боломжийг бүрдүүлэхэд томоохон саад тогтор болж байна. Нөгөө нэг хортой үр дагавар нь уламжлал, ёс заншил, соёлын хэвшмэл үзэл баримтлал нь эрэгтэйчүүд гэр бүл, нийгмийн амьдралд тогтоосон хэм хэмжээний “золиос” болох тохиолдлууд олон байна. Иймээс жендэрийн ижилсгэх хандлага, тэгш байдлыг ёс төдий тунхагласан загвар бүхий хууль, эрхзүйн тогтолцоо нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тэгш бус харилцааны элдэв гажуудал, ялгаварлалыг арилгах, хүн, нийгмийн хөгжлийн сайн хөшүүрэг болдоггүй.

Жендерийн **ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлага нь** эмэгтэйчүүд “сул дорий”, “эмзэг”, эсвэл “хүүхэл төрүүлдэг”, эрэгтэйчүүдийг бодвол “эрт хөгширдөг” учраас тэтгэвэрт эрт гарах ёстой, эсвэл хүч тэнхээ багатай учир “хөнгөн” ажил хийх ёстой гэх зэргээр үздэг хандлага юм. Тухайлбал, манай нийгэмд онгошны үйлчлэгч, байгууллагын нарийн бичгийн дарга зэрэг ажил эрхэлдэг бүсгүйчүүд заавал залуухан, гоё сайхан байх ёстой хэмээн хандах нь олонтой тохиолдож байна. Эмэгтэйчүүдийг ийм шалгуураар ажилд авдаг байгууллагуудад “царай, бие галбир нь муудсан” хэмээн шалтаглаж ажлаас халах нь олон тохиолдог ба нилээд олон тохиолдолд ажлын байран дахь бэлгийн түрэмгийлэл, дарамтад өртөх, хүйсийн болон жендерийн ялгаатай учир шалтгаанаар тэтгэвэрт гаргах, ажлаас халах, цалин бууруулах зэргээр эмэгтэйчүүдийг гадуурхдаг байдал байсаар байна. Нас, гадаад төрх, төрүүлсэн хүүхдийн тоо зэрэг ялгаатай байгааг шалтаглан ялгаварлан гадуурхалтыг “уламжлалын” дагуу улс төр, нийгмийн хүрээнд гаргасан хэвээр байгаа төдийгүй нийтээр дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар, журамд жендерийн ялгаварлан гадуурхалттай заалтууд орсон байдаг. Жишээ нь, Гэр бүлийн тухай хуулийн 24.3-т “Хүүхэд эшгийн нэрийг авна”^{63[28]}, Хөдөлмөрийн тухай хуулийн “Эмэгтэй хүний хөдөлмөр” гэсэн хуулийн нэр, томъёо, 101.1, 103.1 зэрэг заалтууд нь эмэгтэй хүн (эм хүйстэн) учир хүүхдээ асрах ёстой гэсэн уламжлалт ойлголтод тулгуурлан боловсрогдож батлагдсан байдаг.

61 [26] Скандинавын зэрэг хөгжилтэй орнуудад жендерийг тэгш харьцааг наад зах нь 60:40 байхаар тооцоолдог. Төрийн байгууллагууд жендерийн харьцааг бүх шатанд жил бүр тооцоолон гаргадаг бөгөөд аль нэг хүйсийн харьцаа дээр заасан харьцаанаас илт давуу байх нь байгууллагын болон нийгмийн хөгжилд муугаар нөлөөлнө гэж үздэг байна. Судлаач.

62 [27] Мэдлэг, боловсрол сайтай олон эмэгтэйчүүд нийгэм, улс төрийн амьдралд идэвхитэй оролцох, ялангуяа шийдвэр гаргах дээд, дунд шатны сонгуульд нэрээ дэвшиүлэх, өрсөлдхөөс байнга татгалздаг байна. Ийм байдал нь олон шалтаг, шалтгаантай ба хамгийн гол нь санхүү, мөнгөний хомсдол байдаг бөгөөд сонгуулийн систем, улс төрийн намуудын дотоод арчилал, сонгогчдын болон хэвлэл мэдээллийн жендерийн мэдрэмж зэрэг асуудлууд ихээхэн нөлөөтэй байсаар байна. Судлаач.

63 [28] Эрэгтэй хүнээр овоглох ёс, заншилтай тул ийм байх ёстой гэсэн хандлага, уур амьсгал хууль тогтоогчдод байсан тул тэр үед хүний эрхийн ТББ-даас “энэ заалт олон улсын гэрээ, тухайн хуулийн 10.1, Үндсэн хуулийн 10.2, 14.2, 16.11 дүгээр заалтуудыг зөрчиж байна” гэсэн шаардлагыг хүлээж аваагүй болно.

Үүний эсрэгээр гэр бүл, нийгэмд эрэгтэйчүүд бол “өөрсдийгөө яаж ийгээд аваад явах чадалтай” гэсэн уламжлалт ойлголтоор хандах, гол төлөв хөвгүүдийг бага балчираас нь гэр орны ажил^{64[29]} хийлгэх дадал, зуршилтай болгох, биеэ дааж аливаа “аар саар ажил” хийж сургах, эрдэм боловсрол, мэдлэг, мэргэжил эзэмшүүлэх зэрэгт эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгч нар анхаарал хандуулж байгаагүйн улмаас хөвгүүд гол төлөв эхэлсэн ажлаа дуусгах чадваргүй, хоосон мөрөөдөх, аливаа ажлыг уйгагүй гүйцэтгэх тэвчээр мөхөс, мөн аливаа зүйлийг сурч мэдэхийн төлөө тутштай хөдөлмөрлөх, гэр бүлийн бусад гишүүдийн төлөө сэтгэл гарган ажиллах хүсэл, сонирхол нь охидоос дутмаг байх явдал түгээмэл байдаг нь ажиглагддаг.

Түүнчлэн, эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгч нар хөвгүүдийн энэ бэрхшээлтэй асуудлыг үл ойшоох, ялангуяа шилжилтийн насты эрэгтэй хүүхдийг сургах, хүмүүжүүлэх арга барил дутуу, чадваргүй байдгаас олон тохиолдолд хөвгүүд сургуулиа орхих, эсвэл эцэг, эх нь хөвгүүдээ “хар бор” ажил хийлгэх зорилгоор дунд болон бага сургуулиас гаргаж, гэр орон мал ахуйн ажил хөдөлмөр хийлгэх, ингэхдээ тэднийг албан бус аргаар боловсрол эзэмшүүлэхэд анхаарахгүй^{65[30]} байгаа нь эмэгтэйчүүдтэй харьцуулбал эрэгтэйчүүд нь суурь мэдлэг, боловсрол султай болж байна.

Нийгмийн амьдралд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн залуучуудад боловсрол, мэргэжил, мэргэшлийг хослуулан эзэмшүүлэх үйл ажиллагаа орхигдсон, гэр бүлийн хүрээнд хөвгүүдийг өөртөө болон бусад үйлчлэх ажилд сургах, зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа ажил хөдөлмөр эрхлэх чадвар суулгах, туршлагатай хүмүүсийг дагалдуулан ажиллуулах үйл ажиллагаа мартагдсан, боловсролын салбарын хүрээнд, ялангуяа хөвгүүдийг сургах, хүмүүжүүлэх ажлын арга барил хоцрогдсон, зэвсэгт хүчиний салбарт хугацаат цэргийн албыг зөвхөн эрчүүд хаадаг, тэднийг төрөл бүрээр дарамтадаг, цэргийн алба хаах хугацаанд эрэгтэйчүүдэд учруулдаг бие бялдар, сэтгэл санааны элдэв дарамт зэргээс эрэгтэйчүүдийн хүний эрх, эрх чөлөө хохирч, олон тохиолдолд амьд явах эрх ч алдагдаж байна.

Эрэгтэйчүүдийг “хүчтэй хүйстэн”-д тооцдог, тэднийг эмэгтэйчүүдээс “дээрд” үздэг нийгмийн үзэл хандлага нь эрэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үзлийг гэр бүл, нийгэмд бий болгох нөхцлийг бүрдүүлдэг. Үүний уршгаар эрчүүд сэтгэл санаагаар унаж, амьдралын замаа алдах байдал олонтой ажиглагддаг. Гэр бүл, нийгэмд эрэгтэйчүүд өөрсдийгөө “дээрд” үздэг учраас гэр бүлийн амьдралд “чадах чинээгээрээ” санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гэр орны болон бусад туслах ажлыг хийж гүйцэтгэх нь эр хүний хийх ажил биш гэж үздэг байдал гэр бүлийн бусад гишүүдийн (ялангуяа эмэгтэйчүүдийн) ачааллыг улам хүндрүүлэх, олон тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэл зэрэг хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг үйлдэгддэг байна. Ийнхүү эрэгтэйчүүдийг “хүчтэй хүйстэн” гэж “дээрд” үзэж байгаагийн нөгөө нэг муу үр дагавар нь эрэгтэйчүүд боловсрол, мэдлэг багатай, аливаа хүндрэлтэй асуудлыг “зөөлнөөр” шийдэх чадвар султай болох, улмаар ажил олгогчид тэднийг “архи уудаг, залхуу” гэж үзэж ажилд авахгүй байх зэрэг нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтуудын хор уршгаар тэд цалин орлогoo нэмэгдүүлэх боломжгүй болж, зөвхөн эхнэр болон хамтран амьдрагчийнхаа “хүчээр”^{66[32]} амиа аргацаах, улмаар өрх гэрийнхээ болон нийгмийн амьдрал ахуйд улам их дарамт учруулж өөрсдийнхөө болон нийгмийн хөгжилд багагүй саад болдог тохиолдлууд олон байна.

64 [29] Гэрийн ажил бол эр хүний хийдэг ажил биш гэсэн ойлголт түгээмэл учраас.

65 [30] Бага, дунд боловсролыг хүүхдэд тасралтгүй олгох нь төрийн үүрэг бөгөөд орон нутгийн засаг захиргаа, сургуулийн захирал, багш нар Боловсролын багц хуулийн дагуу үр дүнтэй арга хэмжээ авахгүй байгаа нь манай орны ирээдүй болсон хүүхдэд багачууд, ялангуяа хөвгүүд мэдлэг, боловсрол муутай байгаагийн нэг үндсэн шалтгаан мөн.

66 [32] “Тогтмол цалинтай, тодорхой ажилтай эмэгтэй хүнтэй айлын хажуу өрөө хөлсөн сууна” FM-ийн зар. 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдөр.

Тав. Төр, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үүрэг, иргэний нийгмийн байгууллагууд, хувь хүмүүсийн хариушлага ба гүйшэтгэх чиг үүргийн талаар.

НҮБ-аас баталсан хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийн тухай олон улсын гэрээ, конвенциуд, Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсэг, Аравдугаар зүйлийн 2, 3 дугаар заалт, 14, 16, 17, 19-1, 23-1, 30-1, 33-3, 38-2,7, 50-3, Хөдөлмөрийн тухай хуулийн 7-2 дугаар заалтууд зэргээр бусад хууль, бодлого, хөтөлбөрт заасан дагуу төр, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны үүрэг, иргэний нийгмийн байгууллагууд, хувь хүмүүсийн хариушлага ба гүйшэтгэх чиг үүргийг дараах байдлаар хуульд тусгах нь чухал байна. Үүнд:

- Жендерийн тэгш эрхийг хангах, аливаа ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх талаар хийгдвэл зохих, хууль эрхзүйгээр зохицуулах үйл ажиллагаанууд гэвэл; (*Гол төлөв дээрээс доошлох стратегийн дагуу дараах арга хэмжээг бүрдүүлэхэд чиглэгдэнэ*)

А. Тухайн асуудлаар мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, семинар, хэлэлцүүлэг зэргийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд явуулах;

Б. Тухайн асуудлаар явагдаж байгаа бүх төрлийн үйл ажиллагаанд орон нутгийн төр, захиргаа, нам, олон нийт, боловсрол, соёл, хэвлэл, мэдээлэл, хууль хяналтын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгэм, бусад сонирхлын бүлэг зэрэг нийгмийн бүхий л давхаргыг татан оролцуулах зэрэг;

- Жендерийн тэгш эрхийг хангах аливаа ялгаварлан гадуурхалтыг хориглох; (*Мөн дээрээс доошлох стратегийн дагуу олон нийт даган мөрдөх эрхзүйн орчныг бүрдүүлэхэд чиглэгдэнэ*)

А. Хууль, дүрэм, тогтоол, шийдвэр зэрэгт хүний эрх, тэгш эрхийн үзэл баримтлалд нийцүүлэн өөрчлөлт оруулах, түүний дотор эрхзүйн орчныг шинээр бүрдүүлэх, шаардлагатай хуулийг боловсруулан батлах арга хэмжээ авах зэрэг;

Б. Аливаа байгууллага, аж ахуйн нэгж нь дотооддоо мөрдөх дүрэм, журам боловсруулан гаргаж мөрдөх, хяналт тавих тогтолцоог бий болгох;

- Жендерийн тэгш эрхийг хангах, аливаа ялгаварлан гадуурхалтыг арилгах, хүний эрх, тэгш эрхийг баталгаажуулах чиглэлээр илэвхитэй үйл ажиллагаа явуулах;

А. Аливаа ялгаварлан гадуурхалттай тэмцэх хууль эрх зүй, уламжлал, ёс заншил, нийгмийн харилцааг өөрчлөх хууль, тогтоомж боловсруулан гаргах;

Б. Эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрх, эрх чөлөөг зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох, улмаар хуулийн дагуу шийтгэл ногдуулах зэрэг;

- Жендерийн тэгш байдлыг хангах аливаа ялгаварлан гадуурхалттай тэмцэх механизмыг бүрдүүлэх;

А. Ялгаварлан гадуурхсан аливаа үйлдлийн эсрэг тодорхой, үр дүнтэй, түр зуурын арга хэмжээг авах ажлыг бүх шатанд зохион байгуулах;

Б. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг баталгаажуулах арга хэмжээнд нийгмийн бүх бүлгийг татан оролцуулах, тэдгээр үйл ажиллагааг санхүүжүүлэх ба урамшуулах зэрэг;

- Бодит тэгш байдлыг (*De facto*) хангах;

А. Хуульд заасан боловч бодит байдалд хэрэгжихгүй байгаа заалтыг үр дүнтэй болгоход чиглэсэн нэмэлт арга хэмжээ авах;



ДОРЖИЙН МӨНХӨӨ

Гал Голомт Үндэсний хөдөлгөөн ТББ-ын Тэргүүн.

ХҮНД ЭЭЛТЭЙ БОДЛОГЫГ ТУНХАГЛАХААС ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИЖ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

УИХ-ын сонгуулийн хуулиас нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байна гэсэн заалтыг хассан явдал нийгэмд олон шинэ хариу үзэгдлийг буй болгож байна.

Эмэгтэйчүүдийн ТББ-уудыг зохион байгуулалтад оруулж, эв нэгдэл хамтын ажиллагааг сайжруулахад түлхэц өглөө. Гэр бүл хэмээх жижиг ертөнцийн тулах нэг багана болсон ханийнхаа эх орон, гал голомтынхоо ирээдүйд чиглэсэн хөдөлмөр, сэтгэлийн ачлалыг үнэлэн хүндэтгэдэг эрэгтэйчүүдэд шинэ хандлага, ухаарал өгч тэднийгээ өмөөрөн дэмжих хүрээ өргөжин тэллээ.

Хэдийгээр социализмын тухай сайнаар дурсвал хуучинсаг болж харагддаг ч эмэгтэйчүүдийн талаар баримталж байсан бодлого, түүний үр дүнг үл тоомсорлох нь дэндүг шударга бус болох билээ. Тухайн үеийн төрийн эрх барих дээд байгууллага Ардын их хурын депутат нарын 24 -өөс доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх бодлогыг тууштай баримталж байсан нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн заалтыг биелүүлэхийн төлөө тавьж байсан хүчин чармайлтын илрэл юм.

Төр барьж байсан улс төрийн хүчин эмэгтэй лидерүүдийг өсгөн салбарын сайн мэргэжилтэн, улмаар хамт олныг зохион байгуулагч болгон хөгжиж төлөвшихд нь тусалж, дэмжих ажлыг хоёр жилээр төлөвлөн, хэрэгжилтэд нь хяналт тавьж дүгнэн, үнэлгээ өгч доод түвшнээс өгсөх замаар албан тушаал дэвшүүлэн туршлага, ур чадвар эзэмшүүлж бэлтгэх ажлын тогтолцоотой байсан.

Олон түмний дунд нэр хүндтэй, ажил хөдөлмөрийн өндөр амжилт гаргасан манлайлагч эмэгтэйчүүдийг бүх шатны сонгуульд нэр дэвшүүлдэг байлаа. Аливаа лидерийг сонгон шалгаруулахад намын хамт олны санал дүгнэлт зөвлөмжийг заавал авдаг байсан юм.

АИХ-ын депутатуудын хурал чуулган дээр хэлсэн үг, тавьсан саналыг холбогдох яам газрууд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган тайлagnадаг, сонгогчдын захия даалгавраа биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлж байв. Энэ бүхнийг эргэн сануулахын учир нь төр түшилцэх чадалтай эмэгтэйчүүд ховордсон гэж гаслах, хилийн чанадаас суралцахаар хөрөнгө мөнгө цаахаасаа өмнө “айлаас эрхээр авдраа үудал” гэсэн Монгол ухааныг сануулах гэсэн хэрэг.

Бүр 1920-иод онд эмэгтэйчүүдийн асуудал хариусан төрийн байгууллагын бүтцийг буй болгож эмэгтэйчүүдийн талаар явуулах бодлогыг тэдний өөрсдийн оролцоотой шийдвэрлэх эхлэл тавьж байж.

Монголын эмэгтэйчүүдийн хороо гэдэг нэртэй төр олон нийтийн статустай байгууллага бодлого тодорхойлогч улс төрийн намын зохион байгуулалтын бүтцэд орж, тэргүүнийг нь нам, төрийн удирдах байгууллагад зохих байр суурь эзлүүлж байсан юм. Өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах шатанд тэдний үгийг сонсож бас бүх шатанд бодлогын хэрэгжилтэд хяналт тавих эрх олгодог байсан гэсэн үг. Энэ боломж нь эмэгтэйчүүдийн эрх ашгийг хөндсөн асуудал шийдвэр гаргах түвшинд богино хугацаанд тавигдах, шийдвэрлэгдэхэд таатай нөлөө үзүүлж байв.

Одоо эмэгтэйчүүдэд их эрх чөлөө олгосон гэж тунхаглаж байгаа үед намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага ямар статустай, эрх хэмжээтэй байгааг би сайн ойлгодоггүй болохоор энэ асуудлыг тодруулан дурдаж байгаа юм. Лав л улс төрийн эрхийг нь баталгаажуулах зүгт хийсэн сонгуулийн хуулийн өөрчлөлтийг нь үгүй болгоход тэдний саналыг сонсох нь бүү хэл бараг амыг нь барих цоож тааруулчихсан бололтой. Орлогч сайд, даргаар эмэгтэй хүн заавал ажиллуулах ажлын байрыг тодорхойлж хэрэгжүүлдэг байсан.

Энэнь Улстөрийн намдэмэгтэй манлайлагчдыг өсгөн хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байсан хэрэг юм. Энэхүү бодлогын үр дүнд Монголын эмэгтэйчүүдийн хорооны дарга агсан, төр нийгмийн нэрт зүтгэлтэн, зохиолч С.Удавал, Сангийн яамны нэгдүгээр орлогч сайд асан Б.Долгормаа, Хөдөлмөр цалин хөлсний улсын хорооны дарга асан Ахамсүрэн, Эрүүл мэндийн яамны нэгдүгээр орлогч сайд агсан Д.Түмэндэлгэр нарын олон олон үндэсний хэмжээний шинжээч лидерүүд байр сууриа эзэлж хүнд ээлтэй хөгжлийн түүхийг бүтээлцэж байсан билээ.

Өнөөдөр эмэгтэйчүүд сонгуулийн хар ажил материал тараах, хэн нэгнийг өмөөрөн бусад намынхантай үзэлцэх, нийгмийн хурц асуудал сөхөн тавигчдын дүрд тоглож улс төрчдийн захиалга биелүүлэх, аливаа маргааныг өдөөгч баатар болон эмэгтэйчүүдэд үүрүүлдэг хоч болсон ухаан богинотой болох батлах, хэвлэлийн хурц хурц шуугиан дэгдээж, хөлсний хар ажлын золиос болох, холыг харагчдын гар хөл болж хоорондоо дайсагналашах гээд олон таагүй үзэгдэл бидний нүдэн дээр өрнөдөг нь цөөн биш. Эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгт өртөгчдийн, биеэ үнэлэгчдийн, харьд зуучлалаар хадамд гарагчдын, гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчдийн бүхэл бүтэн эгнээг бүрдүүлж нэг хэсгийг маань эмгэнэлт хувь заяа нь тохуурхан даажигнаж байна.

Хэн биднийг өмөөрөн энэ асуудлыг гарган тавьсан билээ. Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагууд олон жил ярьсан энэ асуудлууд ямар улс төрийн хүчиний мөрийн хөтөлбөрт тусгалаа олсон билээ. Энэ бүхэн бил төрийн хэрэгт хошуу дүрэх, шийдвэр гаргах, хөгжлийн бодлого боловсруулахад орон зайгаа нэхэх хэрэгцээ шаардлагыг бий болгож байгаа юм.

Гэр бүлийн задрал, архинд живсэн нийгмийн орчин, өсвөр залуу үе, эрүүл мэнд, боловсролоор доройтож, гэмт хэрэгт орооцолдсон эрчүүд, эрүүл мэндийн хүнд ээлтэй тусlamж үйлчилгээ, чанартай, хөрвөх чадвартай боловсрол, эznээ олж, амьдралыг нь болитой дэмжих нийгмийн хalamж үйлчилгээ гээд бидний хошуу дүрэх асуудал нэн олон бас орон зай нь үгүйлэгдэж байгаа туршлага, мэдлэгийн хомсдол ч их байна.

Гэтэл сонгуульд яалт ирвэл хичнээн эмэгтэй шийдвэр гаргах өндөр болон дунд шатанд байр эзэлсэн байдаг билээ. Зөвлөх, туслах их л сайндаа мэргэжилтэн болох хувь зохиол биднийг хүлээж байдаг нь нууц биш. Хэрэв эмэгтэй хүн бие даан ямар нэг ажил санаачлан амжилтанда хүрвэл түүнийг гутаах их аян өрнөдөг, бас замаасаа зайлуулах, бие даасан санал санаачилга гаргах замыг нь хаах занга тавихаар оролдох нь ч бий. Бидний үеийнхэн социализм, зах зээл нийгэмд хоёулаанд нь амьдарч байгаа болохоор энэ бүхний амьд гэрч юм.

Эдгээр зүйлийг бичихдээ хэн нэгнийг буруушаах гэсэндээ бус Монголын ард түмний ололт, алдаа бүхэн билэнд болон хойч үед минь хамаатай тул урьд үеийнхний бүтээсэн сайн зүйлийг бүгдийг нь хог болгон шүүрлэхгүй, авах гээхийн ухаанаар хандаж, нэгэнт бүтээсэн зөв менежмент, туршлага, бас Монголын хөрсөн дээр буусан үнэт зүйлийг судлан өнөө үед таарч тохирохгүй болсныг нь сайжруулан ашиглаж байгаасай гэсэндээ энэ бүхнийг нуршлаа.



ПҮРЭВИЙН ОЮУНЧИМЭГ

Хууль зүйн ухааны магистр, докторант. ХЭҮК-ын гишүүн.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ АЖИЛ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛҮҮД

“Цагдаагийн байгууллагын ажилнуудад зориулсан гарын авлага”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилнуудад зориулсан гарын авлага” зэрэг 5 төрлийн гарын авлага,

“Хүний эрх” сэтгүүл “Сэжигтэн, яллагдагчийн эрхийг баталгаатай хангах зарим асуудал” 2005/1, “Хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон шийтгэгдсэн хохирогчийн эрхийн асуудала” 2005/2, “Цагдан хорих ажиллагаа ба хүний эрх” 2005/4, “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр, хэршгий хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийг хангахад цаашид анхаарах зарим асуудлууд” 2006/1 зэрэг өгүүлмэгүүд.

“Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн талаархи олон улсын баримт бичиг, зохицуулалт сэдвээр “НХХ-ийн гэмт хэргийн талаархи үндэсний чуулган”/2004 он/,”

“Гэр бүлийн хүчирхийлэл ба хүний эрх” /2003 он/ зэрэг илтгэлүүдийг,

“Иргэн таны эрх зүйн мэдлэгт” /2006 он/.

ЭМЭГТЭЙЧҮҮД, ОХИДЫГ ХИЛ ДАМНУУЛАН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТУУД БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАЛААР

Олон улсын үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн төрлүүд дотроос олон улсын анхаарлыг ихээр татаж, эзэндээ хямдхан ажиллах хүчээр асар хэмжээний мөнгийг нэг дор олж өгдөг хүн худалдаалах гэмт хэрэг нь хар тамхи, мансууруулах бодис худалдаалах, олон улсын террорист гэмт хэргийн дараа толгой цохидог гэмт хэргийн нэг болж байгааг олон улсын хүний эрхийн байгууллагууд цохон тэмдэглэж байна.

Цагаан боолын худалдаа, эмэгтэйчүүдийг хүйсийн давуу байдаар нь ашигладаг, эзэндээ хялбар аргаар хурдан хугацаанд асар их мөнгө олж өгдөг энэ төрлийн гэмт хэрэг зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн сонирхлыг юугаараа тэгтлээ татдаг вэ?

Тэгвэл энэ асуудлыг бичихээс өмнө хүн худалдаалах гэмт хэрэг гэж чухам юуг хэлээд байна вэ гэдгийг сонирхвол хүнийг мөлжих зорилгоор, хүч хэрэглэхээр заналхийлэх, буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хүнийг хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, тухайн эмэгтэйчүүд охидыг эмзэг байдлыг нь далимдуулан гэмт хэрэгтээ ашиглах зэрэг аргаар эмэгтэйчүүд охидыг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлдэг байна.

Хүнийг мөлжих зорилгоор гэдэгт биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харьцаанд хүчээр оруулан мөлжих, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил хэрэглэх, эрх чөлөөтгүй байлагах, эд эрхтнийг нь авах зэрэг үйлдлүүдийг хэлдэг байна.

Мөлжих зорилгоор эмэгтэйчүүд, охидыг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хүн худалдаалах гэж үздэг.

Хүн худалдаалах тэр дундаа эмэгтэйчүүд, охидыг худалдаалах энэ гэмт хэрэг гарахад З төрлийн хүчин зүйл нөлөөлдөг гэж үздэг.

Нийгмийн хүчин зүйл:

- Нийгэмд эзэлж байгаа эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн доогуур байр суурь;

- Энэ талаархи нийгэм, олон нийтийн сүл мэдээлэл, дэмжлэг;
- Тухайн улсуудын соёл болон практик үйл ажиллагаа;
- Гэр бүлийн дотор болон нийгэм дэх биеийн ба сексийн дарамт шахалт;
- Хүйсийн хувьд ялгаварлан гадуурхах үзэл;
- Нийгмийн эмзэг бүлэгт хамарагсдын эрх зүйн хамгаалалтын сүл байдал;
- Үндэсний цөөнх болон нутгийн уугуул хүн амыг ялгаварлан гадуурхах үзэл;

Эдийн засгийн хүчин зүйл:

- Хувь хүний болон гэр бүлийн гишүүдийн бусдад тавьсан өр зээлийн асуудал;
- Ядуу буурай орнуудын болон нийгмийн ядуу хэсгүүдийн дундах хүнс тэжээлийн хомдолтой байдлууд;
- Тухайн бүс нутгийн тэгш бус эдийн засгийн хөгжил;
- Байгалийн гамшиг ган гачиг, үер ус, газар хөдлөлтийн үед үүссэн эдийн засгийн хямралтай байдлууд;
- Тухайн улс орны ажилгүйдлийн түвшин, орлого бага байх;
- Орлогын тэгш бус хуваарилалт;

Улс төрийн хүчин зүйл:

- Тухайн улс орнуудын дотоодын хууль эрх зүйн үр дүнтэй тогтолцоо буюу хуулийн хэрэгжилт;
- Улс орнуудын хамтын ажиллагаа болон хилийн шалган нэвтрүүлэх ажиллагааны үнэн зөв шударга авилгаас ангид байх ажиллагаа;
- Цагаач ажилчдын талаархи төрийн бодлого зохицуулалт;

Эдгээр хүчин зүйлүүд нь нэг ёсондоо эмэгтэйчүүд охидыг худалдаалан ашиг олоход түлхэц өгдөг хүчин зүйлүүд юм.

Үндсэндээ хүн худалдаалах гэмт хэргийн гол зорилго бол биеийг нь үнэлүүлж ашиг орлого олох, янхандуулах, порнографт бие дүрсийг нь ашиглах, албадан хүсээгүй хөдөлмөрийг эрхлүүлэх, арилжааны зорилгоор худалдах, хууль бус үрчлэлтийг хил дамнуулан зохион байгуулалттайгаар хийх, хүчээр албадан гэрлүүлэх зорилгуудыг тус тус агуулан асар их хэмжээний ашиг орлогыг олж байдагт оршино.

АНУ-ын төрийн департментын 2007 оны 6 дугаар сард гаргасан илтгэлд дурласанаар Африкийн Замби Улсаас охидуудыг Ирланд Улс руу, Филиппин охидуудыг Готе Де Воире руу, Доминикан эмэгтэйчүүдийг Монтенегро руу, Кени эмэгтэйчүүдийг Мексик руу, Хятад эмэгтэйчүүдийг Афганистан рүү тус тус сексийн зорилгоор, Вьетнам хүүхдүүдийг Англи руу хар тамхи мансууруулах бодис зарах үйл ажиллагаанд татан оролцуулахаар, Тайланд эрчүүдийг АНУ руу ажиллах хүчээр, Оросын оюутнуудыг АНУ руу ажиллах хүч болгон гаргаж мөлжлөг явуулдаг талаархи мэдээг оруулжээ.⁶⁷

Мөн энэ гэмт хэргийн хохирогчид нь хөдөлмөрийн мөлжлөг, сексийн мөлжлөгийн хохирогч болохоос гадна давхар хөлсгүй хөдөлмөр, боолчлолын хохирогч субъект болдог байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан судалгаагаар 12.3 сая хүн хөлсний хөдөлмөр тэр дундаа хөлсгүй боолын хөдөлмөр, албадлагын хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр эрхэлж байгааг дурджээ.

АНУ-ын Засгийн газрын тусlamжтайгаар хийсэн судалгаагаар 2006 онд 800.000 мянган хүнийг хил дамнуулан үндэстэн хооронд худалдаалсан тоо гарсан байна.

67 Trafficking in persons report,June,2007,7

Хохирогчдын хамгааллын асуудал хэрхэн шийдвэгдэх ёстой вэ?

Хүн худалдаалах асуудал өөрөө гэмт хэрэг учраас тухайн гэмт хэрэгт бүх талаараа хохирсон хүн хохирогч нь болдог.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын хувийн амьдралын талаар нууц байлгах, тэдгээрийг бие хүний хувьд тухайлбал, хүн худалдаалах гэмт хэргийн шүүн таслах ажиллагааг хаалттай явуулах арга замаар тухайн хохирогчийн эрхийг хамгаалдаг.

Хохирогчдын бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмдээ зэлэх байр суурин хувьд нөхөн сэргээх үйл ажиллагааг тогтвортойгоор явуулахын тулд бие даасан сэтгэл зүйч, эмч, мэргэжилтэн нарыг тусгай хөтөлбөр, программын дагуу бэлтгэн энэ чиглэлээр мэргэшүүлэн ажиллуулах нь хамгийн үр дүнтэй гэж тооцдог.

Энэ гэмт хэргийн хохирогчдыг эх орондоо ирэх тохиолдолд орон байраар хангах асуудал зайлшгүй яригддаг. Азийн бүсийн зарим улс орнууд тухайлбал, Филиппин, Тайланд зэрэг орнууд энэ гэмт хэргийн хохирогчдын нэлээдгүй тоог эзэлдэг улсын хувьд хамгаалах байр, түр орогнуулах байрыг төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр ажиллуулдаг байна.

Энэ гэмт хэргийг үйлдэгчид хохирогчдыг сонгож авахдаа:

- зан авирын хувьд сул дорой, хүний үгэнд оромтгой, гэнэн итгэмтгий охид эмэгтэйчүүд;
- нийгмийн эмзэг бүлэгт хамаарагсад, ахуй амьдралын хувьд ядуу, мөнгөний ямар нэгэн эх үүсвэр байхгүй, мөнгөөр байнга гачигдаж байдаг гэр бүлийн гишүүд;
- ар гэрийнхнээс нь тухайн хүний талаар огт хөөцөлдөх боломжгүй гэж үзсэн бүлгийн хүмүүс;
- боловсролын түвшин доогуур буюу огт боловсролгүй хүмүүс;
- үндэсний цөөнхийн бүлгээс тус тус сонгож авдаг байна.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд дотоодын байгууллага төдийгүй хил залгаа улс орнуудын хил, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байдаг.

Үүний тулд хил залгаа улс орнуудын хувьд хилийн хяналтыг өөрийн боломжийн хэрээр бэхжүүлэн ажиллах шаардлагатайгаас гадна хил дээр ажиллаж буй боловсон хүчинүүдийн хувьд ямар нэгэн авилгал, тохиролцооны асуудалд оролцохоос сэргийлэх зорилгоор тодорхой арга хэмжээг хамтран зохион байгуулах асуудал гарч ирдэг.

Мөн хилээр нэвтрэч байгаа тээврийн хэрэгслүүдийг хяналтандaa байлгах, тэдгээрийн талаар зохих хууль тогтоох, бусад төрлийн хяналтын арга хэмжээг байнга авч ажиллах хэрэгтэй. Улс орнуудын хилээр машин, онгоц, усан онгоц, суудлын вагон зэрэг хүн тээвэрлэх боломжтой тээврийн хэрэгслүүдэд онцгой анхаарал тавьж хяналтаа чангатгах хэрэгтэй.

Хилээр дамжин өнгөрч байгаа арилжааны тээвэр эрхлэгчид, аливаа тээврийн компани буюу тээврийн хэрэгслийн эзэмшигч болон оператор нарт бүх зорчигчид нь тухайн улс оронд нэвтрэх эрх бүхий бичиг баримт, визний ямар нэгэн асуудалгүй байх үүргийг хүлээлгэх хэрэгтэй байдаг. Энэ үүргийг биелүүлээгүй зөрчсөн тохиолдолд оногдуулах хариуцлагын механизмыг боловсронгуй тогтоож өгөх явдал нь чухал юм.

Хүнийг хил дамнуулан наймаалах үйл ажиллагааны зорилготой уялдан тухайн улсын хувь хүний гадаад паспорт, хил нэвтрэх виз зэрэг бичиг баримт нь хуурамчаар үйлдэгдэх, түүнд эрх мэдэл бүхий субъектүүд холбогдох явдал гардаг билээ.

Иймээс хүмүүсийн хувийн баримт бичгүүд, түүнийг зүй бусаар хялбар ашиглаж чадахааргүй өндөр нууцлалтай, хууль бусаар өөрчлөх, хуулбарлах, дахин ашиглах нөхцөл

боломжгүй, чанарын өндөр түвшинд хийгдсэн байх шаардлага зүй ёсоор тавигдлаг.

Үүний тулд эдгээр бичиг, баримтуудын нууцлалын чанд байдал, өндөр зэрэглэлийг хангаж ажиллах нь тухайн улсын хувьд чухал асуудлын нэг болдог.

Ер нь хүнийг хил дамнуулан наймаалах гэмт хэргийн хохирогч болдог субъектуудын хувьд хилийн шалган нэвтрүүлэх боомтоор нэвтрэх орох, гарах зөвшөөрлийг олгодог хамгийн анхны эрх мэдэл бүхий субъект нь төрийн албан хаагчид өөрсдөө байдаг. Эдгээр албан тушаалтнуудын сонор соргог мэдрэмжтэй байх ажиллагаа нь энэ гэмт хэргийг таслан зогсоох нэгэн хүчин зүйл болдог гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хүнийг наймаалах энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улс орнуудын хувьд өөр өөрийн түвшинд зохион байгуулан хийхээс гадна бүс нутаг, олон улсын хэмжээнд хамтран ажиллах явдал сүүлийн жилүүдэд нилээдгүй хэмжээгээр өсөж байна. Жишээлбэл, Зүүн өмнөд Азийн 5 орныг нэгтгэсэн Меконгийн сүлжээ байгууллага нь Тайланд, Лаос, Камбож, Вьетнам, Бирм зэрэг улсын нутаг дэвсгэрийг дайран урсах Меконг голын нэрээр нэрлэж, энэ голын урсгалыг даган байрласан эдгээр улсын хот суурин, тосгонуудаас эмэгтэйчүүд, охидыг хууль бусаар хил дамнуулан наймаалах гэмт хэргийг таслан зогсоох зорилгоор 5 орны Засгийн газрын хооронд гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Үндэсний сүлжээ байгууллагуудыг улс орнууд өөр өөрийнхөө хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулан, төрийн болон төрийн бус байгууллагуудыг түшиглэн үйл ажиллагаа явуулдаг.

Тухайн байгууллагуудыг төрөөс ямар нэгэн байдлаар үйл ажиллагааг нь дэмжих буюу тухайлбал, санхүүгийн хувьд тусlamж үзүүлэх зэргээр хамтран ажилладаг байна.

Эдгээр байгууллагуудын үйл ажиллагаанд үндэсний хэмжээний мэдээллийн сүлжээг бий болгох нь тухайн орны хууль хяналт, хил, гаалийн байгууллагуудын мэдээллийг нээлттэй, нэгдсэн сүлжээтэй болоход чухал алхам болдог.

Зарим улс орнуудын хувьд энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулан, бүх байгууллагуудыг хамруулсан мэдээлэл солицох, мэдээлэл түгээх, сургалтын хөтөлбөр боловсруулах, олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зэрэг эдгээр урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг олон нийтийн хүчинд тулгуурлан зохион байгуулахыг чухал ач холбогдолтой гэж үздэг байна.



НЯМДОЛГОРЫН САМПИЛНОРОВ

Шинжлэх ухааны дэд доктор. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга.

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСЭД УРАМ ХАЙРЛАЯ

Монгол Улсад Ардын хувьсгалт төр, засаг оршин тогтнож эхэлсэн 1920-иод оноос хойш гэмгүй, шударга хэдэн арван мянган иргэд үзэл бодол, итгэл үнэмшил, шашин шүтлэг, угсаа гарал, нийгмийн байдал, өмч хөрөнгийнхөө улмаас ангийн дайсан, хувьсгалын эсэргүү, намын эсрэг бүлэг гэгдэн ад үзэгдэж, ялгаварлагдан гадуурхагдаж, хийж үйлдээгүй хилс хэрэгт татагдаж, тухайн үеийн хуулийн хурц илдэнд амь нас, амьдрал ахуйгаа егүүтгүүлэн хэлмэгдэж байсан нь түүхэн баримтаар нотлогддог юм.

Ер нь улс төрийн талаар хүнийг хэлмэгдүүлэх нь манай хувьсгалт ардчилсан төр, засаг тогтох, мандахаас ч бүр өмнө, магадгүй хүн төрөлхтөн анги, нийгэм болж хуваагдаж байсан тэр үеэс эхэлсэн юм биш үү. Миний үншиж байсан түүхийн холбогдолтой эрдэм шинжилгээ, уран зохиолын гадаад, дотоодын олон ном зохиолуудад, кино, ший зэрэгт эрт урьд цагт болж өнгөрсөн үйл явдлууд үүнийг гэрчилж байх шиг санагддаг. Монголын хаант гүрэн оршин тогтнож байсан үед ч Манжийн хаанчлалын дарангуйллын үед ч монголын тусгаар тогтолын төлөө амь насаа зориулсан олон арван шилдэг хүмүүс улс төрийн золиос болж байсан юм байна гэж бодогддог юм. Бид зөвхөн монголын түүхийн зурvasхан үе болох 1921 оноос хойшхи үйл явдлыг л ярьж, бичиж байна. Ингэхээс ч өөр аргагүй биз.

“Улс төрийн хэлмэгдүүлэлт гэдэг бол хүн төрөлхтний түүхэнд гарсан хэзээ ч арилшгүй цусан толбууд юм” гэж НҮБ-ын Хүний эрхийн комиссоос гаргасан түүхэн баримт бичигт заасан байдаг. Энэ “цусан толбо” улс үндэстнүүдэд их бага янз бүрээр тогтож үлдсэн. Хамгийн их хэлмэгдүүлэлт амссан дэлхийн арван орны тоонд Монгол Улс багтдаг. Түүхийн баримтаас үзэхэд 1929 онд Шмераль гэж хүн коминтерны их хуралд Монголын тухай илтгэл тавихдаа манай улсын нийт хүн амыг 800 мянга гэж тэмдэглэсэн байдаг.

Гэтэл хэдхэн жилийн дараа 1940-өөд онд хүн амаа тоолж үзэхэд 600 мянга болсон байв. 200 мянган хүн хаачив!

Олонхи судлаачид үүнийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн үед цаазлагдсан, шорон гянданд нас барсан, далимдуулан хөнөөж устгасан хүмүүстэй холбож тайлбарладаг юм. Архивын материал, бичиг баримтад үлдсэнээр бол улс төрийн аймшигт хэлмэгдүүлэлтээр 40 орчим мянган хүн өртсөн гэдэг тооцоо бий. Гэтэл тэр үеийн ОХУ руу “улс төрийн хэрэгтэн” асар олон хүнийг нууцаар ачиж байсан. Тэдний хувь заяа хэзээ хаана дууссаныг тооцоолж гаргасан бүрэн төгс материал одоо хүртэл байдаггүй. Нэг жишээ авьяя.

Сибирьт нэгэн модон байшин саяхан хүртэл байсан гэдэг. Тэр байшинг нутгийнхан “Монгол байшин” хэмээн нэрлэдэг байж. Хана түүрганд нь дүүрэн монгол хүний нэр

сийлсэн. “Үхэвч Монгол минь хэвээр үлдэнэ”, “гэртээ харихсан”, “Өлзий чи минь намайг хүлээ” гэхчилэн хуучин монгол бичгээр бичсэн үгстэй байж. Жараад оны үед тэндхийн нэг ахмад орос хүн: “Дөчөөд оны үед энд монголчуудыг хорьдог шорон байсан юм. Олон давхар төмөр тортой, биднийг ойртуулдаггүй газар байсан. Дээлтэй хүмүүсийг машин машинаар ачаад явдаг байсан” гэж монгол оюутнуудад хуучилсан гэсэн. Цөөн хэдэн монголчуудыг маань хаана аваачиж, яаж хороож байсныг мэдэхийн аргагүй болж дээ.

Бичиг баримтад үлдсэн 39-40 мянган хүний 80 гаруй хувь нь шинэ үеийн сэхээтэн, эрдэм төгс лам хуврагууд байсан юм билээ. Өөрөөр хэлбэл, гадаад дотоодын харгис хар хүчин Монголын оюун санааны асар их потенциалыг бүрэн устгах боллого явуулж байсан нь эндээс ил тод байдаг.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөөгүй айл өрх, төрөл садан, ураг элгэн, аймаг, хошуу гэж тухайн үеийн Монгол Улсад байхгүй.

Хэлмэгдүүлэлтэд улс төр, эдийн засаг, өмч хөрөнгө, оюун санаа, гарал үүсэл, үндэс угсаа, түүх соёл гээд хамраагүй салбар хүрээ ч бас үгүй.

Хэлмэгдүүлэлтэд зөвхөн тухайн хүн өртөөд зогсоогүй, биеийн болон эд хөрөнгө, сэтгэл оюуны залхаан цээрлүүлэлтийг хэлмэгдсэн хүн бүрийн эцэг эхэд, хань ижил, үр хүүхдэд, удам хойчид нь танил тал, найз нөхдөд нь нэг нутаг усныханд, хамт олонд нь халдаан хэрэглэснээрээ түүний хор үршиг, үр дагавар нь хэмжээлшгүй их байсан юм.

Хэлмэгдүүлэлтэд гадны нөлөө байсан гэх боловч үнэн хэрэгтээ Монголчууд бил өөрсдөө өөрсдийгөө яллаж, өөрсдөө гүйцэтгэж, эх орон нэгтнүүдээ бусдын гар т өөрсдөө барьж өгч, харийн нутагт өөрсдөө хүргэж, харийн хүний илдээр, харийн улсын хуулиар шийтгүүлж байсан нь түүхийн гашуун үнэн юм.

1940-өөд оноос хойш энэ явдал арга хэлбэрээ өөрчлөн, үе шаттайгаар хэлмэгдүүлэх боллого явагдаж байсан нь ч одоо тодорхой болжээ. 1950-иад оны үед “Сэхээтний төөрөгдөл”, “Төмөр-Очирын хэрэг”, “Цэндийн асуудал” улмаар, 1960-1970-аад оны үед “Намын эсрэг бүлэг”, 1970-1990 онд “Гавьяя найрууллын хэрэг”, “Хэвлэл номынхны асуудал”, “Түүхчдийн асуудал” гэхчилэн сэхээтнүүдээ хоморголон устгах арга хэмжээ авч 15 хүнийг шоронд гэсгээн цээрлүүлж, олон зуун хүнийг ажил албанаас нь зайлуулан цөлж, Улсыг Аюулаас хамгаалах байгууллагын хяналтад мөрдөн мөшгөж, тамлан зовоож байсан юм. Зөвхөн “Намын эсрэг бүлэг” гэгч зохиомол зүйл гарган ирж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн 200 гаруй сэхээтнийг ял зэмлэлд унагаж, гэр бүл, үр хүүхэд зэрэг 2000 гаруй хүнийг ажил амьдралаар нь хохироож байлаа.

Элгээр хоморголон шийтгэгдсэн хүмүүс нь манай улсын оюуны асар их потенциалтай шилдэг тэргүүний сэхээтнүүд байсан юм.

Хүн бүрт нээгддэг байсан “Анкет”, хүн амын тооллогын нэг гол асуулт нь “Ард уу?”, “Тайж уу?” гэдэг, удам судрын судалгаа байлаа. Энэ “Анкет”-аар үндэслэн тайж гаралтай бүх хүнийг устгах боллого барьж байв. “Тайж гарал” гэдэг нь их Богд эзэн Чингисийн ураг удмыг хөнөөж дуусгах боллого байсан гэж түүхчид хариулдаг юм билээ.

Монголын төрсүүлийн жилүүдэд улстөрийн хэлмэгдэгсэд, тэдний үе залгамжлагчдын талаар ихээхэн анхаарал тавьж, олон чухал арга хэмжээ авч байгаа. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссыг УИХ-ын дэд даргаар удирдуулан ажиллуулж, хэлмэгдэгсдийг цагаатгах, нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, нөхөн олговор олгох, зарим хөнгөлөлт арга хэмжээний талаар хууль, эрх зүйн орчин бүрдүүлж өглөө. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгаж эхэлсэн 1939 оноос хойш 29,0 мянга орчим иргэнийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээсэн байна.

Хэлмэгдэгсдэд нөхөн олговор олгож эхэлсэн 1998 оноос хойш өнөөг хүртэл 16,9

мянган хүнд 15,7 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгоод байна. Тэрчлэн, улс төрийн хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхэд 600-гаад хүнд байр сууц олгох, буцалтгүй мөнгөн ба эд материалын тусламж үзүүлэх, зарим талын хөнгөлөлтөд хамруулах зэрэг олон ажил дэс дараатай хийгдэж байна. Гэвч энэ бүхэн нь хэлмэгдсэн хүмүүсийн болон тэдний гэр бүл, үр хүүхдийн амссан зовлон, үүрсэн ачаа, сэтгэл санааны болон эд материалын хохиролтой жишиж үзэх юм бол дуслын төдий зүйл юм. Хэлмэгдсэн хүн, тэдний гэр бүлийнхний туулсан зовлонг, өөрийн биеэр үзээгүй хүн тэгтлээ ойлгодоггүй юм билээ. Тэгээд ч улс төрийн хэлмэгдэгсдэд хүйтэн цэвдэг сэтгэлээр хандах, тохуурхаж, доромжлох “эсэргүү” байдаар хандах явдал одоо хүртэл зарим хүний бодол санаанд байдаг бололтой.

Сэтгэл санааны болон эд материалын асар их хохирол амсаад, тэр хатуу ширүүн үеийг сэтгэлийн хатаар туулж, одоо амьд сэргүүн байгаа, зуу хүрэхгүй хэлмэгдэгсдээдээ урам хайлаж хорвоогоос буцаах юмсан гэхдээ эл өгүүллийг өчүүхэн би бээр тэрлэж байгаа юм.

Өнөөдөр улс орны маань эдийн засгийн чадавхи сайнгүй байгаагаас улс төрийн хэлмэгдэгсдээдээ аваад өгөх мөнгө хөрөнгө хомс, орон сууц, эд материалын боломж тун бага гэдэг нь ойлгомжтой. Хамгийн гол нь тэдэнд сэтгэл санааны урам хайлрах явдал чухал байна. Өнөөдөр амьд сэргүүн байгаа хэлмэгдэгсэд маань ид бүтээж, туурвих 30-40 наасны үедээ арга хэмжээ авахуулж, хамаг сайхан үеэ алдсан хүмүүс. Гэтэл тэднийг улс төрийн үзэл бодлоор нь өнөө хүртэл ялгаварлан үзэж, шагнал урамшууллаас хасах явдал түгээмэл байгааг цөөн хэдэн хүнээр жишээ болгож авья.

“Төөрөгдсөн сэхээтэн” гэгдэж, тэргүүн эгнээнд арга хэмжээ авагдаж байсан МХЗЭ-ийн Төв хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, агсан Н.Дангаасүрэн гуай 80 гаруй настай, эрдмийн ажлаа гар салгалгүй зүтгэж байж доктор профессор болсон. 70 насыг хол давсан хөгшин нь олон жил хэвтээрт, өөрөө зүрхний хүнд өвчтэй, зургаан настай гуч охинтойгоо өрөвдөлтэй амьдарч байгаад насан өөд болсон. 60 жилийн бүтээлд нь Шинжлэх ухааны гавьяат ажилтан ч юм уу, Төрийн соёрхол олгох ч юм уу, ядаж одон медалиар шагнаж болно оо доо. Гэтэл тэр хүн бүрмөсөн мартагдав.

“Намын эсрэг бүлэг” гэгчийн гол төлөөлөгч Ц.Лоохууз, өнөөгийн ардчилал, зах зээлийн бодлогыг олон арван жилийн өмнө урьдчилан харж, хурал дээр шулууун шударга үг хэлснийхээ төлөө арга хэмжээ авахуулан, шоронд тамлагдаж байсан буурал өвгөн сангийн аж ахуйнуудыг удирдах газрын даргаар ажиллахдаа монголын атар газар эзэмших их хөдөлгөөнийг удирдаж байсан билээ.

Атар газар эзэмшсэний 40 жилийн ойгоор УИХ-ын гишүүн асан Ш.Гунгаадорж гуайг Сүхбаатарын одонгоор шагнахад тэрээр “Надаас өмнө энэ шагналыг авах хүн Лоохууз гуай л байсан юм даа” гэсэн гэдэг. Хүндтэй энэ хүний жинтэй үгийг нь өнөө хэр мэдэрч ойлгоогүй л байна. Энэ хүний удирдлагад ажиллаж, тодорхойлолтоор нь хөдөлмөрийн баатар болсон олон арван хүн бий.

Ц.Лоохууз Говь-Алтай аймгийн Намын хорооны нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллах хугацаандаа Гуулингийн услалтын системийг байгуулахаар шамдан хөөцөлдөж, анхны суурийг нь тавьж, аймгийн бүтээлч олон түмнийг энэхүү чухал ажилд гардан удирдаж байсан. Өнөөдөр түүний санаачлан зохион байгуулж хийлгэсэн 22 км-ийн урттай Гуулингийн суваг, услалтын систем хэвийн ажиллаж байна. Энэ нь Ц.Лоохуузын залуу зандан үеийн нөр шаргтуу хөдөлмөрийн нэгээхэн хэсэг нь гэж үзэх үндэстэй.

Ц.Лоохууз гуай яагаад Төрийн өндөр дээд шагнал хүртэж болохгүй гэж?

Монголын нэért одон орон судлаач С.Нинжбадгар нь түүний хань Д.Төмөр-Очир дарга арга хэмжээ авахуулан цөлөгдөж, тамлагдаж явахад “Би төртэй суугаагүй, Төмөр-

Очиртой суусан” гээд хамаг хүнд бэрхийг нь үүрэлцсэн, ханийнхаа зовлонг хуваалсан байна. Монголын одон орон судалын үндсийг тавьж, олон арван шилдэг бүтээлээрээ үе үеийн сэхээтнүүдийг хүмүүжүүлсэн энэ эмэгтэй ямар ч гавьяа цолонд хүрч чадалгүй наян насыг хол давжээ.

Монгол Улсын гавьяат багш байтугай, Ардын багш цолыг аль хэдийнээ авсан байх учиртай Ш.Бат-Очир, Д.Лхамжав, Д.Юмжав, П.Санж нарын олон эрдэмтэн багш сурган хүмүүжүүлэгчид, инженер техникчид Монгол төрийнхөө хайр хишгийг хүртэж чадалгүй зарим нь нас барж, зарим нь наян насныхаа нурууг элээжээ. Философич Д.Лхамжав монголын сор болсон эрдэмтдийн нэг байсан бөгөөд хэлмэгдлийн хүнд бэрхийг дааж чадалгүй нас барсан. Тэр хүний зохиосон “Монгол-Англи” хэлний олон мянган үгтэй анхны, үндэсний толь бичгийг хэвлэж өгөөгүйгээр үл барам, тэр том бүтээл чухам хаа яасан нь мэдэгдэхгүй сураггүй алга болсон.

Зохиолч Тангадын Галсанд хорин хэдэн настайгаас нь эхлэн нутаг зааж, хүнд хүчир ажилд нухлуулсан билээ. Тэрээр хэлмэгдэж явах хугашаандaa үншигчдын талархал хүлээсэн тавиад ном бичиж, монголын зохиолчдоос сод авьяасаараа тодорсон хүн. Хориодхон насандаа бичсэн “Арвайхээр” найраглалаараа л Төрийн соёрхол авах бүрэн боломжтой яруу найрагч байсан гэж зохиолч нөхөд нь болон олон түмэн ярьдаг юм билээ. Одоо дал гаруй насыг шүүрсэн буурал өвгөн болсон ч Төрийн шагналт олон арван зохиолчдын дунд түүний нэр байдаггүй. Яагаад гэсэн асуултад “хэлмэгдэж явсан учраас” гэсэн ганцхан хариулт бий.

Улс даяар шуугисан “Гавьяа” найрууллыг бичсэний учир арга хэмжээ авагдан нутаг заагдаж, бүтээл туурвих ид үеийг усан дунд зогсон ажиллаж, мод үүрч өнгөрөөсөн зохиолч сэтгүүлч Г.Жамъян өнөөдөр далан нас зооглож яваа ч үзэг цаасаа нийлүүлсээр сууж байна. 50 гаруй жил сэтгүүлчийн нэр хүнд хөдөлмөрийг эрхлэн, өнөөдөр өдөр тутмын сонинд сурвалжлагчаар ажиллаж байгаа хүн Жамъян гуайгаас өөр байхгүй. Сэтгүүлчдийн байгууллага, хамт олон нь Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол олгуулахаар олон удаа тодорхойлсны эцэст саяхан л энэхүү хүндэтэй цолыг хүртсэн дээ.

Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбооны тэргүүнээр ажиллаж байсан А.Дашнамжил гэж өвгөн байлаа. “Намын эсрэг бүлэг” гэгч хилс хэрэгт холбогдуулан Гурван Тэсийн давсны үйлдвэр, Түмэнцогтын САА-д ажиллуулсан 24 жилд тэрээр асар их зүйлийг хийж бүтээсэн хүн юм билээ. Олон зүйлийн шинэ санаачилга, ажлын арга барилаар тухай үеийн ханшаар 20 гаруй сая төгрөгийн цэвэр ашиг улсад оруулж байсан нь тэр үеийн хөдөлмөрийн баатар болж байсан хүмүүсийн жишгээс даруй 2-3 дахин дээгүүр байсан гэдэг. Гэтэл түүний тэрхүү хөдөлмөрийг нь төр засаг үнэлэлгүй өдий хүрч, өвгөн буурал саяхан ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн.

Хурал дээр үг хэлснийхээ төлөө “Намын эсрэг бүлэг” гэгчид багтсан Хөдөлмөрийн баатар З.Лувсансамбуу гуайг нас барахад нь Алтан-Өлгийд газар өгөлгүй өөр газар оршуулж байсан жишээ ч бий.

Ийнхүү үзэл бодлынхoo зөрүүгээр хилс хэрэгт арга хэмжээ авагдсан мянган шилдэг сэхээтэн, жирийн хүмүүс, хөдөлмөр бүтээлээ үнэлүүлж чадалгүй, төрийнхөө хайр ивээлд багталгүй хорвоог орхисоор одоо 100 хүрэхгүй хүн үлдээл байна. Энэ хүмүүс бол бүгд, түрүүн нэрлэсэн цөөн хэдэн хүний адил, нэр нь тодроогүй гавьяат үйлстнүүд юм. Гол нь, ажил амьдралаараа хохирсон хөөрхий тэдэнд урам хайлж, хорвоог орхихоос нь өмнө ганц удаа ч болов баярлуулбал, цагаасаа өмнө суусан үрчлээний нь нэг нь ч болов арилж, цагаан судал татсан үснийх нь ширхэг бөхжихсөн дөө.

Монголын Улс төрийн хэлмэгдэгсдийн холбоо түрүү нэгэн ойгоор хэлмэгдсэн 18 хүнээ Төрийн дээд гавьяа шагналд тодорхойлсон юм билээ. Гэтэл тэр 18 хүний нэгэнд

нь ч шагнал олдоогүй Монгол Улсын төр, засгаас иргэлдээ олгодог шагнал гэдэг нь улс эх орныхоо төлөө зүтгэсэн зүтгэл, хийсэн бүтээл, байгуулсан гавьяаг нь үнэлж олгодог урамшил мөн биз дээ.

Улс төрийн хэрэгтэн биш гэдэг нь түүхийн баримтаар нотлогдож, хууль хяналтын байгууллагууд хилс хэрэг байжээ гэдгийг нь батлан цагаатгаж, тэр ч байтугай арга хэмжээ авч, буруутгаж байсан байгууллагууд нь буруугаа хүлээж, училалт гүйгаад хилсээр авсан арга хэмжээгээ хэрэгсэхгүй болгосон нөхцөлд ч, хэлмэгдүүлэлтэд өртөхөөсөө өмнө байгуулсан гавьяаг нь, хэлмэгдүүлэлтийн он, жилүүдэд ялтан, хэрэгтэн болж явахдаа хийж бүтээсэн хөдөлмөрийг нь эргэн харж, үнэлж дүгнэж, тэднийг Төрийн дээд шагналаар нэхэн шагнаж болохгүй гэж үү?

“Урмыг нь хугалахаар ууцыг нь хугал”, “Бурмаар тэтгэхээр урмаар тэтгэ” гэхчилэн Монголчуудын сайхан үгс бий. Улс төрийн хилс хэрэгт идэр, залуу, хамаг сайхан наасаа өнгөрөөж, амьдралаараа хохирсон цөөн хэдэн хүнээ урмаар тэтгэх юмсан. Хойч үед маань сургамж болохсон болов уу. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний үр хүүхэд, төрөл төрөгсөд Монголынхoo түүхэнд бүтэн нэртэй, цагаан мөртэй, дуурсах алдартай үлдэх болтугай!

ДАШААГИЙН ЦЭДЭНБАЛ



Монгол Улсын Сангийн яамны ахлах түшмэл.

Эрдэм шинжилгээний ажил, судалгааны бүтээлүүд

Хүүхдийг хөгжүүлэх талаар 2000 он хүртэл баримтлах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр (1993),
Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (1994),
Монгол Улсын төрөөс баримтлах хүн амын боллого (1996),
Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр, түүний нэмэлт (1996,1999),
Өрхийн амьжиргааг дэмжих үндэсний хөтөлбөр (2001),
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр (2001),
Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002),
Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2002),
Хүүхдийн эрхийг хамгаалах тухай (1996, 2003) хууль,
Хөдөлмөрийн тухай (1999) хууль,
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (2001) хууль,
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2004) хууль,
Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах боллого (2003),
Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах боллого (2004)

ХҮНИЙ ХӨГЖИЛ БА ЖЕНДЭРИЙН ОЙЛГОЛТ, ЖЕНДЭРИЙН ЧИГ ХАНДЛАГЫГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТУХАЙ

Сүүлийн жилүүдэд манай улс хөгжлийн түвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас хүний хүчин зүйлсийн нөлөөллийг чухалчилдаг дэлхий дахинь нийтлэг үзэл баримтлалд анхаарал хандуулж байна. Монгол Улсад өрнөсөн ардчиллын ач буянаар хүний хөгжлийг хангах хөрс суурийг баттай тавьж чадсандаа ард түмэн бил сэтгэл хангалийн байх бүрэн үндэстэй юм. Өнөөдөр манай улсад хүн ажил мэргэжил, амьдралын арга замаа сонгох, өөрийн ажил амьдралын талаарх аливаа асуудлыг хөнгөн шийдвэр гаргахад нөлөөлөх, түүнийг хянах бололцоогоор улам бүр хангагдаж байна.

Монгол Улсын хөгжил дэвшилийн үндэс нь эрдэнэт хүн байх нь эргэлзээгүй бөгөөд хүний хөгжил бол Монгол Улсын урагшлах хөгжил дэвшилийн угтвар нөхцөл, хүрэх өндөрлөг юм.

1. Хүний хөгжлийн тухай ойлголт

Сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд дэлхийн улс орнуудын эдийн засаг эрчимтэй хөгжиж, тодорхой амжилтад хүрсэн хэдий ч ядуурал, ажилгүйдэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл улам бүр нэмэгдэж, нийгэмд шийдвэрлэгдээгүй асуудал хуримтлагдсаар байна. Хөгжлийн тухай ойлголтыг 1980-aad оны энээс 1990-ээд оны эхээр шинэчлэн томъёолж, улмаар “Хүнтөвтэй хөгжил”, “Тогтвортой хөгжил” гэсэн шинэ нэр томъёог өргөн ашиглаж, улс орнууд хөгжлийн чиг хандлагаа үүнэ чиглүүлэх болжээ. Хүний хөгжил болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг харуулах үүднээс дэлхийн улс орнуудад хүний хөгжлийн тухай ойлголт, түүнийг хэмжих аргазүйг хөндөн судалж, улам бүр баяжуулан хөгжүүлж, боловсронгуй болгосоор байна.

Хүмүүний тухай үзэл хандлага. Хүн бол хөгжил дэвшил, соёл иргэншлийн охь манлай, түүнийг тэжээн тэтгэгч хүчин билээ. Хүний аж төрөхүйн хамаг утга учир, хүч чадал, онцлог шинж оюун билэгтээ оршдог. Хүн төрөлхтний оюуны эрэл, таамаглал,

үзэл бодол, сурах, судлах үйл, хүсэл эрмэлзэл хязгааргүй юм. Хүнийг тэгш, тогтвортой хүндэтгэх үзэл бол хүний нийгмийн хөгжлийн хамгийн дээд бөгөөд чухал чиг шугам, нарийн чанд дэг ёс юм. Хүн гэдэг бүхэл бүтэн ертөнцийг олон талаас нь танин мэдэх ёстой ажээ. Хүнийг бие махбодь, оюун санаа, эрдэм мэдлэг, ёс суртахуун, үйл хөдлөл талаас нь иж бүрэн танин мэдэхгүйгээр зөвхөн нэг талаас нь өрөөсгөл хандвал түүнийг ойлгох үзэл, дэг ёс маань гажихад хүрнэ. Хүний бие сэтгэл, оюун ухаан, ааш араншин, ажил байдал, мэдлэг чадвар, зан төлвийн онцлог шинжийг судлан тогтоож чадваас хүнд хандах чиг хандлага өөрөө зөв гольдролд хөтлөгдөх болно.

Хүн гэж хэн бэ? Хүн бол бие, оюун ухааны хязгааргүй хүчин чадал бүхий цогцос юм. Хүнийг үл ялгаварлах, ялгаварлах хоёр янзын үзэл хандлага байна.

Нэгдүгээрт, хүнийг оршин суугаа тив дэлхий, газарзүйн орчин, улс үндэс, гарал үүсэл, ястан үндэстэн, язгуур угсаа, арьс өнгө, эр эм, боловсрол мэдлэг, хот хөдөө, авьяас билэг, хөгжлийн түвшингээр үл ялгаварлах үзэл юм. Манай гарагийн хүн бүрийн оюуны ерөнхий чадвар онсын ялгаваргүй байдаг ажээ. Тэгэхлээр нэг нь нөгөөдөө дээрэлхэх, нөгөөгөө гадуурхах, үзэн ядах утга учир онол, практикийн хувьд байх ёсгүй билээ. Ийнхүү үл ялгаварлах үзлийн практик алхам тухайлбал, АНУ-д бусдаас илүү дээгүүр түвшинд хэв ёс болсон байна.

Хоёрдугаарт, Хүнийг засаг захиргаа, иргэншил, бие махбодийн давтаглашгүй онцлог ялгаа, ёслол хүндэтгэлийн зарчим, дэг горим, нас хүйс, аж төрөх арга хэлбэр, хөрөнгө чинээ, мэргэжлийн төрөл, гэр бүл, олон нийтийн олгосон хүмүүжил зэргээр ялгаварлах үзэл хандлага дэлхийн зарим улс орон, бүс нутагт шашин, уламжлалтай холбоотойгоор байсаар байна. Эдгээр үзэл хандлага нь хүмүүсийн хоорондын харилцаанд янз бүрээр илэрч, аливаа зөрчил, тэмцэл үүсгэж байдаг үзэгдэл юм. Хүн бүр үндсэндээ адил тэгш эрхтэй төрсөн байтлаа нэгэндээ дээрэлхэн доромжлох, нэгийгээ сайхан муухай, өнгө зүс, яс үндэс, угсаа гарлаар ялгах явдал утгагүй зүйл билээ. Үнэндээ хүнийг дээдэс доодос, эрх тушаалаар, нас хүйсээр, өнгө зүсээр, ажил төрлөөр, хөрөнгө чинээгээр ангилан зааглаж, аливаа хэл яриа үүсгэх, өш хонзон санах, хов зөөх, ая тал засах зэрэг үйлдэл бол хүн чанаргүй бөгөөд хүнийг үзэх гаж буруу үзэл ойлголт, ухагдахуун мөн.

Хүмүүнийг аугаа их ухаан, асар их хүч, хөгжил дэвшилийн ноён нуруу, гүйцэд судлагаагүй, хүч нөөцөө бүрэн дэлгээгүй ертөнч гэж тодорхойлж болно.

Хүний хөгжлийн үзэл баримтлал. Хүний хөгжил байгаль, нийгмийн хэмээх хоёр эх сурвалжтай болой. Хүний хөгжил өөртөө бие хүний тухайд хувийн шинж, нийгмийн тухайд соёл иргэншлийн шинжийг агуулна. Ер нь хүний хөгжилд цаг хугацааны хязгаар, тасралт гэж байхгүй болохоор өдөр тутмын буюу байнгын шинж чанартай үйл явц юм.

Хүний хөгжил гэсэн ойлголтод **нэгд**, хүний байгаль шинжийн хөгжил, **хоёрт**, хүний соёл иргэншлийн хөгжил, **туравт**, хүний нийлмэл шинж буюу хувийн шинж чанарын хөгжил хамаарна.

Хүний байгаль шинж нь сая сая жилийн шалгарал буюу хувьсал өөрчлөлтөөр хуримтлагдсан баялаг, дархлагдсан өв, удам дамжин ирсэн бие, оюуны чадавхи юм.

Хүний соёл иргэншлийн шинж нь хүний хамтын хүчин чармайлт, хөдөлмөр зүтгэл, үзэл бодол, үйл ажил, аж төрөх арга ухаан, туршлага, сургамжийн түүхэн замнал буюу хүн төрөлхтний нийтлэг хөгжлийн хэв загвар юм.

Харин **хүний нийлмэл буюу хувийн шинж чанар** гэдэг бол тухайн тодорхой бие хүний байгалийн ба нийгмийн шинж хосолсон нэгэн насанд олдох тэрхүү боломж, чадвар хамаарна. Ингэхлээр хүн хөгжинө, хүнийг хөгжүүлнэ гэдгийн цаана хүний хөгжлийн эх сурвалж, хөгжлийн төв цэг, хүн хөгжих арга зам, саад бэрхшээл хаана оршин буйг сөхөн тавих шаардлага зүй ёсоор урган гарч ирнэ. Энэ бүхний хамгийн гол зангилаа

нь ХҮН хэмээх дээд төрөлт амьтан маань өөрөө бүхий л хөгжил дэвшилийн оргил буюу тэргүүн манлайд явж ирсэнд байгаа юм. Гэхдээ нэгэн зүйлийг нэлээд гүнзгий ухааран хичээхгүй бол багагүй төөрөгдөл орж болох юм. Тэр зүйл бол хүний төрөлх чанар ба нэгэн насны амьдралын олдмол чанар хоёрын харицсан шүтэлцээг зөв мэдрэх, зөв танин мэдэх шаардлага зүй ёсоор тавигдаж ирсэн байна.

Хүний төрөлх чанар бол хүний үүсэл, хөгжлийн бүхий л түүхэн үйл явцыг агуулан хөгжиж, удамшин дамжиж, шилэгдэн шалгарч үлдсээр ирсэн бэлэн боломж буюу далд нөөц, үндсэн суурийн тухай ойлголт юм. Энэ бол хүн хоёр хөл дээрээ тэнцэн явж, хоёр гарыг хөдөлмөрийн хэрэгсэл болгон чөлөөтэй ашиглаж, уураг тархины сэтгэхүйн хуулиар бүхнийг жолоодож, харах зүйлийг харж, сонсох зүйлийг сонсож, мэдрэх зүйлийг мэдэрч, тэр бүгдийг бодол санаандаа буулгаж, бодитой биетэй зүйлийг оюуны бүтээл болгож, оюуны бүтээлийг биетэй зүйл болгож чадах болсон түүхэн чадавхийг хэлж буй хэрэг юм. Энэхүү чанарыг хэрхэн ашиглах, юу бүтээхийг хүлээж байдал тодорхой хүч чадал, боломж дээрээ түшиглэн хүн болох, хүн шиг амьдрах үндэс бүрдлэг байна.

Хүний нэгэн насны амьдралын олдмол чанар бол хүн нэрийг олж төрөөд, өсөн торниж, амьдралаа залах зорилго, тэмцэлтэй холбоо бүхий үйл явцын тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хүний зам мөрийг олсон нэгэн насны төөрөг дотор хүний бүхий л амьдралын турш өөрт олдсон хувь заяандаа түшиж явна уу, эсвэл шинээр хүч чадал, чадвар улам сууж явна уу гэдгийн шалгуур сорилыг хүн өөртөө ухаалгаар тавьж, мэдлэг, чадвараа зохистой үнэлэн цэгнэж, аж төрөх явдал юм. Үүнтэй уялдаатайгаар хүн хэмээх баялаг, хүний нөөц, хүний чадамж (хүний чадавхит+ хүний чадвар), хүний хүчин зүйлийг хөгжилд ухаалгаар ашиглах үзэл баримтлал, чиг хандлага гарч ирсэн байна.

Хүний хөгжлийн цар хүрээ. Аливаа улс үндэстний хамгийн үнэтэй, юугаар ч сольшгүй эрхэм нөөц баялаг бол хүн байдал. Улс орны хөгжлийн үндсэн зорилго үнэт баялаг болох эрдэнэт хүнийг урт удаан наслах, эрүүл саруул амьдрах, бүтээлчээр ажиллах, амьдрах таатай орчин, боломж нөхцлийг бүрдүүлэхэд оршдог байна. Хүний хөгжил нь өргөн цар хүрээтэй ойлголт юм. Хүний хөгжил гэж хүн бүрт тэгш боломж олгох, тэрхүү боломжийг үе дамжин хадгалах, хүний эрх мэдлийг баталгаажуулах замаар тэдний амьдрал ахуйдаа өөрийн сонголт явуулах боломжийг өргөжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хэлнэ. Зарчмын хувьд эдгээр сонголтод ямар нэг хязгаарлалт байхгүй бөгөөд харин эдгээр нь цаг хугацааны хувьд байнга хувьсан өөрчлөгдөж байдал. Гэвч хөгжлийн ямар ч түвшинд хувь хүнд нэн хэрэгтэй, хамгийн чухал гурван хүчин зүйл байдал. Энэ бол **нэгдүгээрт**, эрүүл саруул амьдарч, урт удаан наслах; **хоёрдугаарт**, эрдэм боловсрол, мэдлэг чадвар эзэмших; **гуравдугаарт**, сайн сайхан амьдрахад хүрэлцээтэй нөөц баялагийн эх үүсвэртэй байх явдал юм. Хэрвээ энэхүү гурван чухал боломжийг хэрэгжүүлж чадаагүй буюу хэрэгжүүлэх бололцоогүй нөхцөл бусад олон таатай боломж, сонголтын тухай ярих аргагүй юм. Хүний хөгжилд эдгээр гурван шийдвэрлэгч хүчин зүйлээс гадна улс төр, эдийн засаг, нийгмийн эрх мэдэл, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрх эдлэх, амьдрах нийгмийн баталгаа, бие биеэ хүндлэх, соёлын өв, үнэ цэнэ зэрэг олон асуудал хамрагдах төдийгүй эдгээр нь хувь хүний боломж, бололцоог өргөжүүлэн хөгжүүлэхэд зайлшгүй чухал хүчин зүйл болдог.

Хүний хөгжил өөрөө хоёр талтай асуудал юм. Нэг талаас хувь хүн эрүүл саруул байж, эрдэм боловсрол, мэдлэг чадвар эзэмших замаар өөрийн сонголтыг илэрхийлэх чадвартай байх, нөгөөтэйгүүр өөрийн чадвараа амьдралд үр ашигтайгаар, бүтээлчээр ашиглах, соёл урлаг, биеийн тамир, нийгмийн болон улс төрийн амьдралд идэвхтэй оролцох бололцоо, нөхцлийг нэмэгдүүлэх явдал юм. Хэрвээ хүний хөгжлийн энэхүү хоёр тал тэнцвэрт байдлаа алдах тохиолдолд хүний хөгжил хямралд ордог байна.

Хүний хөгжлийн ухагдахууны үндсэн бүрдэл хэсэгт хүний бүтээмжийг дээшлүүлэх; хүний тэгш боломжийг хангах; хүний хөгжлийн тогтвортой байдлыг хадгалах; хүний эрх мэдлийг баталгаажуулах явдал хамаарна. Хүний хөгжлийн тогтвортой байдал гэдэг бол өнөөгийн хүрсэн боломж зөвхөн эдүгээ цаг дор төдийгүй дараа дараагийн үед залгамжлан хүртээмжтэй байх, улмаар бүх төрлийн нөөцийн (хүний нөөц, биет нөөц, байгалийн нөөц, санхүүгийн нөөц) эх үүсвэрийг хөгжүүлэх ойлголт юм.

Хүний хөгжлийг агуулга талаас нь үзвэл орлого өөрөө чухал хүчин зүйл хэдий ч мөнхүү сонголтын зөвхөн нэг хэлбэр юм. Хүн бүр хангалттай орлого олох, амьдралаа өөд татахыг хүсэж, түүний төлөө тэмцэж гол чухал сонголт хийдэг боловч орлого өөрөө хүний амьдралыг бүхэлд нь шийдвэрлэж чадлаггүй байна. Учир юу гэвэл:

(1) Нийгмийн сайн сайхан байдал нь орлогын түвшингээс бус харин орлогыг хэрхэн хуваарилж, юунд яаж ашиглаж зарцуулснаас голлон хамаардаг байна.

(2) Орлогын түвшин доогуур хэдий ч хүний хөгжлийн түвшин дээгүүр байх буюу орлогын түвшин өндөр хэдий ч хүний хөгжлийн түвшин доогуур байдгийг дэлхийн улс орнуудын туршлага харуулж байна.

Хүний хөгжлийн хэмжүүр. Хүний хөгжил гэдэг энэхүү нэр томьёо нь хувь хүний амьдралын сонголтын боломж, бололцоог өргөжүүлэн хөгжүүлэх үйл явц төдийгүй сайн сайхан байдалд хүрсэн түвшинг илтгэн харуулдаг ойлголт юм. Хүний хөгжлийг хэмжих нийтлэг үзүүлэлт нь **хүний хөгжлийн индекс** (англиар *Human Development Index-HDI*, оросоор *Индекс развития человеческого потенциала-ИРЧП*) юм. Хүний хөгжлийг хүний амьдралын гурван үндсэн хэмжээс болох дундаж наслалт, мэдлэг чадвар, амьдралын боломжит түвшинд тулгуурлан тодорхойлдог.

Нэг дэх үзүүлэлт бол төрснөөс хойших үеийн наслалтыг тодорхойлох **дундаж наслалт** юм. Дундаж наслалт нь эрүүл мэндийн ба хоол тэжээлийн хувьд боломжийн байсныг шууд бус байдлаар илтгэн харуулдаг учраас хүний хөгжлийн чухал үзүүлэлт болж байгаа юм.

Хоёр дахь гол үзүүлэлт нь **мэдлэг чадвар** юм. Орчин үеийн нийгэмд үр бүтээлтэй амьдрахад дээд зэргийн чанартай боловсрол эзэмших явдал маш чухал. Бичиг үсэг мэдэх явдал нь хувь хүний сурах, мэдлэг боловсролоо дээшлүүлэхийн эхний суурь үндэс болдог. Эдүгээ цагт өргөн утгаар үзвэл аливаа хүн наад тал нь үндэсний бичиг үсгийн боловсрол; байгаль, экологийн боловсрол; энх тайвны боловсрол; соёлын боловсрол; мэдээллийн технологийн боловсрол эзэмших ёстой болжээ. Иймээс бичиг үсэгт тайлагдах явдал хүний хөгжлийг хэмжих бас нэг гол хэмжүүр болдог.

Гурав дахь гол үзүүлэлт нь хүний боломжит амьдралыг хангахад хүрэлцэхүйц хэмжээний нөөц баялаг хэр зэрэг хүртэж байна вэ гэдгийг хэмжих явдал бөгөөд үүнд олон үзүүлэлтийг хамруулж болох юм. Гэвч дэлхий нийтийн практикт **орлого** тухайлбал, **нэг хүнд ногдох жишмэл бодит ДНБ-ний хэмжээг** хүний хөгжлийг хэмжих гол үзүүлэлт болгон хэрэглэж байна. **Өөрөөр хэлбэл**, орлого нь худалдан авах чадварын харьцаа хэмжээ болон орлого нэмэгдэхийн хэрээр өгөөж буурах илтгэлүүрээр засварлагдсан нэг хүнд ногдох жишмэл бодит ДНБ-ээр тодорхойлогддог.

Хүний сайн сайхан байдалг илэрхийлж чадах хөгжлийн үзүүлэлтийг тогтоох чиглэлээр олон улсын хэмжээнд нэлээд эрэл хайгуул хийгдсэн байна. Түүний нэг болон **Амьдралын чанарын индекс** (англиар *Index of life quality-IOLQ*, оросоор *Индекс жизненного качества-ИЖК*)-ийг зарим эрдэмтэд (Моррис, Акалпин нар) зохиосон байна. Энэхүү индексийг нялхсын эндэгдэл, дундаж наслалт, насанда хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэг гэсэн 3 үзүүлэлтээр тооцдог. Гэхдээ нялхсын нас баралтын (1000 амьд төрөлтөд) дээд хэмжээг 229, доод хэмжээг 7; дундаж наслалтын дээд хэмжээг 77, доод хэмжээг

39 гэж авдаг ажээ. Харин бичиг үсгийн мэдлэгийн индексийг 15 ба дээш насны хүн амд бичиг үсэг мэддэг хүний эзлэх хувиар тооцно.

Амьдралын чанарын индекс нь бичиг үсгийн мэдлэгийн индекс, нялхсын нас баралтын индекс, дундаж наслалтын индексийн арифметик дундаж юм.

Хүний хөгжил ба ядуурлын харилсан хамаарал. Хүний хөгжил нь хувь хүний аливаа сонголт явуулах боломж, бололцоог өргөжүүлэн хөгжүүлэх асуудлыг хөндөн тавьдаг байхад **хүн амын ядуурал** нь хүний эрүүл энх аж төрөх, урт удаан наслах, бүтээлчээр сэтгэх, нийгмийн таатай орчинд хангалаун сайхан амьдрах, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, өөрийгөө болон бусдыг хүндлэх зэрэг хүний хөгжлийн хамгийн наад захын боломж, бололцоо, сонголтуудыг хялан боогдуулдаг байна.

Хүний хөгжил, ядуурал гэсэн энэхүү эсрэг, тэсрэг хоёр ойлголт нь хөгжлийг үнэлж, цэгнэх хоёр хандлагыг бий болгодог байна. Нэг дэх нь тухайн нийгэм дэх ядуугаас баян хүртэлх нийгмийн бүлгүүдийн хүрсэн олоот, амжилт, сайн сайхан хөгжил дэвшилд тулгуурласан “**conglomerative**” буюу “**хуримтлалын**” хандлага, хоёр дахь нь үүний эсрэг байр сууринаас хандсан нийгмийн хөгжлийг ядуу, эмзэг бүлгийнхний талаас үнэлэн дүгнэдэг “**deprivational**” буюу “**доройтлын**” хандлага юм.

Ядуурал гэдэг ойлголт өөрөө олон талт үзэгдэл учраас ядууралд өртсөн хүмүүсийг тогтоох, ядуурлыг хэмжих, үнэлэх зэрэг асуудал нэн төвөгтэй юм. Ядуурлын хоёр үндсэн түвшин буюу хэлбэрийг туйлын ядуурал, харьцангуй ядуурал хэмээн тодорхойлдог байна. Гэхдээ ядуурал нь өөртөө орлогын ядуурал, хүртээмжийн ядуурал, эрх мэдлийн ядуурал гэсэн ойлголтыг бас багтаадаг ажээ.

Хүний хөгжил хэмээх ойлголтын хүрээнд хүний чадвартай уялдуулан ядуурлыг тодорхойлох аргыг хамгийн тохиromжтой гэж үздэг байна. Хүний чадварын арга бол тухайн хувь хүнд аливаа нөхцөл бололцоо байгаа тохиолдолд өөрийн зохих үүрэг, тухайлбал, эрүүл энх байх, урт удаан наслах, сайн хооллох, нийгмийн амьдралд идэвхтэй оролзох зэрэг үүргийг гүйцэтгэх чадамж байгаа эсэхэд голлон анхаардаг байна. Түүнчлэн энэ арга нь хүнд өөрт нь байгаа боловч түүнийг ашиглахгүй байгаа сонголтуудыг нээн илрүүлэх, хэрэглэхэд түлхүү чармайдаг байна.

Хүний хөгжил ямар түвшинд хүрснийг хүний хөгжлийн индексээр тодорхойлдог бол хүний амьдралын доройтлыг **ядуурлын индексээр** харуулдаг байна. **Үнд:** наслалт, мэдлэг боловсрол, амьдралын түвшин гэсэн гурван үзүүлэлт хамрагдана. Наслалтын хувьд 40 наснаас өмнө нас барсан хүмүүсийн хувь, мэдлэг боловсролын хувьд бичиг үсэг үл мэдэх насанда хүрсэн хүмүүсийн хувийн жин, амьдралын түвшингийн хувьд эрүүл мэндийн ба цэвэр усны үйлчилгээнд хамрагдалтын хувь, тэжээлийн доройтолтой 5 хүртэл насны хүүхдийн хувь гэсэн 3 хэмжүүрийн нийлбэрийг тус тус ашигладаг байна. Хүний амьдралын түвшингийн доройтлыг хэмжлэг ядуурлын индексийг тооцож, хэрэглэх нь ядуурлын цар хүрээг нэмэгдүүлэхгүй байх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 1990 оноос хойш жил тутам “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийг тодорхой сэдвийн хүрээнд эрхлэн гаргаж байгаа бөгөөд жил бүрийн хүний хөгжлийн илтгэлийн сэдэв, гол агуулга, дэвшүүлсэн зорилт, санал, илтгэлийн онцлог зэргээр танилцаж болох юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 1990 оны анхны Дэлхийн хүний хөгжлийн илтгэлийг “Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр” хэмээх сэдвээр гаргасан юм. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс энэхүү илтгэлд хүний хөгжлийг тодорхойлох, хүний хөгжлийг хэмжих, хүний нөөцийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг ашиглах, эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил, хүний тогтвортой хөгжил, хүний хөгжлийн улс орны хэмжээний төлөвлөлт, хүний хөгжлийг санхүүжүүлэх, хүний

хөгжлийн гадаад орчин, хүний хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх зэрэг асуудлыг судалж, дүгнэлт хийж, зөвлөмж гаргасан байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хүний хөгжлийн индексээр дэлхийн улс орнуудыг 3 бүлэгт ангилдаг байна. Хүний хөгжлийн индекс 0.800 ба түүнээс дээш бол “хүний хөгжил өндөр”; 0.500-0.799-ийн хооронд байвал “хүний хөгжил дунд зэрэг”; 0.500-гаас доош байвал “хүний хөгжил доогуур” гэж үздэг байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс эрхлэн жил бүр нийтэлдэг “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-д тухайн жилийн хүний хөгжлийн индексийг хэрхэн тооцсоныг дэлгэрэнгүй тайлбарласан байдаг.(Үүнийг хавсралтаас үзнэ үү)

Монголын хүний хөгжлийн илтгэл. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэлхийн улс орнуудыг хамруулсан “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийг эрхлэн гаргахын зэрэгцээ тус байгууллагын тусlamж дэмжлэгтэйгээр улс орон бүрийн үндэсний илтгэлийг бэлтгэн гаргадаг байна. Дэлхийн хэмжээнд үндэсний илтгэлээ хэвлэн гаргасан 100 гаруй орон байдал тухай “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-д дурдсан байна. Монгол Улс хүний хөгжлийн үндэсний илтгэлийг 1997 онд анх удаа хэвлэн гаргасан бөгөөд энэ нь хүний хөгжлийн асуудалд дүн шинжилгээ хийсэн анхны баримт бичиг юм. Монгол улс хүний хөгжлийн үндэсний илтгэлээ 1997 онд “Монголын хүний хөгжил”, 2000 онд “Төрийг шинээр зүглүүлэхүй”, 2003 онд “Хүний хөгжлийн хот, хөдөөгийн ялгаа” гэсэн сэдвээр боловсруулан гаргажээ. Монгол Улс хүний хөгжлийн үндэсний илтгэлийг тодорхой сэдвээр, жил бүр тогтмол хэвлэн гаргадаг болох талаар хүчин чармайлт тавьж ажиллах хэрэгтэй байгаа юм.

Нийгмийн хөгжил дэвшил. Хүний хөгжлийн индекс нь олон улсын хэмжээний энгийн харьцуулалт гаргах буюу ерөнхий чиг хандлагыг тодорхойлоход хэрэгтэй боловч өөрийн гэсэн учир дутагдалтай юм. Дэлхий нийтэд улс үндэстний нийгмийн хөгжил дэвшлийн индексийг тооцох судалгаануудыг хийж эхэлсэн байна. Хүний хөгжлийн үзэл баримтлал нь улс төрийн эрх чөлөө зэрэг хүний амьдралын олон талыг хамардаг бөгөөд эдгээр нь чухамхүү хүний хөгжлийн индексэд тусгагддаггүй ажээ. Хүний хөгжил нь улс орны доторх ялгавартай, тэгш бус байдлыг авч үздэг бол индекс нь ердийн дундажийг л харуулдаг байна. Жишээлбэл, Монгол Улс дахь хүний хөгжлийн индексийг тооцоход хүний дундаж наслалтын түвшингийн дээшлэлт нь 1990 оны түвшингээс ихээхэн дошилчихсон орлогын унаалтыг нөхөж байгаа юм.

Үүний нэг тодорхой жишээ бол АНУ-ын Пенсильванийн их сургуулийн профессор Ричард Эстэсийн “Дэлхийн нийгмийн байдал: Шинэ зууны хамлаг” (1998) илтгэлд нийгмийн хөгжил дэвшлийн индексийг нийтдээ **45** үзүүлэлтээр тооцож гаргасан байна. Тухайлбал, боловсрол (4), эрүүл мэнд (8), эмэгтэйчүүдийн нийгмийн байдал (6), эдийн засгийн хөгжил (5), газарзүйн байдал (3), үндэстэн угсаатны ялгаа (3), хүн ам зүй (6), батлан хамгаалах үйл ажиллагаа (1), нийгмийн эмх замbaraагүй байдал (4), нийгмийн халамж (5) гэсэн 10 бүлэг индексийг санал болгосон байна. Энэ эрдэмтний судалгаагаар дэлхий дахинд хүн амын хэт өсөлт, зэр зэвсгийн аюул, эдийн засгийн аюул, нийгмийн гинжин урвалт аюул, байгаль орчны бохирдол (**5**) заналхийлж байна. Эдгээр аюул заналыг тус бүрд нь задлан үзэж болно.

Монгол Улсын хувьд эдийн засгийн ба нийгмийн гинжин урвалт аюул, байгаль орчны бохирдол анхаарал татаж болохоор байна. Эдийн засгийн аюулд ажлын байрны хомсдол, ядуурал, гадаад өр зээл, зээл тусlamжаас хараат байдал ордог байна. Мөн нийгмийн гинжин урвалт аюулд хөдөөгийн хүн ам хотод шилжин суурьших, өрх бүл, ураг төрлийн холбоо сулрах, нийгмийн ялгаанаас үүдэн гарсан зөрчлүүд, албадан шилжин суурьшигчид, дүрвэгчид, үндсэрхэг үзэл, олон улсын байгууллагад үл итгэх байдал зэргийг хамруулан үздэг байна. Манай орны байгаль орчны доройтол, түүний бохирдол

жилээс жилд нэмэгдэж байгаа нь билдний зүрх сэтгэлийг зовоож байна. Энэ бүхнээс үүдэн дэлхий нийтийн болон улс үндэстний нийгмийн хөгжлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан гаргах цаг үе ирсэн гэж үзэж байна. Нийгмийн хөгжлийн эрхэм гурван зорилт бол дайн дажингүй байх, эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн шударга ёс журмыг сахиулах явдал юм. Үүний тулд ядуурлыг бууруулах, хүний хүчин зүйлийг дэмжих (боловсрол, эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн нийгэмдээ эзлэх байр суурийг дээшлүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн эмзэг хэсэгт халамж дэмжлэг үзүүлэхэд нэмэлт хөрөнгө оруулах), нийгмийн тустай хөдөлмөр эрхлэх бололцоо олгох явдлыг илүүтэй анхаарах ёстой байна.

2. Хөгжлийн үзэл баримтлалын ойлголт

Хөгжил гэж үү вэ? Хүмүүсийн амьдралын түвшин дээшилж байгааг ерөнхийд нь хөгжил хэмээн ойлгож болно. Гэхдээ хөгжлийн түвшинг зөвхөн хүн амын материаллаг аж байдал, мөнгөн орлогын түвшингээр хэмждэггүй. Хөгжил нь аливаа өөрчлөлтийн чанарын талыг харуулдаг байна. **Хөгжлийн гол зорилго** бол улс төр, эдийн засаг, нийгмийн бүхэл тогтолцооны чиг хандлага, зохион байгуулалтыг өөрчлөх олон талт үйл ажиллагаа төдийгүй хүмүүсийн аливаа зүйлийг сонгох, сонголт хийх боломжийг өргөжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, хөгжил нь бүтээгдэхүүний үйлдвэрлэл ба аливаа орлогын өсөлтөөс гадна хүн амын хүнсний хэрэглээ, эрүүл мэнд, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэх, хүмүүсийн өөрийгөө үнэлэх үнэлгээ, амьдралын итгэл үнэмшлийг хангаж чадах тийм нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтолцоог бүрдүүлэх, хүмүүсийн сонгох эрх чөлөөг нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хамаардаг байна.

Хөгжлийн талаар орчин үеийн олон янзын үзэл баримтлал байдаг ажээ. Үүний нэг нь АНУ-ын Колумбын Их сургуулийн профессор Жозеф Стиглицийн **Олон талт хөгжлийн загвар** (comprehensive development paradigm) юм. Энэ загварт хөгжил гэдгийг:

- Хөгжил бол бүх нийтийн оролцооны үйл явц;
- Хөгжил бол улс төрийн тогтвортойлжилт;
- Хөгжил бол нийгмийн өөрчлөлтийн илэрхийлэл;
- Хөгжил бол эдийн засгийн үр ашиг гэж тодорхойлжээ.

Түүнчлэн, Азийн хөгжилтэй орнуудын эдийн засагчид, судлаачид **хөгжил** гэдэг ойлголтыг:

- Хөгжил бол технологийн дэвшил;
- Хөгжил бол чадавхийн өсөлт;
- Хөгжил бол ардчиллын ололт, хүний эрх, эрх чөлөөний илэрхийлэл гэж тодорхойлсон байна.

Хөгжил гэсэн ухагдахуунд чадавхийг бүрдүүлэх (capacity development) тухай ойлголтыг зайлшгүй хамааруулан үздэг байна. Чадавхи бүрдүүлэлт нь өөртөө зохион байгуулалтын ба хүний нөөцийн хөгжлийн талыг багтаадаг. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн гаргасан тодорхойлолтоор чадавхийн хэмжигдэхүүнийг тогтолцооны; байгууллагын; хувь хүний гэсэн гурван түвшинд судлан тогтоосон байна. Тухайлбал, байгууллагын түвшинд зорилго ба стратеги; бүтэц ба загвар; үйл ажиллагаа; хүний нөөц; санхүүгийн нөөц; мэдээллийн нөөц; дэд бүтэц зэргийг чадавхийн хэмжигдэхүүнд багтаадаг байна.

Хөгжлийн үзэл баримтлалын чиг хандлага. Хүний хөгжил өөрөө хөгжлийн үйл явцын тогтвортой байдлыг чухалчилдаг байна. Дэлхий нийтээр улс орны хөгжлийн төвл хүн байх төдийгүй эдийн засгийн хөгжлийн үйл явц нь хүмүүсийн чадавхийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой гэсэн чиг хандлагыг 1990-ээд оноос тууштай

баримталж байна. Хүний хөгжил нь өргөн утгаараа өсөлт төдийгүй хүний хэрэгцээг аль болох бүрэн хангахад чиглэгдэж байж сая жинхэнэ “**хөгжил**” хэмээн ойлгогдоно гэж үздэг үзэл баримтлал юм.

Өсөлт гэж юу вэ? Хөгжлийн үзэл баримтлал эдийн засгийн өсөлтөөс өргөн цар хүрээтэй ойлголт юм. Өсөлт нь аливаа нэг өөрчлөлтийн тооны талыг харуулдаг байна. Тухайлбал, хүн амын тооны өөрчлөлтийг хүн амын өсөлт, ДНБ-ний тоо хэмжээний өөрчлөлтийг эдийн засгийн өсөлт үзүүлдэг зэргийг нэрлэж болох юм. Хүний хөгжлийн үйл явцыг түргэтгэх хамгийн гол хүчин зүйл нь эдийн засгийн өсөлтийг хангах явдал юм. Эдийн засгийн өсөлт, хүний хөгжлийн хооронд шууд уялдаа холбоо байхгүй учраас эдийн засгийн өсөлтийн хүний хөгжилд нөлөөлөх нөлөөллийг яаж илэрхийлэх вэ? гэдэг асуудалд тохирсон хариу эрж олох нь нэн чухал байна. Хөгжлийн үйл явц нь хувь хүний авьяас чадварыг хөгжүүлэх, тэдний авьяас чадварыг үр ашигтайгаар, бүтээлчээр ашиглах таатай орчин, боломжтой нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Хөгжлийн үзэл баримтлал нь нэг хүнд ногдох орлогыг нэмэгдүүлэхээс гадна нийгмийн шударга ёс, орлогын хуваарилалтын тэгш байдлыг эрхэмлэх, хүн амын наад захын хэрэглээг хангах, ядуурлыг бууруулах зэрэг нийгмийн зорилтуудыг багтаадаг. Ер нь хөгжлийн үзэл баримтлал нь өөртөө **хүний хөгжил, нийгмийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй хөгжлийг** шингээсэн бүхэл бүтэн тогтвортой хөгжлийн цогц ойлголт юм.

Тогтвортой хөгжил. Хөгжил бол олон хүчин зүйлээс хамаардаг. Өнөөдөр байгаль орчны доройтол, бохирдол дэлхий дахины анхаарал татсан асуудал болжээ. Тогтвортой хөгжил гэсэн нэр томьёо 1970 онд Кокоуосын тунхаглалд анх сонсогдож, улмаар 1992 оны Рено де Жанерогийн дэлхийн дээд хэмжээний уулзалтаас хойш шинэ агуулгаар баяжсан байна. Тогтвортой хөгжил гэдгийг хамгийн энгийн байдлаар томьёолбол ирээдүй үеийнхний хэрэгцээг золиослохгүйгээр өнөө үеийнхэн өөрсдийнхөө хэрэгцээг хангах явдал гэж үзэж болох юм. Тогтвортой хөгжлийн зорилтууд өргөн хүрээтэй боловч тогтвортой хөгжлийн үзэл баримтлал давуу ба сүл талтай юм. Үүнийг улс орон бүр өөр өөр талаас нь тайлбарлах, ашиг сонирхол нь зөрчилдөх явдал гардаг байна. Мөн “**тогтвортой хөгжил**” гэдэг нэр томьёог монгол хэлний утга, агуулгад нийцүүлэн “тэнцвэртэй хөгжил”, “зохистой хөгжил”, “тулхтай хөгжил” гэж нэрлэх саналууд дэвшигдэж байгааг судлан үзэж, бүх нийтээр зөвшшилцөх нь зүйтэй байна.

Хөгжлийн хэмжүүр. Улс орон хэр зэрэг хөгжиж байгааг **нэгдүгээрт**, хүний хөгжил, **хоёрдугаарт**, эдийн засгийн өсөлт зэрэг үзүүлэлтүүдээр хэмжиж байна. Тухайлбал, дундаж наслалт, нялхсын ба хүүхдийн нас баралт, хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин зэрэг үзүүлэлтээр амьдралын чанар, хүний хөгжлийг; нэг хүнд ногдох орлого, ажилгүйдлийн түвшин зэрэг үзүүлэлтээр эдийн засгийн өсөлтийг харуулдаг байна. Нийгмийн хөгжлийг урагшуулахад төрийн чиг үүргийг өндөржүүлэх (үндэсний аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг хамгаалах, хүний эрхийг хангах, хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг удирдан зохицуулах, тогтвортой хөгжлийг хангах, нийгмийн хамгаалалд хамааруулах, ардчилсан ёс, хамтын ажиллагааг хөхиүүлэн дэмжих), төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах, үндэсний хөгжлийн зөвлөх ажиллуулах, хөгжиж буй орнуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд бодит алхам хийх хэрэгтэй болжээ.

Нийгмийн бодлогын асуудал. Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын дундах баян, ядуугийн ялгаа ихэсч, хүн амын эмзэг хэсгийн нийгмийн баталгааг хангах асуудал төр, засгийн анхаарлын төвд байхын зэрэгцээ төрийн бодлогын хүрээнд нийгмийн бодлого гол байр суурийг эзэлж байна. Нийгмийн бодлого нь өргөн хүрээтэй, олон талын асуудлыг өөртөө хамруулдаг нэлээд төвөгтэй ойлголт юм. Монгол Улсын

хувьд нийгмийн бодлогын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээг хамруулан авч үзэх нь нэлээд түгээмэл, нийтлэг хандлага болоод байна.

Нийгмийн бодлогын асуудлыг өргөн хүрээнд судлан үзвэл нийгмийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг бүхий л байгууллага, үйлчилгээ, үйл ажиллагаа, тухайлбал, түүх, соёлын дурсгалын газар, тэдгээрийг хамгаалах ажил, музей, номын сан, биеийн тамир, соёл урлаг, шинжлэх ухаан, хэвлэл мэдээлэл зэрэг салбарын асуудал бүгд хамрагдах хэрэгтэй болно. Түүнчлэн, хүн амын орлого, цалин хөлсний хэмжээ ч төр, засгийн байнгын анхаарлын төвд байх ёстой чухал асуудлын нэг юм. Тэгэхлээр нийгмийн бодлого гэж хөгжлийн тухай үндэсний хэмжээний зорилтыг ханган биелүүлэхийн төлөө хувь хүн, өрх гэр, олон нийтийн байгууллага зэрэг нийгмийн үндсэн нэгжүүдийг дайчлахад чиглэгдсэн хөгжлийн бодлогын бүрэлдэхүүн хэсгийг хэлнэ.

Нийгмийн бодлогын хамрах хүрээ: Нийгмийн хөгжлийн гол бүрэлдэхүүн хэсэг болсон нийгмийн бодлого нь: (1) Хүн амын бодлого, хүн ам зүйн асуудал; (2) Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн асуудал; (3) Орлого, цалин хөлс, тэдгээрийн инфляци хоорондын хамаарал; (4) Нийгмийн хамгааллын сүлжээ; (5) Боловсрол; (6) Эрүүл мэнд; (7) Орон сууц; (8) Хүнсний аюулгүй байдал; (9) Усны асуудал зэргийг өөртөө багтаана. Мөн сүүлийн үед нийгэм, хамт олныг дайчлах асуудал (**social mobilization**) нийгмийн бодлогын гол бүрэлдэхүүн хэсэг гэдгийг судлаачид хүлээн зөвшөөрч байна. Учир юу вэ? гэвэл хэчинээн сайн (нийгмийн) бодлого боловсруулсан хэдий ч түүнийг хэрэгжүүлэхэд алдаа гарах явдал нийтлэг байдаг. Үүнээс урьдчилан сэргийлэхийн төлөө бүх түвшин дэх байгууллага, хамт олны гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг нарийн тодорхойлох явдал бодлогыг чанартай хэрэгжүүлэхийн гол гогцоо асуудал болно. Ялангуяа нийгмийн бодлогын хэрэгжилтэд хамт олны үүрэг роль асар их байх нь хэн бүхэнд ойлгомжтой юм. Энэ утгаар нь хамт олны идэвхийг өрнүүлэх, тэдний нийгэмд гүйцэтгэх үүрэг, ролийг өндөржүүлэх явдал өнөөдөр юу юунаас чухал болоод байна.

Нийгмийн бодлогын нөгөө нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь нийгмийн ажлын хөгжил байх тухай сүүлийн жилүүдэд нэлээд өргөн хүрээтэй яригдах болоод байна. Нийгмийн бодлогын хэрэгжилтийг хамт олны дунд гардан зохион байгуулагч нь нийгмийн ажилтан юм. Нийгмийн бодлогын хүрээнд гол байр суурийг эзлэх хүн амын эмзэг хэсгийн талаар баримтлах бодлогын асуудал, түүний хэрэгжилттэй нийгмийн ажлыг гардан зохион байгуулагч нийгмийн ажилтан шууд тулж ажиллах ёстой билээ. Манай орны нөхцөлд хөгжилд чиглэсэн нийгмийн ажлыг хөгжүүлэхэд төр, засаг анхаарлаа түлхүү хандуулахын зэрэгшээ нийгмийн ажлын онол, аргазүйг жендэр ба хөгжил хандлагатай уялдуулах хэрэгтэй болсон байна.

Хүн ам ба хөгжлийн уялдаа холбоо. Хүний (цаашид хүн ам гэх) хүчин зүйл хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөгжлийн үр дүнтэй хэрхэн уялдаатай болохыг болит амьдралд нийцүүлэн томьёолох талаар дэлхийн олон орны эрдэмтэд, судлаачид багагүй эрэл хайгуул хийж тодорхой амжилтад хүрч байна. Эрдэмтэд, судлаачдын явуулсан судалгаа шинжилгээний ажил, түүний үрдүн нь юуны өмнө хүн ам ба хөгжлийн хоорондын харилцан үйлчлэл, уялдаа холбооны зүй тогтолцыг илрүүлэхэд голлон чиглэж ирсэн байна.

Олонхи эрдэмтэд хүн амзүйн тогтолцоо **хүн амын үйл явц** (хүн амын төрөлт, хүн амын нас баралт, хүн амын шилжих хөдөлгөөн), **хүн амын үр дүн** (хүн амын тоо хэмжээ, хүн амын нас, хүйсийн бүтэц, хүн амын байршилт, нутаг дэвсгэрийн хуваарилалт) гэсэн 2 үндсэн хэсгээс бүрддэг гэж үзэж байна. Мөн хүн амын үйл явц, хүн амын үр дүн хэмээх багц ойлголтын хүрээнд хамаарах үзүүлэлтийг тодорхойлон практикт хэрэглэх чиглэлээр багагүй амжилт олжээ.

Эдүгээ **хөгжил** гэж юу болох талаар эрдэмтэд, судлаачид өөр өөрийн санал бодлыг

бас илэрхийлсээр ирснийг өмнө дурдсан билээ. Тэгэхлээр ирээдүй хойч үеийнхээ хэрэглээ, сонголт хийх боломжийг багасгахгүйгээр өнөө үеийнхний амьдралын бодит түвшин өргөн хүрээнд дээшилж байгааг хөгжил гэж ерөнхийд нь ойлгож болох юм. Мөн хөгжил нь **хөгжлийн үйл явц** [бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ (хоол хүнс, хувцас хунаар, орон сууц, эрүүл мэнд, боловсрол, соёлын зэрэг), хөрөнгө оруулалт, хадгаламж, биет нөөц (газар, хөрөнгө, технологи) байгалийн нөөц, улсын зарлага], **хөгжлийн үр дүн** [орлого, орлогын хуваарилалтын байдал, хөдөлмөр эрхлэлтийн байдал, боловсролын байдал, эрүүл мэнд, хүнсний хангамжийн байдал, хүрээлэн буй орчны төлөв байдал, эрх мэдлийн хуваарилалтын байдал] гэсэн үндсэн багц агуулгад багтдаг байна. Түүнчлэн хөгжлийн үйл явц, хөгжлийн үр дүн гэсэн багц ойлголтын хүрээнд хамрагдаж байгаа тодорхой үзүүлэлтийг томьёолон практикт хэрэглэх чиглэлээр улс орнуудад бас баагүй дэвшил гарсан байна.

Ийнхүү хүн амын үйл явц, хүн амын үр дүн болон хөгжлийн үйл явц, хөгжлийн үр дүн, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилсан үйлчлэлийг сайтар ухаарсан байх нь хүн амын хүчин зүйлийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оновчтой тусган хэрэгжүүлэх чухал урьдчилсан нөхцөл болно. Ялангуяа хүн амын үйл явц, хүн амын үр дүн болон хөгжлийн үйл явц, хөгжлийн үр дүн гэсэн 2 томоохон багц үйл явдлын хоорондын уялдаа холбоо, харилсан үйлчлэлийн зүй тогтлыг бүрэн танин мэдэж, сайтар ойлгож байх нь оншгий ач холбогдолтой юм. Ингэж бүтээлчээр хандах явдал хүн амзүйн тогтолцоонд гарч буй өөрчлөлт нь нийгэм, эдийн засгийн тогтолцоонд нөлөөлж байдаг бөгөөд нийгэм, эдийн засгийн тогтолцоонд гарч буй өөрчлөлт нь эргээд хүн амзүйн тогтолцоонд бас нөлөөлж байдаг бодит хандлагыг тогтоосонтой холбоотой ажээ.

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд эл асуудал бүр ч их анхаарал хандуулах болжээ. Зах зээлийн шинэ тогтолцоонд шилжиж буй манай улсын хувьд бүр ч их анхаарах учиртай асуудал юм. Энэ талаар олон түмэнд цэгтэй ойлголт өгсөн бүтээл туурвил манай оронд бараг байхгүй байна. Өнөөгийн байдлаар олон улсын түвшинд хүн ам ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан үйлчлэлийг судлан томьёолох болжээ. [Training Module on Integrated Population and Development Planning. Manila, Asian Development Bank. 1993, (5-36 pages)] (Зураг1.)

Хүн амын болон хөгжлийн үйл явц нь харьшангуй бие даасан үйл явдал боловч аль нэг нь дангаараа оршин тогтнох боломж багатай нь хэн бүхэнд ойлгомжтой юм. **Өөрөөр хэлбэл**, эдгээр үйл явц нь зөвхөн тэдгээрийн хоорондын харилсан үйлчлэлийн нөлөөн дор тасралтгүй үргэлжлэх шинж чанарыг олж авдаг байна. Үүнийг хүн амын үйл явц өөрөө хүн амын үр дүнг үүсгэж, улмаар хөгжлийн үйл явцыг өдөөж хөгжлийн үр дүнэд хүргэдэг төдийгүй хөгжлийн үр дүн нь эргээд хүн амын үйл явцад нөлөөлөх замаар тасралтгүй үргэлжлэх эргэлтийг нөхцөлүүлдэг бодит байдлын тусгал хэмээн тайлбарлаж болох юм (Зураг 1).

Гэхдэээнэхүү тойрог маягийн үйлявцыг хурдасгах, эсвэл удаашруулах зэргээр өдөөж байдаг нэг гол хүчин зүйл бол хүний хөгжлийн тодорхой зорилго бүхий ухамсартай үйл ажиллагааны нэг ирэл болох хөгжлийн болон хүн амын холбогдолтой бодлогыг аливаа улс оронд боловсруулан хэрэгжүүлж байдагт оршино. **Өөрөөр хэлбэл**, уул үйл явцыг төлөвлөн удирдаж байдаг явдал юм. Иймд төлөвлөлтийг ямагт боловсронгуй болгож байх нь ач холбогдолтой байдаг ажээ.

Хүн ам ба хөгжлийн уялдаа холбооны бүдүүвчийг хавсралтын дагуу хураангуйлан үзүүлж болох байна (Зураг 2). Хүн ам ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан үйлчлэл, хамаарлын энэхүү бодит байдлын илэрхийлэл (бүдүүвч Зураг 1, Зураг 2)-ийн агуулгад задлан шинжилгээ хийж үзэхэд хүн амын бодлогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх

чиглэлээр хүн амын үйл явцыг зөв залж хүн амын зохистой үр дүнг бий болгож, улмаар хүн амын үр дүнг хөгжлийн болдого, төлөвлөлтөд оновчтой тусгах замаар хөгжлийн үйл явцыг зөв чиглүүлэн хөгжлийн хүсэн хүлээсэн үр дүнд хүрч болох юм гэсэн дүгнэлт гарч байна.

3. Хүний эрхэд сууринсан жендерийн тэгш байдлыг хангах үзэл баримтлал

Хөгжих эрх бол хүний үндсэн ба салшгүй эрх төдийгүй Хүний эрхийн түгээмэл тунхаглалын нэг бүрэлдэхүүн хэсэг мөн билээ. Хөгжил нь хүний бүх эрхийг хангахад таатай нөлөө үзүүлдэг хэдий ч улс орны хөгжил буурай байх явдал олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн хүний эрхээ эдэлж чадахгүй байх шалтгаан болох ёсгүй билээ. Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгэмд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг жинхэнэ утгаар нь эдлүүлэх, бодитойгоор хангах явдал эдүгээ хүн төрөлхтний өмнөх хуримтлагдсан олон асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн түлхэц өгнө гэж үздэг болжээ.

Жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн эрхэд сууринсан болдого, хууль тогтоомж, хөтөлбөрийг хүний эрхийн үндсэн асуудал болгон баталгаажуулахын төлөө улс орнууд чармайн ажиллаж байна. Хүний эрх нь нас, хүйс, арьсны өнгө, хэл, үндэс угсаа, язгуур, шашин шүтлэг, улс төрийн үзэл болдлыг үл харгалzan эрхээ бүгд тэгш эдэлнэ гэсэн үндсэн зарчимд тулгуурладаг билээ. Хүний эрх гэдэг бол бүх хүнд заяасан төрөлх эрх бөгөөд хүний эрхийг хамгаалах явдал нь төр, засгийн байгууллагуудын анхдагч үүрэг юм гэсэн Венийн тунхаглалыг 1993 онд Дэлхийн хүний эрхийн бага хурлаар Засгийн газрууд хүлээн зөвшөөрчээ. Мөн бага хурлаар эмэгтэйчүүдийн эрх, хүчирхийлэлд үл өртөх эрх гэх мэт эмэгтэйчүүдийн эрхийн онцлог байдал, нөхцлийг хамгаалах, дэмжихэд чиглэсэн Засгийн газрын чиг үүргийг тусгайлан хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна.

Манай Улсын өмнөх Үндсэн хуулиудад “эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн адил эрх эдэлнэ” гэж зааж ирсэн бол Монгол Улсын 1992 оны Үндсэн хуульд “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” хэмээн цоо шинэ утга агуулгаар баяжуулан баталгаажуулсан. Монгол Улс хүний эрхийн чиглэлээр олон улсын 40 шахам гэрээнд нэгдэн орсон бөгөөд гэрээнд нэгдэн орсон улс бүр гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх хариуцлага хүлээдэг.

Жендерийн тэгш байдлыг нийгэм, эдийн засгийн хүрээнд хангахад Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Нийгмийн дэвшил, хөгжлийн тухай тунхаглал (1969), Хөгжих эрхийн тухай тунхаглал (1986), Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах тухай тунхаглал (1992), Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал (1993), Мянганы хөгжлийн тунхаглал (2000), Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш шан харамж олгох тухай (1951), Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай (1952), Эхчүүдийн эрхийг хамгаалах тухай (1952), Сайн дурын үндсэн дээр гэрлэх тухай болон гэрлэх нас, гэрлэлтийг бүртгэх тухай (1961), Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай (1979) зэрэг конвенцийн үзэл санааг амьдралд хэрэгжүүлэх явдал улс орон бүрийн гол зорилт болж байна.

Жендерийн тэгш байдлыг хангахад Эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, хөгжил, энх тайвны асуудлаарх 1985 оны Найробны, Хүний эрхийн талаархи 1993 оны Венийн, Хүн ам ба хөгжлийн асуудлаарх 1994 оны Каирын, Нийгмийн хөгжлийн асуудлаарх 1995 оны Копенгагены, Эмэгтэйчүүдийн байдлын тухай 1995 оны Бээжингийн бага хурлуудын шийдвэр, үйл ажиллагааны хөтөлбөр ихээхэн ач холбогдолтой юм.

Жендерийн тэгш байдлыг нийгэм, эдийн засгийн харилцаанд хангахтай холбоотой онол, практикийн зарим асуудлыг цухас хөндөн ярихыг хүсэж байна.

Жендерийн ойлголт. Хүний нийгмийн оршин тогтносон бүхий л үеийн туршид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын харилцаа, тэдэнд хүлээлгэсэн үүрэг, хариушлага, үнэлэмжийн байдал хөгжин өөрчлөгдөж ирсэн бөгөөд энэ нь шашин, соёл, уламжлалын хэм хэмжээ болтлоо хэвшсэн явдал юм.

Жендерийн ойлголт нь өөрөө арга, билгийн ёсны зүй тогтоор амьдралд хэрэгждэг. *Өөрөөр хэлбэл, эр талыг арга; эм талыг билиг* гэж үзнэ. Энэхүү ухагдахууны талаар дорнын гүн ухаантан Ч.Дэмчигдорж (Дандаа)-ийн Эрдэнэт толь хэмээх шастар оршивой (1995) номын “Эр, эмийн сацуу ёсыг илтгэсэн арван хоёрдугаар бөлөг”-т “... Арга билгийн ёсон, түүний үндэс нэгэн бөгөөд аргын ёсон хөдлөн, билгийн ёсон нам буюу. Нэгэнт хөдлөх, нэгэнт нам болох нь арга билгийг түшиж нам болой. Билэг аргыг дагаж хөдлөнө. Эр нь эмийг гэр болгоно. Эм нь эрийг дагаж тогтоно. Няглан шинжилбээс, эр нь эмээс илүү болсон ёсонгүй бөгөөд эм нь эрээс дутуу болсон учиргүй сацуу буюу” хэмээн тэмдэглэжээ.

Мөн зохиолын энэхүү бүлэгт “... нэгэн шөнийн зүүдэнд огторгуй дүүрэн саран мандсаныг нүүх үүл хэлхэснийг салхиар хийсгэхийг зүүдлэв. Энэ нь гэгээн саран үүлнээс гараад тунгалаг болохын билиг буюу. Олон сар хэмээгч даруй хамаг эхнэр төрөлхтний бэлэг мөн буюу. Нүүх үүл хэмээгч даруй доромжлох муу ан зан мөн буюу. Их салхи хэмээгч даруй өтгөс миний зохиол мөн буюу. Тиймийн тул хойч сурх ард намайг язгуур болгон миний ёсыг эрхлэх болбоос эхнэр төрөлхтнийг доромжлох энэхүү муу сурагтайг халж залруулбаас зохино” гэж жендерийн харилцааны тэгш ёсыг сургамжлан захисан байх юм.

Жендер буюу нийгмийн хүйс бол нийгмийн практикаар бүрэлдэж тогтсон ойлголт юм. Эрэгтэй, эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн засгийн харилцаанд гүйцэтгэх үүрэг, хариушлага, нийгэмд эзлэх байр суурийн тухай бүрэлдэн тогтсон үзэл бодол, ойлголтыг жендер гэнэ. Өөрөөр хэлбэл, жендер гэдэг нь нийгмийн харилцааны ухагдахуун төдийгүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг дахь зохион байгуулалтын шинж байдлыг тодорхойлох арга хэрэгсэл болдог.

Жендерийн сургаал (Gender ideology). Жендерийн сургаалын үүсэл анх эмэгтэйчүүдийн эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой гарч иржээ. Гэвч хөгжлийн явцад нийгмийн ухамсар, мэдлэгт жендерийн үзэл санаа үүсэн бүрэлдсэн нь үнэндээ шинэ онол үүссэнээс ч илүү үйл хэрэг болсон байна. *Өөрөөр хэлбэл, “хүйс”* (секс) гэдэг хоёр талт ойлголтоос асар олон талт “**жендер**” хэмээх ухагдахуун үүссэн түүхтэй билээ.

Орчин үед жендер судлал хамарагдах бүхэл бүтэн шинжлэх ухааны хүрээлэл үүссэн байна. Тухайлбал, гүн ухаан, нийгэм судлал, эдийн засаг, түүх, улстөр судлал, сэтгэл судлал, хүн судлал, хүн ам зүй, хэл зүй ба нийгмийн хэл зүй, соёл судлал, нийгмийн ажлын ухаан зэргийг нэрлэж болох байна. Жендерийн үзэл сургаал гэдэг бол “байгалийн жам ёсны” ялгаа, эсвэл байгалийн жам ёсноос ангид тогтсон үзлээс үүдэлтэй жендерийн ялгаа болон жендерийн давхаргын тухай нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн үзэл санааны тогтолцоо юм.

Жендерийн тулгуур ухагдахуун. Жендерийн тулгуур ухагдахуунд жендерийн тэгш эрх, жендерийн тэгш байдал, жендерийн чадамж; жендерийн хэрэгцээ, жендерийн үүрэг, жендерийн харилцаа, жендерийн технологи, жендерийн судалгаа, жендерийн статистик, жендерийн дүн шинжилгээ зэрэг ойлголт хамаарна. Эдгээр ойлголтыг нийтэд нь бас **жендерийн хүчин зүйлс** хэмээн нэрлэж болох талтай юм. Жендерийн хүчин зүйлсийг агуулгаар нь **жендерийн үйл явц** (жендерийн тэгш эрх, жендерийн тэгш байдал, жендерийн чадамж), **жендерийн үр дүн** (жендерийн хэрэгцээ, жендерийн үүрэг, жендерийн харилцаа, жендерийн технологи, жендерийн судалгаа, жендерийн статистик,

жендэрийн дүн шинжилгээ зэрэг) гэж ангилж үзэх саналыг дэвшүүлж байна.

Жендэрийн үйл явши:

Жендэрийн тэгш эрх: Эмэгтэйчүүдэд, эрэгтэйчүүдийн адил тэгш эрхтэй байр суурийг бүрдүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдэд эрэгтэйчүүдийн нэгэн адилаар тэгш боломж олгох, тэднийг нийгмийн бүхий л хүрээнд бүрэн оролцуулах, оролцооныхоо хэрээр тэнцүү ашиг хүртээх ойлголт мөн.

Жендэрийн тэгш байдал: Эрэгтэй, эмэгтэйчүүдэд шударга хандах, нийгмийн зүгээс адил дэмжлэг үзүүлэх явдал мөн. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэйчүүд ижил хөдөлмөрт адил цалин хөлс авах, сурч боловсрох, өмч эзэмших, орон сууц, ажлын байртай болох, эрүүл мэндээ хамгаалах адил нөхцлөөр хангагдах, эрх мэдлийг тэнцвэржүүлэх нийгмийн баталгаа юм. Жендэрийн тэгш байдал нь хөгжлийн гол асуудал төдийгүй хөгжлийн биеэ даасан нэгэн чухал зорилт болсон байна. Иймд жендэрийн тэгш байдлыг хангах явдал нь хөгжлийн чухал стратеги болжээ.

Жендэрийн чадамж: Эмэгтэйчүүд өөрсдийн стратеги сонирхлыг тодорхой ухамсарлах, тэдэнд шинэ үнэлэмж чадварыг төлөвшүүлэх, жендэрийн харилцаан дахь байр сууриа өөрчлөн амьдралдаа эзэн болох ойлголтыг хэлнэ. Эдгээрт шаардагдах нөөц боломжийг дайчлах явдал чухал юм. Өөрсдийгөө чадваржуулснаар бусдад болон эмзэг бүлгийнхэнд эрх тэгш амьдрах нөхцлийг буй болгохын төлөө тэмцэж ажиллана.

Жендэрийн үр дүн:

Жендэрийн хэрэгшээ: Жендэрийн хэрэгцээ нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн бодит байдлаас урган гарсан голхэрэглээнүүдюм. Нөөцбаялагдах хэрэгцээ болон хүртээмжийг сайжруулахад чиглэгдсэн зээл, эмэгтэйчүүдийн ачааллыг хөнгөвчлөх техник хэрэгсэл, эмэгтэйчүүдийн үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх гэх мэт бүхий л үйл ажиллагаа бодит хэрэгшээнд хамаарна. Эмэгтэйчүүдийн бодит хэрэгцээ ба стратегийн сонирхлыг таних нь эрэгтэйчүүдийнхээс өөр учраас оролцооны аргаар тус тусад нь судлах явдал чухал юм.

Жендэрийн үүрэг: Эрэгтэй, эмэгтэйчүүдийн ажлын үүрэг, хариуцлагын тухай ойлголт бөгөөд тэдний хамтран ажиллах, зохицох үйл явцад илрэх харилцааны байдал юм. Энэ нь зөрчил, зохицлыг хамтад нь агуулдаг төдийгүй тэдний үүргийг нийгмийн цогц харилцаанд судалдаг. Жендэрийн үүрэг байнга өөрчлөгдөж байдаг хувирамтгай шинж чанартай бөгөөд нийгмийн анги, давхарга, нас, шашин шүтлэгээс хамааран олон хэлбэр, хувилбартай байдаг.

Жендерийн үүрэг	Эмэгтэй	Эрэгтэй
Нөхөн үржихүйн үүрэг	Хүүхэд төрүүлэх, өсгөх, гэр орны ажлыг зохион байгуулах	Итгэл найдварын баталгаа
Үйлдвэрлэлийн үүрэг	<p>Хөдөөд: Өрхийн аж ахуйн ихэнх ажлыг нугалдаг.</p> <p>Хотод: Жижиг үйлдвэр, албан бус салбарт зонхилено.</p> <p>Орлогын хоёрдагч өх үүсвэрийг бүрдүүлэгч, ядуу өрхүүдийн хувьд гол үүргийг гүйцэтгэх тохиолдол түгээмэл бөгөөд өрх толгойлсон бол цорын ганц амьжиргааг тэтгэгч юм.</p>	Орлогын ихэнхийг бүрдүүлэгч, зохион байгуулагч ийн үүргийг гүйцэтгэнэ
Нийгэм, хамт олон, олон нийтийн түвшинд гүйцэтгэх үүрэг	<p>Олон нийтийн үйлчилгээ, ялангуяа нөхөн үржихүйн чиглэлийн халамж, зөвлөгөөг тэд голлон хийнэ.</p> <p>Удирдахалбантушаалдбайсанчэрэгтэйчүүдийн удирдлагад ажиллана.</p> <p>Сайн дурын албан тушаалын ихэнхийг бүрдүүлнэ.</p>	Албан ёсны нам, улс төрийн үйл ажиллагаанд зонхилогч, цалин өндөртэй удирдагчдын олонх нь эрэгтэйчүүд байдаг

Жендерийн харилцаа: Нийгэм дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын харилцаагаар илэрнэ. Энэ харилцаа жендерийн үүрэг дээр суурилан эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх ялгаатай байр сууриар тодорхойлогоно. Ихэнх тохиолдолд энэ харилцаа нь нийгэмд тэгш бус туйлширсан байдалтайгаар буюу эмэгтэйчүүд нь илүү хараат байдалд байдаг. Нөгөөтэйгүйр жендерийн харилцаа нь нийгмийн орчингоос хамааран ангийн ялгаа мэт нийгмийн өөрчлөлтөд өртөж байдаг.

Жендерийн технологи: Жендерийн орчин үеийн учир зүй (логик) нь “хүйс-хэлэлцүүлэг-эрх мэдэл” гэсэн салшгүй холбоотой ойлголтуудыг илэрхийлдэг. Жендерийн технологи нь хэлэлцүүлгийн шинж бүхий арга хэрэгсэл бөгөөд жендер үүсэн бүрэлдэж, хүйс хэрхэн үзэл суртлын хэрэглэгдэхүүн болсныг харуулдаг. Жендерийн технологийн үндсэн тулгуур илэрхийлэл болох хэл яриа, шашин, уламжлал, боловсрол, хүмүүжил нь орчин үеийн дуу, авиа дүрс бичлэгийн “нийгмийн дизайн” гэдэг нэр томъёогоор баяжиж байна. **Өөрөөр хэлбэл**, дэлгэцийн технологи буюу клипийн урлаг бүхий кино, телевиз, хэв загвар, зар сурталчилгаагаар хүйсийн хэв шинжийг эрчтэй үзүүлэх боллоо. Жендерийн технологи нь орчин үеийн “танилцуулах бодлого”-ыг илэрхийлсэн, жендерийн хөгжлийн чиг хандлагыг агуулсан жендерсудалын судалгааны зүйл болжээ.

Жендерийн судалгаа: Жендер ба хөгжил хандлагын судалгаа нь жендерийн мэдрэмжтэй стратеги бодлогыг тодорхойлоо ос эхэнэ. Тулгуур ойлголтууд нь мэдээлэл цуглуулах болон дүн шинжилгээ хийхэд оршино. Эдгээр нь “Жендерийн үүргийг судлах Харвардын загвар”-т тодорхой тусгагдсан байдаг.

Жендерийн статистик: Жендерийн холбоотой тоо баримт, мэдээллийг төрийн ба төрийн бус байгууллага цуглуулах, шинжлэх, түгээхдээ жендерээр бүрэн ангиж нас, оршин суугаа газар, орлого зэрэг бусад үзүүлэлтүүдээр ялгах үйл ажиллагаа юм. Тэдгээр нь чанар, хамрах хүрээ, найдварыг тэгш хангах, тоо мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгахад чиглэгдэнэ.

Жендерийн дүн шинжилгээ: Жендер ба хөгжлийн хандлага, жендерийн төлөв байдал, түүний хэрэгцээ, үүрэг, оролцоо зэргийг тандсан судалгааны явцад мэдээлэл цуглуулан үнэлэлт, дүгнэлт хийж, нэгдсэн загварт оруулсан байдлыг жендерийн дүн

шинжилгээ гэж хэлнэ. Өөрөөр хэлбэл, жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бодлого, хөтөлбөр боловсруулах үйл явцад харгалзан үзэх зорилго бүхий зохион байгуулалтын аргыг **жендэрийн дүн шинжилгээ** гэнэ. Жендэрийн дүн шинжилгээний гол зорилго нь хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдэд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ашиг сонирхол, болит хэрэгшээ, үүрэг, оролцоог бүрэн тусгуулахад оршино.

Жендэрийн хөгжлийн хэмжүүр. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 1995 оноос эхлэн Хүний хөгжлийн индексийг жендэрийн ололтын судалгаагаар баяжуулан Жендэрийн хөгжлийн индекс (англиар *Gender Development Index-GDI*, оросоор *Индекс развития с учетом гендерного фактора-ИРГФ*), Жендэрийн тэгш боломжийн хэмжүүр (англиар *Gender Empowerment Measurement-GEM*, оросоор *Индекс расширения возможностей женщин-ПРВЖ*)-ийг бас тооцон гаргадаг болжээ.

Жендэрийн хөгжлийн индекс (GDI) нь хүний хөгжлийн индексийг тогтооход хэрэглэдэг үзүүлэлтээр эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хоорондын тэгш бус байдлыг тооцоолж гаргадаг. Жендэрийн хөгжлийн индекс бол жендэрийн тэгш бус байдлыг харьцуулан тооцсон хүний хөгжлийн индекс юм. Жендэрийн хөгжлийн индексийн судалгаанаас гарсан зарим чухал дүгнэлт гэвэл: **Нэгдүгээрт**, дэлхийн бүх улс оронд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс харьцангуй доогуур амьдардаг. **Хоёрдугаарт**, тэгш бус байдлын эрэмбэ орлогын түвшингээс хамаарахгүй байна. Скандинавын орнуудад тэгш байдлын түвшин нэн өндөр байхад Японд энэ түвшин дундаас доогуур байдаг. Харьцангуй ядуу орны дотор жендэрийн тэгш байдлыг урагшуулах талаар Барбадос, Куба, Малайз, Шри Ланк, Ямайка зэрэг орон сайн үр дүнэхүрчээ. **Гуравдугаарт**, хэдийгээр хүний хөгжил дотор жендэрийн ялгаа одоо хэр мэдэгдэхүйц хэвээр байгаа ч жендэрийн хөгжлийн индекс сүүлийн жилүүдэд бараг хaa сайгүй өсчээ.

Жендэрийн тэгш боломжийн хэмжүүр (GEM) нь жендэрийн хөгжлийн индексээс зарчмын ялгаатай юм. Энэ хэмжүүр жендэрийн тэгш бус байдал улс орны нийт хөгжилд хэрхэн нөлөөлөхийг судлан үзэх бус, харин эдийн засгийн ба улс төрийн эрх мэдэлд жендэрийн тэгш байдлын түвшин ямар байгааг голлон анхаарч, чинээлэг байдлын ололтыг бус, үйл ажиллагааны хүрээн дэх тэгш байдлыг хэмжихийг эрмэлздэг байна.

4. Жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах

Өнөөдөр улс орон бүрт эрэгтэй, эмэгтэйчүүдийг хөгжилд жигд оролцуулах явдал тулгамдсан зорилт болж байна. *Нийгмийн хөгжлийн бодлого нь хүний эрхэд сууриссан байхаас гадна жендэрийн чиг хандлагыг зайлшгүй тусгахыг чухалчилдаг болсон* байна. Өөрөөр хэлбэл, хөгжлийг жендэрийн агуулгатай болгохын төлөө чармайх болжээ.

Жендэрийн тэгш байдлыг бодлогоор дэмжих үйл явцыг английар “*Gender mainstreaming*”, оросоор “*Комплексный подход к проблеме гендерного равенства*” хэмээн албан ёсоор нэрлэж байна. Бид үүнийг “*жендэрийн чиг хандлага*” гэсэн утгаар хэрэглэж байна. Энэ нэр томьёогоор жендэрийн тэгш байдлыг амьдралд хэрэгжүүлэх үйл явцыг ерөнхийд нь төлөөлүүлэн ойлгож байна.

Жендэрийн чиг хандлага: Жендэрийн чиг хандлага хэмээх ойлголт нь эмэгтэйчүүд хөгжилд хандлагаас жендэр хөгжилд шинэ хандлагаар солигдож байна. Энэ шинэ хандлага нь голчлон жендэрийн харилцаанд суурилдаг бөгөөд эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг тэнцвэржүүлэхийг зорьдог байна. Жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх хэрэгшээ, шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байна.

Аливаа шийдвэр гаргахаас өмнө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд үзүүлэх үр нөлөөг дүгнэн шинжилж байх зорилгоор Засгийн газар болон бусад оролцогчид бүхий л хүрээний

хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслүүдэд жендэрийн чиг хандлагыг зохих ёсоор тусгахад чиглэсэн идэвхтэй бөгөөд мэдэгдэхүйш үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Бээжин хотноо 1995 онд хуралдсан Эмэгтэйчүүдийн байдлын тухай Дэлхийн IY бага хурлаас баталсан Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэмдэглэсэн байна.

Түүнчлэн, НҮБ-ын Нийгэм, эдийн засгийн зөвлөл (ECOSOC)-өөс 1997 онд зөвшөөрсөн тодорхойлолтоор **жендэрийн чиг хандлага** гэдэг нь аль ч салбар, аль ч түвшингийн төлөвлөлт, хууль тогтоомж болон бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагааны үр дүн эрэгтэй, эмэгтэйчүүдэд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх үйл явц юм. Энэ нь улс төр, нийгэм, эдийн засгийн салбарын бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх явцад эрэгтэй, эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг тусгах, түүний сургамж, туршлагыг нэгтгэх цогц стратеги юм. Энэхүү стратегийн туйлын зорилго нь жендэрийн тэгш байдлыг хангахад оршино.

Жендэрийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт нэгтгэх үйл явц нь хоёр талтай юм. Үүнд **нэгдүгээрт**, жендэрийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт нэгтгэх замаар хөгжлийн бодлогын чиглэлийг шинэчлэн томьёолох, **хоёрдугаарт**, жендэрийн чиг хандлагыг өнөөгийн практикт төв байгууллагын бодлого, хөтөлбөр санаачлах, төсөл батлах, судалгааны сэдэв сонгох, санхүүжүүлэх үйл явцад тусгах явдал юм.

Жендэрийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт нэгтгэх явдалыг зорилго бус үйл явц гэж үзвэл илүү оновчтой болох билээ. Энэ нь зөвхөн эмэгтэйчүүдийн оролцоог дээшлүүлэх төдийгүй, тэдний оролцох нөхцөл байдлыг харгалзан үздэг байна. Жендэрийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт нэгтгэх үйл явц нь дан ганц эмэгтэйчүүдийн хөгжлийн асуудалд анхаарал хандуулаад зогсдоггүй, бас үйл ажиллагаа, хүчин чармайлт бодлог.

Жендэрийн мэдрэмжтэй бодлого: Жендэрийн чиг хандлагыг хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдэд тусгаснаар жендэрийн мэдрэмжтэй болно. *Шийдвэр гаргагч, төлөвлөгч нарыг нөөц баялгаас тэгш хүртэх, түүнд хяналт тавих ажилд жендэрийн мэдрэмжтэйгээр хандуулах үйл явцыг жендэрийн мэдрэмжтэй бодлого гэнэ.*

Жендэрийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт тусгах үйл явцын үндсэн бүрдэл хэсэгт:

- ❖ Эрхэд суурисан бодлого, үйл ажиллагааны хүрээ
- ❖ Нэгдсэн ойлголтод хүрэх, нөлөөллийн ажлыг дэмжих
- ❖ Үр дүнгийн хариуцлага, шалгуур үзүүлэлт, үнэлгээ
- ❖ Зохион байгуулалтын үйл явц, журам, арга хэрэгсэл
- ❖ Бие даасан чадавхийг төлөвшүүлэх
- ❖ Оролцооны хандлага хамаарна.

Жендэрийн мэдрэмжтэй бодлого нь төлөвлөлтийн үйл ажиллагаагаар дамжин амьдрал практикт хэрэгждэг байна.

Жендэрийн мэдрэмж бүхий төлөвлөлт гэж бүх түвшингийн төлөвлөлтийн үйл явцад жендэрийн чиг хандлагыг цогц байдаар тусгах санаачилгыг хэлнэ.

Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлтийн ерөнхий загвар



Төлөвлөлтийн үйл явц нь 1) төлөвлөж буй асуудалтай холбогдолтой судалгаа явуулж зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлох; **2)** уул зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэрэгслийг тодорхойлох; **3)** гарах үр дүнг тооцоолох; **4)** хэрэгжилтийн явцыг болон эцсийн үр дүнг үнэлэх шалгууруудыг тодорхойлох; **5)** хөгжлийн стратеги, бодлого, хөтөлбөр, дэд хөтөлбөр зэрэг төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах гэсэн дэс дараалал бүхий хоорондоо нягт уялдсан 5 хэсгээс ихэвчлэн бүрддэг.

Жендерийн мэдрэмжтэй төлөвлөлтийг боловсруулахад баримтлах шаардлага нь:

- Шаардлагатай тоо баримт, мэдээлэл цуглуулах
- Дүн шинжилгээний зохистой арга, хэлбэр, бүтцийг сонгох
- Бүх түвшинд хүмүүсийн оролцоог хангах
- Засгийн газар, салбарын байгууллагын чадавхийг бэхжүүлж, шинэ ур чадвар эзэмшүүлэх
- Жендерийн мэдрэмж сул, жендерийн чиг хандлагын ойлголт бага, жендерээр ялгаварлах үзэл бодолтой төрийн ажилтнуудын үзэл бодлыг өөрчлөх явдал юм.

Жендер ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан үйлчлэлийн хүрээг Зураг 3-т дүрслэн үзүүлж болох юм. Жендерийн болон хөгжлийн үйл явц нь харьцангуй бие даасан байдаг боловч аль нэг нь дангаараа оршин тогтонох боломж багатай нь хэн бүхэнд ойлгомжтой билээ. Өөрөөр хэлбэл, эдгээр үйл явц нь зөвхөн тэдгээрийн хоорондын харилсан үйлчлэлийн нөлөөн дор тасралтгүй үргэлжлэх шинж чанарыг олж авдаг.

Үүнийг жендерийн үйл явц өөрөө жендерийн үр дүнг үүсгэж, улмаар хөгжлийн үйл явцыг өдөөж хөгжлийн үр дүн хүргэдэг төдийгүй хөгжлийн үр дүн нь эргээд жендерийн үйл явцад нөлөөлөх замаар тасралтгүй үргэлжлэх хөдөлгөөнийг нөхцөлдүүлдэг бодит байдлын тусгал хэмээн тайлбарлаж болно. (Зураг 3). Гэхдээ энэхүү тойрог маягийн үйл явцыг хурдасгах, эсвэл удаашруулах зэргээр өдөөж байдаг гол хүчин зүйл бол хүний

хөгжлийн тодорхой зорилго бүхий ухамсартай үйл ажиллагааны нэг илрэл болох хөгжлийн болон жендерийн мэдрэмжтэй боллогыг аливаа улс оронд боловсруулан хэрэгжүүлж байдагт оршино. Өөрөөр хэлбэл, уул үйл явцыг төлөвлөн удирдах явдал юм.

Жендер ба хөгжлийн уялдаа холбооны ерөнхий бүдүүвчийг Зураг 4-т хураангуйлан томьёолов. Жендер ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан үйлчлэл, хамаарлын энэхүү болит байдлын илэрхийлэл (бүдүүвч Зураг 3, Зураг 4)-ийн агуулгад задлан шинжилгээ хийж үзэхэд жендерийн мэдрэмжтэй боллогыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх чиглэлээр жендерийн үйл явцыг зөв залж жендерийн зохистой үр дүнг бүрдүүлж, улмаар жендерийн үр дүнг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оновчтой тусгах замаар хөгжлийн үйл явцыг зөв чиглүүлэн хөгжлийн хүсэн хүлээсэн үр дүнд хүргэж болно гэсэн дүгнэлт эд хүрч байна.

Жендерийн судалгаа, дүн шинжилгээний мэргэжилтэн нарын зөвлөснөөр жендерийн чиг хандлага, төлөв байдлыг бодлогоор дэмжиж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах дөрвөн алхмыг зайлшгүй мөрдөж ажиллах шаардлагатай. Үүнд:

Алхам 1: Хүйсээр ангилаан тоо баримтыг цуглуулах үйл явцыг тогтмолжуулж, тоон мэдээлэлд жендерийн дүн шинжилгээний аргыг нэвтрүүлсэн байна. Эдгээр мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр жендерийн ялгаа, тэгш бус байдал, түүнийг шийдвэрлэх болсон шалтгааныг гаргаж тавих, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд үндэслэсэн бодлого, төлөвлөгөөг боловсруулах, түүнчлэн, бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, төсвийн үр нөлөө эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн, ямар байдаар тусч байгааг судлан шинжлэх бололцоотой болно.

Алхам 2: Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль аль нь хөгжилд чухал нөлөөтэй байдаг. Харин гагшгүй эмэгтэйчүүд өөрсдийнхөө өмнөөс хүчтэй дуу хоолойгоор ярьж чаддаг, тэрхүү дуу хоолойг нь сонсдог, тодорхой арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлдэг болсон цагт л тэдний нөлөө хүчтэй мэдрэгдэл байна. Өөрөөр хэлбэл, бүх шатны шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдийн адил дэвшигүүлж, тэд хамтдаа жендерийн тэгш байдлыг хангах шийдвэрт нөлөө үзүүлдэг байна.

Алхам 3: Жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны агуулга, чиглэлийг тодорхойлно. Жендерийн тэгш байдлыг бодлогоор дамжуулан хэрэгжүүлэхэд хүйсээр ангилаан тоо баримт, статистик мэдээ, жендерийн дүн шинжилгээнд тулгуурлан үйл ажиллагааг төлөвлөхөөс гадна эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлсон байх шаардлагатай болно. Бодлого, хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаа нь маш тодорхой байхын сацуу түүнийг хэрэгжүүлэх, гардан хариуцах эзэн, төсөв, санхүү, хяналт-шинжилгээ явуулах үйл явц, түүнийг зохион байгуулах арга, хэлбэр, үнэлгээний үзүүлэлт зэргийг тодорхой заасан байна.

Алхам 4: Байгуулмагынч давхийг бэхжүүлэх башинэлэг гаргаражиллах шаардлагатай болно. Жендерийн чиг хандлагын стратегийг хэрэгжүүлэх, түүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангах явдал тухайн байгууллагын мэргэжилтнүүдийн үр чадвар, мэдлэг, туршлага, хариуцлага, идэвх санаачилгаас ихээхэн хамааралтай болно. Жендерийн тухай ойлголт, ухамсыг төлөвшүүлэх, хариуцлагыг ухааруулах, чадавхийг бэхжүүлэх явдал тийм ч хялбар зүйл биш юм. Жендерийн тэгш бус байдлыг байгууллага, салбарын хүрээнд арилгах явдал бол урт хугацааны өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц байdag ажээ.

Жендерийн чиг хандлагыг бодлогоод тусгаж буй байдал. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр болон олон улсын байгууллага, хандивлагч орнууд 1990-ээд он хүртэл бие даасан, салангид олон жижиг төслүүдийг санхүүжүүлж байсныг өөрчилж, өнөөдөр хөгжлийн хандлага бүхий ядуурлыг бууруулахад чиглэсэн тодорхой салбарын буюу үндэсний хэмжээний бодлогыг дэмжих болсон байна.

Мянганы хөгжлийн тунхаглал “Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх” зорилгыг тавьсан билээ. Энэ хүрээнд дэлхий дахинд бага ба дунд боловсрол дахь хүйсийн ялгааг 2005 он гэхэд арилгахыг зорьж, 2015 он гэхэд бүх шатны боловсрол дахь хүйсийн ялгааг арилгах зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ зорилтын шалгуур үзүүлэлтэд бага, дунд ба дээд боловсрол эзэмшиж байгаа хөвгүүд, охидын тооны харьцаа; бичиг үсэгт тайлагдсан 15-24 насны эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тооны харьцаа; Хөдөө аж ахуйгаас бусад салбарт цалинтай ажил эрхэлдэг хүн амын дотор эзлэх эмэгтэйчүүдийн хувь хэмжээ; үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэмжээг сонгож авсан байна.

НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр явуулсан “Монгол Улсад хүн ам, жендерийн хүчин зүйлсийг хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгасан байдлын үнэлгээ”-ний тайлангаас үзэхэд 30 гаруй бодлого, хөтөлбөрт үнэлгээ хийсэн байна. Судалгаагаар хүн ам, жендерийн хүчин зүйлсийг сүүлийн жилүүдэд боловсруулсан хөтөлбөрүүдийн 30 хувьд сайн, 47 хувьд дунд зэрэг, 23 хувьд хангалтгүй тусгасан гэсэн үнэлгээ гарчээ. Түүнчлэн, хүн ам, жендерийн хүчин зүйлсийг үндэсний хэмжээний бодлогын томоохон баримт бичгүүдэд харьцангуй сайн, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбарын төлөвлөлтийн баримт бичгүүдэд дунд зэрэг, аймаг, сумдын төлөвлөлтийн баримт бичгүүдэд хангалтгүй тусгасан гэж дүгнэжээ. Үүнтэй холбогдуулан хэлэхэд сүүлийн хоёр жилд боловсруулсан Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг болон Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц байдлын тухай үндэсний илтгэлд жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр багагүй хүчин чармайлт тавин ажиллаж байна.

Олон улсын байгууллагын сүүлийн үеийн судалгааны дүгнэлтээс үзэхэд жендерийн тэгш байдлыг хөгжүүлэх 3 зүйл бүхий стратегийг улс орнууд хэрэгжүүлэх нь зүйтэй гэдгийг зөвлөсөн байна. Үүнэд:

1. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш эрх, боломжийг хангах чиглэлээр байгууллагын бүтцийг шинэчлэн өөрчлөх (үндсэн эрх дэх тэгш байдлыг хангах, жендерээр ялгаварлан гадуурхах явдалыг таслан зогсоох нөхцлийг бүрдүүлэх, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хөгжүүлэх);

2. Хөрөнгө нөөцийг тэгш хуваарилах, тэгш оролцоог хангахад эдийн засгийн хөгжлийг чиглүүлэх;

3. Хөрөнгө нөөцийн эрх мэдэл, улс төрийн оролцоо дахь жендерийн амь бөхтэй ялгааг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх явдал гэж үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор дараах **дөрвөн чиглэлээр** идэвхитэй бодлого явуулах шаардлага урган гарч байна. Тухайлбал:

1. Хөрөнгө нөөц, орлого олох чадавхийг нэмэгдүүлэх;
2. Эмэгтэйчүүдийн гэрийн хөдөлмөр, ажил үүргийн ачааллыг багасгах;
3. Жендерийн зохистой нийгмийн хамгааллыг хөгжүүлэх;
4. Эмэгтэйчүүдийн улс төрийн дуу хоолой, идэвх, оролцоог нэмэгдүүлэх замаар жендерийн тэгш байдлыг нэмэгдүүлнэ гэж үздэг болжээ.

Жендерийн чиг хандлагыг бодлого, хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлснээр нийгмийн хөгжлийг жендерийн агуулгатай болгон, энэхүү жендерийн мэдрэмжтэй бодлогын үр дүнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд эрхээ эдлэх, хөрөнгө нөөц өзэмших, санал боллоо илэрхийлэх, дуу хоолойгоо сонсгох замаар жендерийн тэгш байдалд хүрэх боломж нэмэгдэх ач холбогдолтой юм.

Хавсралт 1

Дэлхийн хүний хөгжлийн илтгэлийн жил бүрийн томъёолол

Он	Илтгэлийн хураангуй сэдэв
1990	Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр
1991	Хүний хөгжлийн санхүүжилт
1992	Хүний хөгжлийн дэлхийн чиг хандлага
1993	Хүн амын оролцоо
1994	Хүний аюулгүй байдлын шинэ чиг хандлага
1995	Жендер ба хүний хөгжил
1996	Эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил
1997	Ядуурлыг арилгахын төлөө хүний хөгжил
1998	Хүний хөгжлийн төлөө хэрэглээ
1999	Хүмүүнлэг дүр төрхтэй даяршлал
2000	Хүний хөгжил ба хүний эрх
2001	Хүний хөгжлийн төлөө шинэ технологи нэвтрүүлэх
2002	Даян дэлхийд ардчиллыг гүнзгийрүүлэх
2003	Мянганы хөгжлийн зорилтууд: Хүний ядуурлыг цэглэх улс үндэстний тэмцэл
2004	Даян дэлхийн эдүгээгийн олон янзын соёлын эрх чөлөө
2005	Олон улсын хамтын ажиллагаа ээдрэээт замын бэлчирт: Тэгш бус ертөнц дэх худалдаа, зээл тусламж, аюулгүй байдал
2006	Усны дутагдлын төлөө юу хийх вэ: Эрх мэдэл, ядуурал ба даян дэлхийн усны нөөцийн хомсдол

Хавсралт 2

Монгол Улсын хүний хөгжлийн индексийн харьцуулалт

	Илтгэлд хамрагдсан орны тоо	Монгол Улсын чансаа	Монголын хүний хөгжлийн индекс	Дэлхийн дундаж индекс	Хөгжиж байгаа орнуудын дундаж индекс
1990	130	70	0.737	-	-
1991	160	87	0.596	-	-
1992	160	88	0.574	-	-
1993	160	100	0.578	-	-
1994	173	102	0.607	-	-
1995	174	110	0.604	0.759	0.570
1996	174	113	0.578	0.746	0.563
1997	175	101	0.661	0.764	0.576
1998	174	101	0.669	0.772	0.586
1999	174	119	0.618	0.706	0.637
2000	174	117	0.628	0.712	0.602
2001	173	116	0.569	0.716	0.549
2002	173	113	0.655	0.722	0.554
2003	175	117	0.661	0.722	0.561
2004	177	117	0.668	0.729	0.557
2005	177	114	0.679	0.741	0.593
2006	177	116	0.691	0.741	0.556

Эх сурвалж: НҮБХХ-ийн хүний хөгжлийн илтгэл

Хүний хөгжлийн индексийг тооцдог дэлхийн аргачлалын тухай

НҮБХХ-өөс жил бүр тогтмол эрхлэн гаргадаг “Хүний хөгжлийн илтгэл”-д орон бүрийн хүний хөгжлийн индексийг тооцоходоо дараах аргачлалыг баримталдаг.

Хүний хөгжлийн индексийг тооцоход хамрагдлаг үзүүлэлт нэг бүрээр дээд, доод тогтмол хэмжээг тогтоодог байна:

Дундаж наслалтын доод хэмжээ 25 жил, дээд хэмжээ 85 жил

Насанд хүрэгчдийн боловсролын түвшин 0-100 хувь

Боловсролд хамрагдалтын хувь 0-100 хувь

Нэг хүнд ногдох бодит ΔНБ-ний доод хэмжээ 100 доллар, дээд хэмжээ 40000 доллар

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 1998 онд эрхлэн гаргасан “Хүний хөгжлийн илтгэл”-д Монгол Улсын хүний хөгжлийн индексийг 1995 оны байдлаар тооцсоныг үзүүлбэл:

Дундаж наслалт (1995 оны байдлаар) -64.8

Насанд хүрэгчдийн боловсролын түвшин -82.9

Анхан, дунд, дээд шатны боловсролд хамрагдсан байдал -53

Нэг хүнд ногдох бодит ΔНБ -3916

Дундаж наслалтын индекс $(64.8-25):(85-25)=0.663$

Насанд хүрэгчдийн боловсролын түвшингийн индекс $(82.9-0):(100-0)=0.829$

Анхан, дунд, дээд шатны боловсролд хамрагдалтын индекс

$(2-0.829)+(1-0.53):3=0.729$

Нэг хүнд ногдох зохицуулсан бодит ΔНБ-ний индекс

Орлогын индексийг тооцох нь нэлээд төвөгтэй байдаг байна. Монгол Улсын нэг хүнд ногдох 1995 оны бодит ΔНБ нь 1995 оны дэлхийн хэмжээний дундаж орлогоос (1995 оны хувьд орлогын доод хэмжээ нь 5990 доллар байжээ) доогуур байгаа учраас түүнийг зохицуулан өөрчлөх шаардлагагүй юм. Хэрэв нэг хүнд ногдох бодит ΔНБ нь энэхүү 5990 доллараас их байх нөхцөл тусгай томьёо ашиглан уг орлогыг зохицуулан өөрчилдөг байна. Түүнчлэн тусгай томьёо ашиглан тухайн жилд (1995 оны хувьд орлогын дээд хэмжээ нь 6311 доллар байжээ) баримтлах орлогын дээд хэмжээг тооцон гаргадаг. Дэлхийн хэмжээний дундаж орлогын дээд, доод хэмжээг НҮБХХ-өөс жил бүр өөрчлөн гаргадаг болохоор нэг хүнд ногдох зохицуулсан бодит ΔНБ-ний индексийг тухайн орны хувьд тооцоход хүндэрэл учруулж болох талтай юм. Тухайлбал, дэлхийн хэмжээний дундаж орлогын доод хэмжээг 1996 оны “Хүний хөгжлийн илтгэл”-д 5711 доллар, 1997 оны илтгэлд 5835 доллартай тус тус тэнцүү гэж тодорхойлсон байна. Ер нь энэхүү дундаж орлогыг хэрхэн яж тооцдог үндэслэл, аргачлалыг нарийвчлан судалж мэдэх нь чухал юм. $\text{Монгол}=(3916-100):(6311-100)=0.614$

Хүний хөгжлийн индексийг тооцоходоо дундаж наслалтын индекс, боловсролын индекс, нэг хүнд ногдох бодит ΔНБ-ний индексийн нийлбэрийг гуравт хувааж гаргана.

Дундаж наслалтын индекс -0.663

Боловсролын индекс -0.729

Нэг хүнд ногдох зохицуулсан бодит ΔНБ - 0.614


$\Sigma=(0.663+0.729+0.614):3=0.669$

Хавсралт 4

Хүн ам ба хөгжлийн уялдааны өрөнхий загвар


Зураг 1

Хүн ам ба хөгжлийн уялдаа холбооны тойм бүдүүвч



Зураг 2

Хүн ам ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан хамаарлын бүдүүвч



**Эмэгтэйчүүд хөгжилд болон жендер хөгжилд
хандлагын ялгаатай байдал**

	Эмэгтэйчүүд хөгжилд хандлага	Жендер хөгжилд хандлага
Анхаарах асуудал	Эмэгтэйчүүд	Жендерийн харилцаа
Тулгамдсан асуудал	Хөгжлийн үйл явц дахь эмэгтэйчүүдийнхязгаар-лагдмал оролцоо;	Эрх тэгш хөгжлийг хангахад тулгарч буй жендерийн тэгш бус харилцаанаас үүдэлтэй бэрхшээлүүд;
Зорилго	Хөгжлийн үйл явцад эмэгтэйчүүдийг идэвхитэй, үр дүнтэй татан оролцуулах, эмэгтэйчүүдийн бүтээлч үйл ажиллагааны чадавхийг дэмжих;	Хөгжилд тэгш, тогтвортой оролцох; Жендерийн хандлагыг бодлого, үйл ажиллагаанд тусгах; Эрх мэдлийн зохистой харилцааг төлөвшүүлэх: <ul style="list-style-type: none"> - Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хоорондын эрх мэдлийн тэнцвэрт байдлын ойлголт; - Хөгжлийн үйл явцын үр дүнг тэгш хүртэх боломж; - Шийдвэр гаргах үйл явцад эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш оролцооны үнэлэмжийг тогтоох;
Шийдвэр	Хөгжлийн өнөөгийн үйл явцад эмэгтэйчүүдийг идэвхитэй татан оролцуулах;	Өнөөгийн жендерийн тэгш бус харилцааг өөрчлөн шинэчлэхэд эмэгтэйчүүд болон эрх, боломж нь хязгаарлагдмал бусад хүмүүсийг чадваржуулах;
Стратеги	Эмэгтэйчүүдийн бүтээлч үйл ажиллагаа болон орлогыг нэмэгдүүлэх; Эмэгтэйчүүдийн өрх гэрээхэтлэх чадавхийг дээшлүүлэх; Хөтөлбөр, тэслүүдэд эмэгтэйчүүдийн оролцоог хангах;	Салбар дундын олон талт стратеги; Стратегийн сонирхол болон бодит хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах; Эмэгтэй, эрэгтэйчүүдийн эрх, үүрэг, хариуцлагын мэдлэг, чадварыг дээшлүүлэх чиглэлээр тэдний харилцан зөвшилцэх үр чадварыг нэмэгдүүлэх; Эмэгтэйчүүдийн өөрийгөө жолоодох, цагаа зохицуулах, үйл ажиллагаагаа хянах чадамжийг дээшлүүлэх;
Шүүмж	Эмэгтэйчүүдийн олон талт үүргийг төдийлөн оновчтой томъёолж чадаагүй; Эмэгтэйчүүдийн цаг ашиглалт болон хөдөлмөр оролцооны уян хатан байдлыг тодорхойлон томъёолж чадаагүй; Урт хугацааны зорилт, үр дүн, үзүүлэлтүүд нь алс хэтдээ тогтвортой байх магадлалтай ч хэрэгжүүлэхэд нэлээд төвөгтэй;	

Хавсралт 6

Жендер ба хөгжлийн уялдааны өрөнхий загвар


Зураг 3

Жендер ба хөгжлийн уялдаа холбооны тойм бүдүүвч

Хөгжлийн бодлого	Жендер ба хөгжлийн уялдаа холбоо	Хөгжлийн зорилго
Хөгжлийн бодлого (X)	<pre> graph TD X((X)) --> A[Жендерийн үр дүн] A <--> B[Жендерийн үйл явц] B <--> C[Хөгжлийн үйл явц] Y((Y)) --> B </pre>	Жендерийн тэгш, тогтвортой оролцоог хангах, эрх мэдлийн зохистой харилцааг төлөвшүүлэх
Жендерийн мэдрэмжтэй бодлого (Y)		

Зураг 4

Жендер ба хөгжлийн уялдаа холбоо, харилсан хамаарлын бүдүүвч



**Байгууллага, зохион байгуулалтын бүтцэд
жендэрийн тэгш байдлыг хангах бодлогыг
хэрэгжүүлэх дэс дараалал**

Байгууллага, зохион байгуулалтын бүтцэд жендэрийн тэгш байдлыг хангах, түүнийг шийдвэрлэх арга зам	
<i>Байгууллага тус бурийн хэрэгцээ, зорилго, чиглэл өөр боловч жендэрийн тэгш байдлыг хангах бүрдэл хэсгүүд ижил төстэй байдаг.</i>	
Жендэрийн мэдрэмж бүхий бодлогыг тунхаглах	<p>Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг (эрхэм зорилгыг) тунхагласнаар тухайн байгууллага, салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаандаа жендэрийн чиг хандлагыг тусгах үүргийг хүлээх болсны баталгаа болно.</p> <p>Энэхүү тунхаглал нь юуг эрхэмлэх, ямар зарчим баримтлахыг тодорхойлж өгөх төдийгүй байгууллагын дотоод бодлого, хөтөлбөр, төлөвлөлтийн үйл явцыг чиглүүлэх удирдамж, стратеги болох бөгөөд зорилгыг хэрэгжүүлэх арга замыг томьёолж өгнө.</p>
Аливаа байгууллагын дээд шатны удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага	<p>Дээд шатны удирдлага нь жендэрийн мэдрэмжтэй бодлогыг бүрэн хүлээн зөвшөөрөх нь тухайн байгууллагыг бодитойгоор өөрчилж, шинэчлэх явцыг үр дүнд хүргэнэ.</p>
Жендэрийн асуудал хариуцсан газар, хэлтсийн ба мэргэжилтний хүлээх үүрэг, хариуцлага	<p>Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эсвэл жендэрийн асуудал хариуцсан газар, хэлтэс, тасаг жендэрийн чиглэлээр явуулж буй практик үйл ажиллагааг хянан үзэх, жендэрийн сургалт зохион явуулах, улмаар хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Ер нь газар, хэлтсүүдэд жендэрийн асуудал хариуцсан орон тооны ажилтан ажиллуулах нь илүү үр дүнтэй байдаг ажээ.</p>